

Бүх нийтийн боловсрол (БНБ)-ын
Хяналт үнэлгээний Дэлхийн Тайлан

2

0


0

9

Бүх нийтийн боловсролд

Хураангуй

Тэгш бус байдлыг арилгах нь:
Яагаад удирдлагын асуудал
чухал вэ?



Бүх нийтийн боловсрол (БНБ)-ын
Хяналт үнэлгээний Дэлхийн Тайлан

Хураангуй

Тэгш бус байдлыг арилгах нь:
Яагаад удирдлагын асуудал чухал вэ?

Энэхүү Тайлан нь олон улсын хамтын нийгэмлэгийн нэрийн өмнөөс ЮНЕСКО-гийн захиалгаар хэвлэн гаргаж байгаа бие даасан бүтээл бөгөөд Тайлан бэлтгэсэн багийн гишүүд болон улс орнуудын засгийн газар, байгууллага, агентлаг, бусад олон мэргэжилтэн, хүмүүсийн хамтын хүчин чармайлтын үр дүн билээ.

Энэхүү номонд хэрэглэсэн нэрс, нэр томъёо болон танилцуулж буй материалууд нь аливаа улс орон, газар нутаг, хот суурин, тэдгээрийн удирдлагын эрхзүйн байдал, эсвэл тэдгээрийн хил хязгаарын зааглалд хамааралтай асуудлаар ЮНЕСКО-гийн оролцооны талаар ямар нэг үзэл бодлыг илэрхийлээгүй болно.

БНБ-ын Хяналт үнэлгээний Дэлхийн Тайланг боловсруулж бэлтгэх Баг нь энэхүү хураангуй тайланд орсон баримт материалуудын сонголт болон танилцуулга бичилт, мөн энд өгүүлсэн ЮНЕСКО-гийнхтай заавал адил байх албагүй санал, дүгнэлтүүдийг хариуцах бөгөөд тэдгээрийн төлөө ЮНЕСКО ямар нэг үүрэг хариуцлага хүлээхгүй.

БНБ-ын Хяналт үнэлгээний Дэлхийн Тайланг бэлтгэн гаргасан баг

**Захирал
Кевин Уоткинз**

Самер Аль-Самаррай, Николь Белла, Аарон Бенавот, Филип-Марк Буа-Льебниц, Мариела Буономо, Сухад Варен, Синтия Гутман, Дидерик де Йонг, Фадила Кайо, Алисон Клейсон, Лейла Лупис, Изабелла Меркович, Патрик Монжурид, Клодин Мукизва, Ульрика Пеплер-Барри, Паула Разкин, Паулина Роуз, Анна Хаас, Джулия Хайсс, Кейт Хинчлиф.

Энэхүү тайлангийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл дараахь хаягаар хандаарай:

The Director
EFA Global Monitoring Report Team
c/o UNESCO
7, place de Fontenoy, 75352 Paris 07 SP, France
e-mail: efareport@unesco.org
Tel.: +33 1 45 68 10 36
Fax: +33 1 45 68 56 41
www.efareport.unesco.org

БНБ-ын Хяналт үнэлгээний Дэлхийн өмнөх Тайлангууд
2008 он. БНБ 2015 он гэхэд: Бид түүнд хүрч чадах уу?
2007 он. Найдвартай, бөх бат үндэс суурь: бага насны хүүхдийн халамж хүмүүжил, боловсрол
2006 он. Бичиг үсгийн боловсрол амьдралын зайлшгүй хэрэгцээ
2005 он. Бүх нийтийн боловсрол болон чанарын шаардлага
2003/4 он. Жендер ба БНБ: тэгш байдалд хүрэх нь
2002 он. БНБ: Дэлхий аян замдаа гарсан уу?

2008 онд НҮБ-ын Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны байгууллагаас хэвлэн гаргав.
7, Place de Fontenoy, 75352 Paris 07 SP, France
График дизайн: Силвайн Баеинз
Хэвлэлийн эх бэлтгэл: Силвайн Баеинз
Анхны хэвлэл: 2008 он

Англи хэлнээс орчуулсан:

Хянан тохиолдуулсан:

Хянан зөвлөсөн:

Болормаа Самд.
Самдан Ц.
Уртнасан Н.
Уртнасан Н.
Цолмон А.
Болормаа Самб.

Өмнөх үг

Шинэ зууны босгон дээр, дэлхийн олонхи улс орон 2015 он гэхэд бүх нийтийн боловсролын зорилтод хүрнэ гэсэн үүрэг амлалт авч байхдаа, БНБ-ын зорилтод хүрэх нь цаг үеийн шалгуур бэрхшээлүүдтэй тулгарах болно гэдгийг ойлгож байсан билээ.

Тэд үнэхээр өөрчлөлт хийж байна. Бүх нийтээр бага боловсрол эзэмших, жендерийн тэгш байдлыг хангах чиглэлээр дэлхийн нэн ядуу олон орон бахдам амжилтанд хүрлээ. Гэхдээ бидний туулах зам одоо ч хол байна. Олон оронд энэхүү ахиц дэвшил хэтэрхий удаан бөгөөд жигд бус байна. Зарим гол зорилтуудад хүрч чадахгүй байх аюул өнөөдөр бидэнд тодорхой болж байна. Боловсрол нь хүний үндсэн эрх төдийгүй эх, хүүхдийн эрүүл мэндийг хамгаалах, хүмүүсийн орлогыг нэмэгдүүлэх, байгаль орчны тогтвортой байдал, эдийн засгийн өсөлтийг хангах болон Мянганы хөгжлийн зорилтод хүрэхэд шийдвэрлэх ач холбогдолтой учраас энэ аюулыг гэтлэн давах явдал амин чухал асуудал болж байна.

БНБ-ын Няналт үнэлгээний Дэлхийн Тайлангийн энэхүү 7 дахь хэвлэл нь Засгийн газар, хандивлагч байгууллагууд болон олон улсын хамтын нийгэмлэгт дохио сэрэмжлүүлэг болж байгаа юм. Одоогийн явц, байдал хэвээр үргэлжилбэл, 2015 он гэхэд бүх нийтэд бага боловсрол эзэмшүүлэх зорилго хэрэгжих боломжгүй болно. Маш олон хүүхэд чанаргүй боловсрол эзэмшиж, бичиг үсгийн болон тоо бодох энгийн чадвар эзэмшихгүй сургуулиа орхиж байна. Эцэст нь, хөрөнгө мөнгө, хүйс, оршин суугаа газар нутаг, гарал угсаа зэрэг тэгш байдлаас үүссэн бусад бэрхшээл нь боловсролын салбарын хөгжил дэвшилд учирч байгаа гол саад болж байна. Хэрэв дэлхий нийтээр БНБ-ыг онцгой анхааръя гэвэл тэгш бус байдлыг арилгахад улам бүр илүү анхаарал хандуулах ёстой.

Энэхүү Тайланд тэгш бус байдлыг арилгахын тулд БНБ-ын зорилго, хөтөлбөрийн гол цөмд адил тэгш шударга байх асуудлыг тавих шаардлагатай гэдгийг батлан харуулж байна. Санхүүжилт болон удирдлагын өөрчлөлт шинэчлэлт ч чухал үүрэг гүйцэтгэх учиртай. Хөгжиж буй орнууд иргэддээ суурь боловсрол олгоход хангалттай төсөв мөнгө зарцуулж чадахгүй байгаа бөгөөд хандивлагч орнууд амлалт, үүргээ биелүүлэхгүй байна. Боловсролд зориулах тусламжийг хязгаарлаж, зогсоож байгаа нь бага орлоготой олон орны боловсролын хэтийн төлөв байдлыг ихээхэн түгшүүртэй болгож байна. БНБ-д хүрэх зорилгыг хангахын тулд энэ байдлыг өөрчлөх зайлшгүй шаардлагатай нь илт тодорхой. Гэхдээ адил тэгш шударга байдлыг бий болгох асуудлыг харгалзахгүйгээр санхүүжилтыг нэмэгдүүлэх нь хамгийн эмзэг, ядуу дорой бүлгүүдэд төдийлөн ашиг тусаа өгөхгүй. Боловсролын салбарын бодлогод хүн амын ядуу давхрагын эрх ашгийн үүднээс хандах нь дэлхийн хэмжээнд сургууль завсардсан хүүхдүүд болон 776 сая бичиг үсэг үл мэдэгч насанд хүрэгчдийн хувьд учир утга бүхий зорилго дэвшүүлэх гол учир шалтгаан юм.

Тайланд хөгжлийн бэрхшээлийг даван туулах, боловсролын хүртээмжийг нэмэгдүүлэх, чанарыг сайжруулах, оролцоо болон хариуцлагыг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн төрийн бодлого, удирдлагын шинэчлэлт өөрчлөлтийн зарим асуудлыг танилцуулсан байна.

2008 оны 9-р сард болсон Мянганы хөгжлийн зорилтын талаарх НҮБ-ын дээд хэмжээний уулзалт дээр дэлхийн удирдагчид болон өргөн хүрээний түншүүд ядууралтай тэмцэх зорилгод хүрэхэд боловсролын үүрэг ролийг онцгойлон үзэж, санхүүгийн нэмэлт эх үүсвэрүүдийг гаргах амлалт авч байсан билээ. Боловсрол дэлхийн бүх хүүхдэд хүрч, бодитой зүйл болохын тулд Засгийн газрууд болон хандивлагч орнууд энэхүү үүрэг амлалтаасаа буцаж няцахгүй байх нь чухал юм.

БНБ-ын зорилгод хүрэхэд жил бүрийн ололт амжилт, ахиц дэвшлийг дүгнэн тодорхойлж байдаг энэхүү Тайлан дэлхийн өнөөгийн боловсролын байдлыг бүх талаас нь тоймлон үзүүлж байна. Тайлан нь үндэсний болон олон улсын бодлого боловсруулагчдад бүх хүүхэд, залуучууд, насанд хүрэгчдэд сурч боловсрох адил тэгш нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн асуудлуудад хийсэн цогц дүн шинжилгээ, сургамж, туршлага, зөвлөмж зэргийг толилуулж байгаа юм. Бид 2015 он хүрэх хугацааныхаа тэн хагасаас илүүг ардаа орхилоо. Дүн шинжилгээ оношлогоо тодорхой байна. Боловсролын тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхэд үр дүн бүхий бодлого стратеги явуулах л үлдлээ. БНБ-ын зорилгод хүрэх хүчин чармайлтыг зохицуулах үүрэг бүхий НҮБ-ын тэргүүлэх байгууллага болохынхоо хувьд ЮНЕСКО 2015 он хүртэлх боловсролын үйл явцыг зөв залж чиглүүлэхийн тулд энэхүү жил бүрийн нэр хүндтэй Тайланг хэвлэн гаргаж, мэдээлэл хийх болон боловсролын бодлогод нөлөөлөх зорилготой ажиллаж байна.



Койчиро Мацуура

2009 оны БНБ-ын Дэлхийн Тайлангийн товч агуулга

Товч агуулга

- Олон улсын хамтын нийгэмлэг 2000 онд Дакар хотноо үүрэг амлалт авсан тэр цагаас хойш БНБ-ын зарим асуудлаар тэмдэглүүштэй ололтууд гарсаар байна. Дэлхийн нэн ядуу зарим оронд улс төрийн манлайлал болон практик үйл ажиллагаа нь өөрчлөлт хийж байгааг харуулж чадлаа. Гэтэл хуучирсан хэвшмэл арга нь Дакарын зорилгыг бүтэлгүйтүүлэхэд хүргэж болно. Хүүхдүүдийг бага болон дараа шатны боловсролд хамруулахын тулд илүү тууштай хүчин чармайлт гаргах шаардлагатай байна. Түүнчлэн боловсролын чанар, сурлагын амжилтанд илүү анхаарах хэрэгтэй.
- Орлогын түвшин, хүйс, оршин суугаа газар нутгийн байршил, гарал угсаа, хэл, хөгжлийн бэрхшээл болон бусад хүчин зүйлтэй холбоотойгоор буй болж байгаа тэгш бус байдлыг арилгах талаарх Засгийн газрын идэвхгүй үйл ажиллагаа нь БНБ-ын зорилгыг амжилттай хэрэгжүүлэхэд саад болж байна. Тэгш бус байдлыг арилгахын тулд Засгийн газрууд бодлогын хүрээнд үр дүнтэй өөрчлөлт шинэчлэлт хийхгүй бол БНБ-д хүрэх амлалт бүтэлгүйтэхэд хүрнэ.
- Сайн засаглал нь боловсролын салбар дахь хариуцлагыг бэхжүүлж, оролцоог нэмэгдүүлэх болон тэгш бус байдалтай тэмцэхэд чухал дэмжлэг болох учиртай. Гэтэл засаглалын шинэчлэлийн өнөөгийн хандлага нь тэгш байдалд зохих ёсоор анхаарал хандуулахгүй байна.

БНБ-д хүрэх 6 зорилтын хэрэгжилтийн явц

1-р зорилт - Бага насны хүүхдийн халамж хүмүүжил, боловсрол

- Хоол тэжээлийн хомсдол нь 5 хүртэлх насны 3 хүүхдийн нэгийг хамарч, тэдний сурах чадварыг бууруулж байгаа нь дэлхий нийтэд учирч байгаа гамшиг юм. Ялангуяа Өмнөд Сахар, Өмнөд Азид хүүхдийн хоол хүнс болон эрүүл мэндийн асуудлыг шийдвэрлэх ажил удаашралтай байгаа нь бүх нийтээр бага боловсролд хүрэх зорилтыг хэрэгжүүлэхэд саад болж байна.
 - Сургуулийн өмнөх насны хүүхдүүдийн аж байдлын өсөлтийн үзүүлэлтүүд санаа зовоож байна. Хэрэв өнөөгийн энэ чиг хандлага хэвээр үргэлжилбэл
- Мянганы хөгжлийн зорилтод тусгагдсан хүүхдийн эндэгдэл болон хоол тэжээлийн хомсдолтой холбоотой зорилтууд хэрэгжих боломжгүй болно.
- Дэлхий хамгийн баян болон хамгийн ядуу хүүхдүүдийн хооронд хоол тэжээлийн хангамжаар ялгагдах байдал үргэлжилсээр байна. 2006 онд сургуулийн өмнөх боловсролд хамрагдагсдын тоо хөгжингүй орнуудад дунджаар 79%, хөгжиж буй орнуудад 36% байсан бол Өмнөд Сахарт 14%-иас ч доогуур байна.
 - Тэгш бус байдал нь улс орнуудын дотор их байгаа бөгөөд ялангуяа хамгийн баян, хамгийн ядуу хүүхдүүдийн хооронд бүр ч тод томруун харагдаж байна. Зарим оронд хамгийн

баян өрхийн 20 хувийн хүүхдүүд гэхэд хамгийн ядуу гэр бүлийн 20 хувийн хүүхдүүдээс даруй 5 дахин илүү сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамрагдаж байна.

Зорилт 2 - Бүх нийтийн бага боловсрол

- Дакарын чуулган болсон цагаас хойш, хөгжиж буй орнуудад хамран сургалтын цэвэр жин тасралтгүй өссөөр байна. Өмнөд Сахарын орнуудад энэ хэмжээ 1999-2006 оны хооронд 54%-иас 70% болтлоо өссөн нь Дакарын чуулганы өмнөх 10 жилтэй харьцуулахад даруй 6 дахин их байна. Өмнөд болон Баруун Азид 75%-иас 86% болтлоо өссөн нь бахдууштай юм.
- 2006 онд сургуульд суралцдаггүй хүүхдүүдийн тоо ойролцоогоор 75 саяд (үүний 55% нь охид) хүрсэн ба тэдний бараг тэн хагас нь Өмнөд Сахарын орнуудад ногдож байна. Одоогийн төлөв байдлаас үзэхэд бүх нийтийг бага боловсролд хамруулахыг зорьж байгаа ч гэсэн 2015 он гэхэд сая сая хүүхэд урьдын адил сургуулиас гадуур үлдэхээр харагдаж байна. 2006 онд 134 оронд хийсэн судалгаа хүүхдүүдийн 2/3 орчим нь сургууль завсардсаныг харуулсан бөгөөд эдгээр оронд 2015 он гэхэд 29 орчим сая хүүхэд сургуулийн гадна үлдэхээр байна гэж урьдчилсан байдлаар тодорхойлсон байна.
- Ядуу айл өрхийн, хөдөөгийн тарчиг амьдралтай нутгийн болон эмзэг бүлгийн хүүхдүүд чанартай боловсрол эзэмшихэд томоохон бэрхшээлтэй учирч байна. Ихэнх улс оронд хамгийн баян гэр бүлийн хүүхдүүдийн 20% нь бага боловсролд хэдийнээ хамрагдсан байхад, хамгийн ядуу гэр бүлийн хүүхдүүдийн 20% нь түүнд хүрэхэд хол байна.
- Бага боловсролын чиг хандлага нь төрийн бодлогоос хамаарна. Этиоп, Танзаны Нэгдсэн Бүгд Найрамдах Улс сургалтын төлбөрөөс чөлөөлөх, хүрэлцээ муу газруудад сургууль байгуулах, багш нарын тоог

нэмэгдүүлэх зэрэгт чиглэсэн төрийн бодлогын үр дүнд ядуу давхрагыг хамруулан боловсролын хүртээмжийг нэмэгдүүлж чадсанаараа гайхалтай амжилтыг гаргаж байна. Нигер, Пакистан зэрэг улсын боловсролын сул удирдлага нь хөгжил дэвшлийг ухрааж, сая сая хүүхдийг сургуулиас гадуур байлгасаар байна.

- 2006 онд дэлхий нийтээр ойролцоогоор 513 сая хүүхэд буюу сургуулийн насны хүүхдүүдийн 58% нь дунд сургуульд хамрагдсан нь 1999 онтой харьцуулахад ойролцоогоор 76 саяар өссөн байна. Ийм амжилтанд хүрсэн хэдий ч, дэлхийн ихэнх хүүхдүүд сургуульд хамрагдах боломжоор хязгаарлагдмал хэвээр байна. Өмнөд Сахарын орнуудад дунд сургуулийн насны хүүхдүүдийн 75% нь энэ эрхээ эдэлж чадахгүй байна.

Зорилт 3 - Залуучууд болон насанд хүрэгчдийн насан туршийн боловсролын хэрэгцээ шаардлагыг хангах нь

- Залуучууд болон насанд хүрэгчдийн сурч боловсрох хэрэгцээ шаардлагыг хангах чиглэлд улс орнуудын боловсролын бодлого тэргүүлэх ач холбогдол өгөхгүй байна. Залуучууд, насанд хүрэгчдийн насан туршдаа сурч боловсрох хэрэгцээг хангахад улс төрийн илүү хүчтэй бодлого, төрийн томоохон хөрөнгө оруулалт хийх хэрэгтэй. Түүнчлэн хяналт үнэлгээг үр дүнтэй явуулахад илүү тодорхой агуулга чиглэл, үнэн бодит тоо баримт шаардлагатай.

Зорилт 4 - Насанд хүрэгчдийн бичиг үсгийн боловсрол

- Дэлхий дээр ойролцоогоор насанд хүрсэн хүн амын 16% буюу 776 сая хүн бичиг үсгийн анхан шатны мэдлэггүй байна. Үүний 2/3 орчим нь эмэгтэйчүүд. Сүүлийн жилүүдэд ихэнх оронд тодорхой амжилт гараагүй байна. Энэ

хандлага цаашид үргэлжилбэл, 2015 он гэхэд бичиг үсгийн боловсролгүй насанд хүрэгчдийн тоо 700 гаруй саяад хүрэх тооцоо гарч байна.

- 1985-1994 оны хооронд болон 2000-2006 онд насанд хүрэгчдийн бичиг үсгийн боловсролын түвшин дэлхий хэмжээнд 76%-иас 84% болж нэмэгдэж байсан байна. Хэдий тийм ч 45 оронд насанд хүрэгчдийн бичиг үсгийн боловсролын түвшин хөгжиж байгаа орнуудын дундаж үзүүлэлт 79%-иас доогуур байна. Тэдгээрийн ихэнх нь Өмнөд Сахарын орнууд, Өмнөд болон Баруун Азийн орнууд юм. Эдгээр орнуудын ихэнх нь 2015 он гэхэд насанд хүрэгчдийн бичиг үсэг үл мэдэх явдлыг арилгана гэсэн зорилтоо хэрэгжүүлж чадахааргүй байна. Тэдгээрийн 19 оронд нь бичиг үсгийн боловсролын түвшин 55%-иас доогуур байна.
- Ядуурал болон бусад хүчин зүйлээс хамааран улс орнуудын бичиг үсгийн боловсролын түвшин ялгавартай байдаг. Насанд хүрэгчдийн бичиг үсгийн боловсролын ерөнхий түвшин доогуурт тооцогддог Өмнөд Сахарын 7 оронд нэн ядуу болоод баян чинээлэг хүмүүсийн хоорондын бичиг үсгийн боловсролын ялгаа 40%-иас илүү байна.

Зорилт 5 - Жендерийн асуудал

- 176 орны 2006 оны статистик үзүүлэлтээс үзэхэд бага, дунд боловсролын түвшинд 59 орон хангаж чадсан нь 1999 оныхоос даруй 20 орноор нэмэгдсэн байна. Зөвхөн бага боловсролын хувьд эдгээр орнуудын 2/3 орчим нь энэхүү амжилтанд хүрсэн. Гэтэл, Өмнөд Сахарын орнууд, Өмнөд болон Баруун Ази, Арабын ихэнх улс орон зорилгодоо хүрсэнгүй. Дэлхийн улс орнуудын дөнгөж 37% нь дунд сургуулийн түвшинд жендерийн тэгш байдлыг хангаж чаджээ.
- Дэлхий даяар, ялангуяа хөгжилтэй бүс нутгууд болон Карибын тэнгис, Номхон далайн орнуудад эмэгтэйчүүд

эрэгтэйчүүдээс илүүтэйгээр дээд боловсролд хамрагдах хандлагатай байна.

- Ядуурал болон нийгмийн бусад эмзэг асуудлууд жендерийн тэгш бус байдлыг улам лавшруулж байна. Жишээ нь, Малид чинээлэг гэр бүлээс гаралтай охидуудтай харьцуулахад ядуу айлын охидууд бага сургуульд хамрагдалт 4 дахин, дунд сургуульд 8 дахин бага байна.
- Охидууд сургуульд хамрагдлаа гэхэд, багш нарын хандах хандлага, хүйсээр ялгаварлах үзлийг дэмжсэн сурах бичгүүд хэрэглэж байгаа зэрэг нь тэд нарт сурч боловсроход нь ямагт хүндрэл учруулж байна. Сургууль дээрх эдгээр хүчин зүйлс нь сургуулийн үйл ажиллагаанд нөлөөлж буй хүйсээр ялгаварлан гадуурхахтай холбоотой нийгэм-эдийн засгийн олон хүчин зүйлүүдтэй нягт уялдаа хамааралтай байна.

Зорилт 6 - Чанар

- Олон улсын үнэлгээгээр баян, ядуу орнуудын суралцагчдын сурлагын амжилтад асар их ялгаа зөрөө байгааг тогтоосон байна. Улс орон дотор ч ялгаагүй энэхүү харилцан адилгүй байдал нь бүс нутаг, орон нутгийн хамт олон, сургууль, анги бүлгүүдийн хооронд ч байсаар байна. Ийнхүү тэгш бус байдал нь боловсролд төдийгүй, бас нийгэмд боломж чадавхийг илүү өргөн хүрээнд хуваарилахад ноцтой үр дагаврыг авчирч байна.
- Хөгжиж буй орнуудад амжилтгүй суралцаж байгаа сурагчдын тоо харьцангуй өндөр байна. Боловсролын чанарын үнэлгээний Зүүн-Өмнөд Африкийн Консерциум (САКМЕК II)-аас Өмнөд Сахарын орнуудад хийсэн судалгаагаар, одоогоор 4 улсад VI ангийн сурагчдын 25 хүрэхгүй хувь нь, 6 улсад дөнгөж 10% нь унших чадварыг хангалттай хэмжээнд эзэмшсэнийг харуулж байна.
- Улс бүрийн хувьд сурлагын түвшин харилцан адилгүй байгаа нь сурагчдын

нийгмийн гарал, боловсролын системийн зохион байгуулалт болон сургуулийн орчин нөхцөлөөс шалтгаалж байна. Хөгжилтэй орнуудын хувьд хэдийнээ баталгаатай хангагддаг болсон шаардлагатай нөөц, тухайлбал, гэрэл цахилгаан, сандал ширээ, сурах бичгийн хэрэгсэл зэрэг нь хөгжиж байгаа орнуудын хувьд урьдын адил дутагдалтай хэвээр байна.

- Дэлхийн хэмжээнд 27 сая гаруй багш бага сургуульд багшилж байгаагийн 80% нь хөгжиж буй орнуудад ажиллаж байна. Бага сургуулийн багш нарын нийт тоо 1999-2006 онуудад 5%-иар өсчээ. 2015 он гэхэд бүх нийтээр бага боловсролыг эзэмших зорилтод хүрэхийн тулд зөвхөн Өмнөд Сахарын орнуудад 1,6 сая багшийн орон тоог шинээр бий болгох шаардлагатай бөгөөд тэтгэвэрт гарах, ажлаас чөлөөлөгдөх, нас барах (ДОХ-ын улмаас гэх мэт) зэрэг шалтгаануудыг тооцоолоод, нийтдээ 3,8 сая багш ажиллуулах шаардлагатай болно.
- Өмнөд болон Баруун Ази, Өмнөд Сахарын орнуудад багш нарын хүрэлцээ хангамж дутагдалтайгаас болж багш сурагчдын тооны харьцаанд үндэсний хэмжээнд болоод бүс нутгийн хэмжээнд асар их ялгаа зөрөө байна. Орон нутагтаа багш нарыг жигд бус хуваарилж байгаа орнуудад энэхүү тэгш бус байдал илүүтэйгээр мэдрэгдэж байна.

Боловсролын санхүүжилт

Үндэсний санхүүжилт

- Мэдээллээ ирүүлсэн ихэнх оронд боловсролд зарцуулах зардал Дакарын чуулганаас хойш өссөн байна. Зарим оронд БНБ-ын зорилгыг хэрэгжүүлэх ажлын ололт амжилттай холбоотойгоор санхүүжилт нь нэмэгджээ. Гэтэл үндэсний орлогоос боловсролд зарцуулсан санхүүжилтийн хэмжээ 1999-2006 оны хооронд, мэдээлэл ирүүлсэн 105 орны 40 оронд нь буурсан байна.

- Бага орлоготой улс орнууд бусад улстай харьцуулахад боловсролд харьцангуй бага төсөв зарцуулж байна. Өмнөд Сахарын орнуудын мэдээллээ ирүүлсэн, бага орлоготой 21 улсаас 11 нь үндэсний нийт бүтээгдхүүний дөнгөж 4 хүрэхгүй хувийг боловсролд зориулж байна. Өмнөд Азийн хүн ам олонтой хэд хэдэн улс орон үндэсний нийт бүтээгдэхүүнийхээ 3-аас доош буюу яльгүй дээш хувийг боловсролд зориулсан хэвээр байна. Энэ бүгдээс үзэхэд, боловсролд анхаарах улс төрийн хандлага, хүсэл эрмэлзэл дутуу байгааг харуулж байна.
- Боловсролын санхүүжилтийн тэгш бус байдал нь дэлхийн хэмжээнд баялаг нь тэгш бус хуваарилагдсан байгааг харуулж байгаа юм. 2004 оны байдлаар Хойд Америк, Баруун Европод 5-25 насны залуучууд дэлхийн нийт хүн амын дөнгөж 10%-ийг эзэлж байхад дэлхийн хэмжээнд боловсролд зарцуулсан нийт төсвийн 55% нь дэлхийн тэр хэсэгт ноогдож байна. Тэгвэл Өмнөд Сахарын орнуудад дэлхийн энэ насны хүн амын 15% нь амьдарч байхад, тэнд боловсролд зориулсан дэлхийн боловсролын зардал нь дөнгөж 2% байна. Өмнөд болон Баруун Азид дэлхийн энэ насны хүн амын ¼-ээс илүү байхад, боловсролд зориулсан зардал нь дөнгөж 7%-тай тэнцэж байна.

Олон улсын тусламж

- Суурь боловсролыг дэмжихэд чиглэсэн тусламж зогсонги байдалтай байна. 2006 онд хөгжиж буй орнуудад олгох тусламж 5.1 тэрбум доллар байсан нь 2004 оны түвшнээс бага зэрэг доогуур байгаа юм. Суурь боловсролыг дэмжих уриалга, зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэсэн тусламжийн тэн хагасыг цөөн хэдхэн хандивлагч нар бүрдүүлсэн.
- Бага орлоготой орнуудад суурь боловсролыг дэмжих зорилгоор 2006 онд нийт 3,8 тэрбум долларын тусламж үзүүлж байсан ба тэдгээр орнуудад боловсролын энэхүү

зорилтуудыг хэрэгжүүлэх наад захын үйл ажиллагааг санхүүжүүлэхэд жил бүр 11 тэрбум доллар шаардагдана гэсэн тооцоог биелүүлэхийн тулд өнөөгийн тусламжийн хэмжээг 3 дахин нэмэгдүүлэх шаардлагатай болж байна.

- Үр Дүнд Түргэн Хүрэх Санаачлага (ҮДТХС) нь хандивлагчдын зүгээс БНБ-д хүрэх зорилтыг шийдвэрлэхэд хоёр талын хэлэлцээрээр нэмэлт дэмжлэг үзүүлэх арга хэмжээг хэрэгжүүлж чадахгүй байна. Түүний Каталик Санд хандивлах тусламжийн хэмжээ нь өнөөгийн байдлаар төлөвлөөд байгаа хэрэгцээг хангахад хүрэлцэхгүй байна. ҮДТХС-ын тусламжийг авахаар батлагдсан орнууд 2010 он гэхэд 2,2 тэрбум долларын санхүүгийн хомсдолд орж болзошгүй юм.
- Ирээдүйд боловсролын тусламжийг илүү үр дүн, өгөөжтэй болгоход чиглүүлэх ёстой. Үр дүн нь өнөөдрийн байдлаар өөр өөр байна. Зарим хандивлагчид нь үндэсний хариуцлагыг хөхүүлэн дэмжих, үндэсний тогтолцоогоор дамжуулан үйл ажиллагаагаа явуулах болон бусад хандивлагчидтай хамтран ажиллах сонирхолтой байхад зарим нь үр өгөөж муутай байна.

Бодлогын эн тэргүүний зөвлөмжүүд

БНБ-ын зорилтуудад хүрэх нь

Бага насны хүүхдэд үзүүлэх халамж хүмүүжил, боловсрол

- Эрүүлийг хамгаалахад чиглэсэн арга хэмжээнүүд болон энэ салбарт төсвийн зардлыг илүү тэгш, шударга хуваарилах замаар боловсролын төлөвлөлт болон хүүхдийн эрүүл мэндийг хамгаалах асуудлуудын **уялдаа холбоог бэхжүүлэх**;
- Бага насны хүүхдийн боловсрол болон ялангуяа эмзэг болон хөгжлийн бэрхшээлтэй **хүүхдүүдийн халамж хүмүүжил, боловсролын**

асуудлыг тусгасан бүх хүүхдийн төлөөх төлөвлөлтөд тэргүүлэх ач холбогдол өгөх;

- Ядуу гэр бүлд чиглэсэн нийгмийн халамжийн хөтөлбөрүүдийг ашиглан хүүхдийн хоол тэжээлийн хомсдлыг арилгах болон эрүүл мэндийг хамгаалах тогтолцоог сайжруулах замаар **ядуурлын эсрэг хүчтэй тэмцэх**;

Бүх нийтийн бага боловсрол

- Бүх нийтийг бага боловсролд хамруулж, бүрэн эзэмшүүлэх явдлыг баталгаажуулахын тулд хэрэгжих боломжтой төлөвлөгөө гаргах, дунд, урт хугацааны хангалттай төсвийн хуваарилалт хийх замаар **урт хугацааны үр дүнтэй зорилтуудыг дэвшүүлэн тавих**;
- Тэгш бус байдлыг арилгах талаар тодорхой зорилтуудыг дэвшүүлэх замаар охид, эмзэг бүлгийнхэн болон үйлчилгээний хүртээмж дутмаг бүс нутгуудын иргэдийн **эрх тэгш байдлыг дэмжих**, ингэхдээ тэгш байдалд чиглэсэн практик үйл ажиллагаанд тулгуурлах;
- Сурах бичгийн хүрэлцээ хангамжийг нэмэгдүүлэх, тэдгээрийн чанарыг дээшлүүлэх, багш нарын сургалтыг бэхжүүлэх, тэдэнд дэмжлэг тусалцаа үзүүлэх болон сургалт явуулахад анги танхимийн хангамж зэрэгт анхаарал хандуулах замаар **боловсролд хүрч хүртэх боломжийг нэмэгдүүлэхийн хамт боловсролын чанарыг дээшлүүлэх**;

Боловсролын чанар

- Хангалттай материаллаг бааз, сайн бэлтгэгдсэн багш, сургалтын хөтөлбөр, сургалтын үр дүнг тодорхойлсон сургалтын үр нөлөөтэй орчинг бүрдүүлэх, боловсролын чанарыг дээшлүүлэхэд чиглэгдсэн **бодлогыг бэхжүүлэх**. Энэ үүрэг зорилтын хүрээнд багш нар болон сургалтын ажилд гол анхаарлаа хандуулах ёстой.
- Хүүхэд бүр хамгийн наад зах нь 4-5

жил бага сургуульд суралцаж, өөрийн боломжийг хөгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай бичиг **үсгийн болон тоо бодох суурь чадвар дадлыг олж авсан** байх тийм нөхцөлийг хангах.

- Сургалтын нөхцөл (дэд бүтэц, сурах бичиг, анги дүүргэлтийн хэмжээ) явц (хэл, сургалтын хугацаа) болон үр дүнд нөлөөлдөг ажлуудад **боловсролын чанарыг үнэлэх, тоолж хэмжих, хяналт үнэлгээ хийх чадавхийг нэмэгдүүлэх.**
- **Сургалтын хугацаа хүүхэд бүрт хангалттай байгаа** эсэх, сургалтын төлөвлөсөн нормт цаг, бодит хамрагдсан цагийн хоорондын зөрөөг сургууль бүрт аль болох бага байлгахын тулд одоо мөрдөгдөж байгаа бодлого, дүрэм журмуудыг эргэн харж, шинэчлэх.
- Бүс нутгийн болон олон улсын харьцуулсан сургалтын үнэлгээнд хамрагдах, сургамж туршлагаас үндэсний бодлогодоо тусгах, улс орныхоо тодорхой хэрэгцээ шаардлага, зорилгыг бодитойгоор тусгасан үндэсний хэмжээний **сургалтын үнэлгээ хийж байх.**

Тэгш бус байдлыг даван туулах нь үндэсний удирдлагын шинэчлэлтийн шалгуур юм.

- Хөрөнгө чинээ, оршин суугаа байршил, хүйс, язгуур угсаа болон амдралын чадавхийн бусад хүчин зүйлээс үүдэлтэй **тэгш бус байдлыг бууруулах үйл ажиллагаа явуулах.** Засгийн газрууд тэгш бус байдлыг багасгахад чиглэгдсэн тодорхой зорилтуудыг дэвшүүлж, тэдгээрийн хэрэгжилтэнд хяналт тавьж байх нь зүйтэй.
- Бодлогын шинжтэй тодорхой зорилтуудыг дэвшүүлж, иргэний нийгэм, хувийн сектор, эмзэг бүлгүүдийн идэвхтэй оролцоотой төрийн үйл ажиллагааны зохицуулалтыг сайжруулах замаар боловсролын салбарын зорилтуудыг хэрэгжүүлэх, тэгш бус байдалтай
- тэмцэхэд **улс төрийн удирдлагын үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх.**
- БНБ-д хүрэх зорилтийг хэрэгжүүлэхэд сөргөөр нөлөөлж байгаа **ядуурал болон тэгш бус байдлыг бууруулахад чиглэсэн бодлогыг бэхжүүлэх.** Засгийн газрууд боловсролын төлөвлөлтийн асуудлыг ядуурлыг бууруулах өргөн хүрээний бодлогод нэгтгэх шаардлагатай.
- **Боловсролын чанарын стандартыг дээшлүүлэх,** бүс нутаг, орон нутгийн хамт олон, анги сургуулиудын хоорондын сурлагын чанарын зөрөөг арилгахын төлөө ажиллах.
- **Үндэсний хэмжээнд боловсролын санхүүжилтийг нэмэгдүүлэх,** ялангуяа боловсролд бага мөнгө зарцуулж буй хөгжиж байгаа улс орнуудад илүү анхаарах
- Төсвийг ялгаваргүйгээр нарийн тооцоолох замаар эмзэг болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд хүртээмжтэй байлгах болон алс бөглүү нутгийн хүн амыг аль болох өргөн хамруулахын тулд шударга, **тэгш хуваарилалтыг санхүүгийн бодлого, төлөвлөлтийн анхаарлын төвд тэгш тавих.**
- Боловсролын салбарын нөөц боломжийг ядуурлын түвшин болон боловсрол дахь санхүүгийн гачигдлыг харгалзан хуваарилах санхүүжилтийн аргуудыг хэрэглэх замаар эрх тэгш байдалд хүрэх нэг чухал асуудал болох **төвлөрлийг бууруулах.**
- **Сургуулиудын өрсөлдөөн, сонголт** болон хувийн болоод улсын сургуулиудын түншлэл нь зарим талаар дутагдалтай байдаг гэдгийг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй. Хэрэв боловсролын тогтолцоо хангалтгүй ажиллаж байвал түүнийг засаж сайжруулах шаардлагатай.
- Бүс нутаг, сургууль бүрт, ялангуяа алслагдсан, үйлчилгээ хүрдэггүй хүн амд мэргэшсэн багш нарын хүрэлцээг сайжруулах зорилгоор **багш нарын тоог нэмэгдүүлэх, зөв хуваарилах болон тэдний хүсэл эрмэлзэл, үүргийг нэмэгдүүлэх үйл ажиллагаа явуулах.**

Хандивлагч орнууд: үүрэг амлалтын биелэлт

- БНБ-ын үндсэн зорилтуудыг санхүүжүүлэхэд өнөөдөр шаардлагатай байгаа 7 тэрбум орчим долларыг олгох замаар, ялангуяа бага орлоготой орнуудад суурь боловсролын зорилтыг хэрэгжүүлэхэд үзүүлэх тусламжийн хэмжээг нэмэгдүүлэх.
 - БНБ-д хүрэх зорилтыг хэрэгжүүлэхэд үзүүлэх санхүүгийн дэмжлэгийг тогтворжуулах зорилгоор суурь боловсролд хөрөнгө оруулж байгаа хандивлагч орнуудын хүрээг өргөтгөх.
 - Бага орлоготой улс орнуудын суурь боловсролд илүү санхүүжилт оруулах замаар боловсролд үзүүлэх тусламжийн тэгш байдлыг хангах.
- Франц, Герман зэрэг зарим хандивлагч орнууд тусламжийнхаа хувь хэмжээг эргэн бодож үзэх шаардлагатай байна.
- ҮДТХС-ыг үргэлжлүүлэн дэмжих, төлөвлөгөө нь батлагдсан улс орнуудад 2010 он гэхэд 2.2 тэрбумд хүрэхээр байгаа санхүүгийн хомсдлыг арилгаж тэдгээр оронд тусламжийг олгох.
 - Үндэсний тэргүүлэх чиглэлийг тогтоох, илүү сайн зохицуулалт хийх, үндэсний санхүүгийн удирдлагын системийн үйл ажиллагааг сайжруулах, тусламжийн хэмжээг урьдчилан тооцоолох зэргээр тусламжийг зөв зарцуулах замаар Парижийн тунхаглалд заасны дагуу тусламжийн ашигт чанар үр шимийг дээшлүүлж, үйл ажиллагааны үргүй зардлыг хэмнэх.

БҮЛЭГ 1.

БҮХ НИЙТИЙН БОЛОВСРОЛ: Хүний эрх ба хөгжлийн хөшүүрэг болох нь

2 000 онд дэлхийн удирдагчид хөгжлийн үндсэн 2 багц зорилтуудыг дэвшүүлсэн. Эхнийх нь Дакарын үйл ажиллагааны хүрээ байсан бөгөөд энд 164 орны Засгийн газрууд 2015 он гэхэд хүүхэд, залуучууд, насанд хүрэгчдийн бүх нийтийн боловсролыг хангах 6 чухал зорилтыг

Амжилт авчирах үр суулгах: Зимбабид хүүхдүүдэд зөв хооллолтын тухай зааж сургаж байна.




Боловсрол нь ядуурлыг бууруулах, тэгш бус байдлыг арилгах, эх хүүхдийн эрүүл мэндийг хамгаалах болон ардчиллыг бэхжүүлэхэд шийдвэрлэх үүрэгтэй.

баталсан. Хоёрдахь нь Мянганы хөгжлийн зорилт бөгөөд 2015 он хүртэл боловсрол, эх хүүхдийн эрүүл мэнд, хоол тэжээлийн хангамж, өвчин зовлон, ядуурлын эсрэг тэмцэх чиглэлүүдээр өргөн хүрээг хамарсан 8 зорилтыг дэвшүүлсэн.

БНБ-ын зорилт, Мянганы хөгжлийн зорилтууд (Хүснэгт 1) нь харилцан уялдаа холбоотой. Боловсрол нь өөрийн үүрэг, зорилтоосоо гадна ядуурлыг бууруулах, тэгш бус байдлыг арилгах, эх хүүхдийн эрүүл мэндийг хамгаалах болон ардчилалыг дэмжихэд шийдвэрлэх үүрэг гүйцэтгэдэг. Нөгөө талаас, ядуурал болон таагүй нөхцлүүдийг бууруулах, жендерийн тэгш байдлыг хангах зэрэг бусад салбарын амжилт ололтуудаас боловсролын хөгжил шалтгаална.

График 1. Латин Америк, Карибын тэнгисийн орнууд, Баруун болон Өмнөд Ази, Өмнөд Сахарын орнуудад 10–19 насны хүүхдүүдийн сургуульд анги дэвшиж хамрагдсан байдал, 2000–2006¹



¹ Дээр заасан хугацааны хүрээнд хамгийн сүүлийн үеийн мэдээ баримт. Эх сурвалж: 2009 оны БНБ-ын Хяналт үнэлгээний Дэлхийн Тайлангийн График 1.2-ыг үзнэ үү.

өөрчлөлт гарч байгаа хэдий ч Дакарын гол гол олон үүрэг, зорилтууд биелэгдэхгүйгээр хэтэрхий удаан, жигд бус явцтай байна. Хүүхдийн эндэгдлийг багасгах, хүнс, хоол тэжээлийн хангамжийг нэмэгдүүлэх зэрэг Мянганы хөгжлийн зорилтуудын хувьд ч мөн адил. Боловсролын салбарын амжилт ололтууд нь Мянганы хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэх явцыг идэвхжүүлэх учиртай. Гэхдээ энэ нь тэгш байдлыг хангах явдлыг зайлшгүй бэхжүүлэхийг шаардана.

2009 оны тайланд БНБ-ын болон Мянганы хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэх явцад гол саад болж байгаа боловсролын салбар дахь тэгш бус байдлыг гэтлэн давахад хөгжиж байгаа орнуудын өмнө тулгарч байгаа бэрхшээлүүдийг тусгав. Тайланд боловсролын салбарын бодлого, шинэчлэл, санхүүжилт болон удирдлагын чухал асуудлууд, түүнчлэн тэгш бус байдлыг арилгахад тэдгээрийн үүрэг ролийг тусгасан болно.

Боловсролын боломж нөхцөл: Хэт туйлшрал

Олон улсын хэмжээнд авч үзэхэд баян ядуу орнуудын хооронд зөвхөн сургуулиар боловсрол эзэмших боломжийн хувьд төдийгүй тэд юу сурч байгаагийн хоорондын ялгаа зөрөө их байна. Ялангуяа, Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (ЭЗХАХБ)-ын орнууд болон Өмнөд Сахарын орнуудын боловсролд хамрагдах байдлыг харьцуулахад илт ялгаатай байна. ЭЗХАХБ-ын орнуудад 7 нас хүрсэн бараг бүх хүүхэд бага сургуульд суралцаж байхад Өмнөд Сахарын орнуудад энэ насны хүүхдийн зөвхөн 40% нь сургуульд хамрагдаж байна. Дунд боловсролын дараах шатны боловсролд ЭЗХАХБ-ын орнуудад 20 хүртэлх насны залуучуудын 30% нь хамрагдаж байхад, Өмнөд Сахарын орнуудад дөнгөж 2%-тай байна. Мали, Мозамбик зэрэг улсад олон хүүхдийн бага боловсролд хамрагдах боломж Франц, Английн Нэгдсэн Вант улсын тэр насны хүүхдийн дээд боловсрол эзэмших боломжоос доогуур байна. Өндөр болон бага орлоготой улс орнуудад дэлхий нийтийг хамарсан боловсролын салбар дахь тэгш бус байдал нь тухайн улс үндэстний дотор түгээмэл

Гэтэл, БНБ-ын 2009 оны Хяналт үнэлгээний Тайланд орсон мэдээгээр, өнөөдрийн байдлаар 2015 он гэхэд дэлхийн хэмжээнд олон үүрэг, зорилт биелэгдэхээргүй харагдаж байна. Боловсролын салбарт ахиц

байдаг тэнцвэргүй байдлыг халхлан далдалж байна. Орлогын түвшин, хүйс, гарал угсаа, оршин байгаа газар нутаг болон бусад хүчин зүйлээс шалтгаалсан үндэсний хэмжээний тэгш бус байдал нь хүүхдүүд боловсролын үр шимийг хүртэхэд бэрхшээл учруулж байна. Өмнөд болон Баруун Азийн орнууд, Өмнөд Сахарын орнуудад нэн ядуу өрхийн 20%-ийнх нь хүүхдүүдийн хувьд 9-р ангийн боловсрол эзэмших магадлал чинээлэг гэр бүлийн 20%-ийн хүүхдүүдийнхээс 2 дахин бага байна (График 1). Улс орны Засгийн газрууд болон хөгжлийн олон улсын байгууллагууд БНБ-ын үндсэн зорилтуудад хүрэхийн тулд тэгш бус байдлыг хангахад хүчин чармайлтаа хандуулах шаардлагатай байна.

Боловсролын үр шимийг хүртэх боломжийг улам бүр нээх нь

Боловсролын салбарын хөгжил дэвшил нь Мянганы хөгжлийн өргөн зорилтуудад хүрэх замд дэлхий даяараа ороход үлэмж их үүрэгтэй. Энэ нь ялангуяа 3 салбарт илүү ихээр мэдрэгдэнэ.

- **Эдийн засгийн өсөлтөөр ядуурлыг бууруулах.** Эдийн засгийн тэгш өсөлт нь ядуурлыг бууруулах чухал хүчин зүйл юм. Боловсролыг эдийн засгийн өндөр өсөлт, хөдөлмөрийн бүтээмжтэй холбон авч үздэг. 1960-2000 оны хооронд 50 оронд явуулсан нэгэн судалгаанаас үзэхэд сургуульд нэг жил илүү сурснаар нийгмийн нийт бүтээгдхүүний өсөлтийн жилийн дундаж үзүүлэлт 0,37%-иар, харин танин мэдэхүйн ур чадварыг дээшлүүлэхтэй нийлээд 1%-иар нэмэгдсэн байна. Өөр нэг судалгаагаар, сургуульд нэг жил илүү сурснаар хувь хүний ажлын цалин 10%-иар нэмэгдэх боломжтой болохыг харуулсан байна. Боловсролын салбарын тэгш бус байдал нь орлогын түвшний тэгш бус байдалд хүргэж байна. Энэтхэг, Филиппин, Вьетнам зэрэг улсад ажлын цалин хөлсний зөрүү нь хүн амын дээд боловсрол эзэмшсэн болон боловсролын үр шимийг бүрэн дүүрэн хүртэж чадаагүй бүлгүүдийн хоорондын тэгш бус байдалтай салшгүй холбоотойгоор

нэмэгдэж байна. Боловсролд хүн амыг өргөн хүрээтэй хамарч, ядуу хүмүүсийг аль болох ихээр оролцуулах нь мөн өргөн хүрээг хамарсан ядуурлыг бууруулахад үр шимээ өгөх тийм эдийн засгийн өсөлтийг хангаж чадна.

- **Хүүхдийн эрүүл мэндийг сайжруулах ба хүүхдийн эндэгдлийг багасгах.** Боловсрол болон нийгмийн эрүүл мэндийн асуудал уялдаа холбоотой болох нь тодорхой. Бага, дунд боловсролтой эхчүүдийн хувьд хүүхдийн эндэгдлийн үзүүлэлт доогуур байгаа нь нэгэнт тогтоогдсон. Түүнээс гадна, боловсролтой эцэг эхчүүд үр хүүхдээ харьцангуй сайн тэжээж, хүмүүжүүлж байна. Жишээ нь Бангладеш, Мозамбикт явуулсан судалгаанаас үзэхэд, эцэг эхийн боловсрол өндөр байх тусам хүүхдийн хөгжлийн хоцрогдол бага байна. Бусад хүчин зүйлүүдийг авч үзэхэд, Бангладешт бага боловсролыг бүрэн эзэмшсэн эхчүүд хүүхдийн өсөлтийн эрсдлийг 22%-иар бууруулж чадсан байна. Бага дунд боловсрол нь цаашилбал, ДОХ-оос урьдчилан сэргийлэх эерэг үр нөлөөтэй. Энэ бүх байдалд боловсрол болон хөгжлийн бусад зорилтууд хоорондоо нягт уялдаа холбоотой байгаа нь харагдаж байна.
- **Ардчилал ба иргэншлийг хөхүүлэн дэмжих.** Хүмүүст бичиг үсэг төдийгүй амьдралын наад захын дадал чадвар олгодог боловсрол нь тэдэнд нийгмийн амьдралд оролцох болон төр засгаа хянаж хариуцлага хүлээлгэх боломж, чадварыг олгодог. Ядуу зүдүү, алс бөглүү газрын хүмүүс ч боловсрол эзэмшсэнээр орон нутгийнхаа зөвлөлийн хуралд оролцож, боловсрол, эрүүл мэнд, усны нөөц болон бусад асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэдэг. Үүний жишээ бол, Өмнөд Сахарын орнуудад боловсрол нь олон намуудын ардчиллыг дэмжиж, хүнд суртлын эсрэг тэмцэхэд чухал үүрэгтэй болохыг нотлон харуулж байна. Сурагчдын олон улсын үнэлгээний ЭЗХАХБ-ын хөтөлбөрийн хүрээнд сүүлийн үеийн сурлагын үнэлгээгээр шинжлэх ухааны боловсрол нь сурагчдад

Эдийн засгийн өндөр өсөлт, хөдөлмөрийн бүтээмж нь боловсролоос хамаарч буй нь нотолгоотой юм.

Оруулга 1. Бүх нийтийн боловсролын зорилтууд ба Мянганы хөгжлийн зорилтын боловсролын асуудлууд

БНБ-ын зорилтууд

- (1) бага насны, ялангуяа эмзэг бүлгийн болон амьдралын боломж тааруу хүүхдийн халамж хамгаалал, боловсролыг бүхий л талаар хөгжүүлж сайжруулах,
- (2) бүх хүүхдүүд, ялангуяа охидууд, эмзэг бүлгийн болон үндэсний цөөнхийн хүүхдүүдийг 2015 он гэхэд бүрэн үнэ төлбөргүй, чанартай бага боловсролд бүрэн хамруулж, эзэмшүүлэх,
- (3) ашигтай мэдлэг олж авах, амьдрах ухаанд сургасан хөтөлбөрүүдэд бүх залуус, насанд хүрэгчдийг эрх тэгш хамруулан, тэдний боловсролын хэрэгцээг хангах,
- (4) насанд хүрэгчид, ялангуяа эмэгтэйчүүдийн бичиг үсгийн түвшинг 2015 он гэхэд 50 хувиар нэмэгдүүлэх, бүх насанд хүрэгчдэд суурь болон насан туршийн боловсролын хөтөлбөрүүдэд хамрагдах эрх тэгш боломж олгох,
- (5) бага, дунд сургуульд жендерийн тэнцвэргүй байдлыг 2005 он гэхэд арилгах, охидуудад чанартай суурь боловсрол эзэмших бүрэн бөгөөд эрх тэгш боломж олгон, боловсролын салбарт жендерийн тэнцвэртэй байдалд 2015 он гэхэд хүрэх,
- (6) боловсролын чанарыг бүхий л талаар сайжруулах, нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн, бодитой үр дүнд бүх нийтээр хүрэх, ялангуяа амьдралд зайлшгүй шаардлагатай унших, бичих, бодох зэрэг мэдлэг чадварыг нийтэд эзэмшүүлж, боловсролын эрхэм чанарыг хангах,

Боловсролтой холбоотой МХЗ-ууд

Зорилт 2. Бүх нийтээр бага боловсрол эзэмших

Зорилго 3. Эрэгтэй эмэгтэй хүүхэд бүр бага боловсролыг бүрэн дүүрэн эзэмшсэн байх

Зорилт 3. Хүйсийн тэгш байдлыг дэмжих, эмэгтэйчүүдийн эрхийг нэмэгдүүлэх

Зорилго 4. 2005 он гэхэд бага дунд боловсрол, 2015 он гэхэд боловсролын бүхий л түвшинд хүйсийн тэгш бус байдлыг арилгах

байгаль орчины асуудлаар өргөн мэдлэг олгож, тогтвортой хөгжилд илүү их хариуцлага хүлээх ухамсрыг төлөвшүүлж байгаа нь харагдаж байна. Энэхүү байдал нь эргээд засгийн газраа хянахад ашигтайгаар нөлөөлж, өөрчлөлт шинэчлэлт хийхийг шаардан хэрэгжүүлэхэд ач холбогдолоо өгч байна.

Энэхүү товч тайлан боловсролын өнөөгийн байдал болон тэгш бус байдлыг арилгахад бодлого, шинэчлэлт нь хэрхэн сайнаар нөлөөлж байгаа талаарх ерөнхий тоймыг өгнө. 2-р бүлэгт БНБ-д хүрэх 6 зорилтыг хэрэгжүүлэх ажлын явц, үр дүн, дэлхий нийт, бүс нутаг, үндэсний хэмжээнд тэгш бус байдлыг арилгах явдалд онцгой анхааран, боловсролын салбарт гарсан ололт амжилтыг дүгнэж байна. 3-р бүлэгт боловсролын удирдлагын асуудлыг авч үзээд, эдгээр шинэчлэлт өөрчлөлт нь тэгш бус байдлыг арилгаж чадах уу үгүй юу, яаж арилгах вэ гэдгийг тодорхойлохыг зорьсон юм. 4-р бүлэгт боловсролыг дэмжих олон улсын тусламжийн чиг хандлага, энэхүү тусламжийн үр нөлөөг дээшлүүлэх хүчин чармайлтын талаар авч үзжээ. 5-р бүлэгт БНБ-д хүрэх бодлогын шинжтэй санал зөвлөмжийг оруулж байна.

Боловсрол болон хөгжлийн бусад зорилтууд хоорондоо нягт уялдаа холбоотой байдаг.



Гондураст бичиг үсгийн хичээлд суух тангараг өргөж байгаа нь

БҮЛЭГ 2.

ДАКАРЫН ЗОРИЛТУУД:

Хэрэгжилт болон тэгш бус байдлын хяналт үнэлгээ

Энэ бүлэгт өмнөх Тайланд хэвлэгдсэн дунд хугацааны үнэлгээний үндсэн дээр БНБ-д хүрэх зорилтын хэрэгжилтийг авч үзсэн юм. 2006 оны тоо баримтаас үзэхэд олон газар, ялангуяа нэн ядуу олон оронд гайхалтай ахиц дэвшил гарсныг цохон тэмдэглэсэн байна. Хэдий тийм ч, 2015 он гэхэд бүх нийтээр бага боловсрол эзэмших зорилт болон бусад олон гол зорилтууд зарим бүс нутагт хэрэгжих боломжгүй байна. Орлогын түвшин, хүйсийн байдал болон бусад хүчин зүйлээс улбаатайгаар амь бөхтэй оршсоор байгаа тэгш бус байдал нь БНБ-д хүрэх зорилтыг хэрэгжүүлэх явцыг удаашруулж байна.

Бага насны хүүхдийн халамж хүмүүжил ба боловсрол: Бид урт замыг туулахаар байна.

Зорилт 1: Бага насны, ялангуяа эмзэг бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд анхаарал халамж тавих, боловсрол эзэмшүүлэхэд чиглэгдсэн цогц арга хэмжээнүүдийг өргөжүүлэн сайжруулах

БНБ-д хүрэх зам нь бага сургуульд орохоос ч өмнө эхэлдэг. Сургуульд орохоос өмнө тохиосон зүйлс нь цаашид сурч боловсрох болон амьдралдаа амжилт бүтээл гаргахад чухал нөлөөтэй байдаг. Хүүхдийн бага насны хүмүүжил, боловсролын хөтөлбөрүүд нь олон талын ач холбогдолтой. Тэдгээр нь хүүхдийн эрүүл мэнд, хүнс тэжээлийг сайжруулах, танин мэдэхүйг нь хөгжүүлэх болон сурч боловсрох, бэрхшээлийг даван туулахад шаардлагатай мэдлэг чадварыг олгож байдгаараа ач холбогдолтой.

Тэдгээрийн нийгэмд үзүүлэх ашиг тусыг өргөн утгаар нь авч үзвэл, хөдөлмөрийн бүтээмж болон орлогыг нэмэгдүүлж, эрүүл мэндийг сайжруулан, илүү тэгш боломжоор хангаж байгаа явдал юм. Өнөөдөр дэлхийн сая сая хүүхдийн өмнө эрүүл мэнд, хүнс тэжээлийн асуудлууд тулгарч, сургуулийн өмнөх боловсролд хамрагдах боломж нь урьдын адил хязгаарлагдмал бөгөөд тэгш бус хэвээр байна.

Хүүхдийн эрүүл мэнд, хүнс тэжээл: Алгуур, жигд бус ахиц дэвшил

Ихэнх улс оронд хүүхдийн сайн сайхан байдал олон үзүүлэлтээр сайжирч байна. Зарим тохиолдолд хүүхдийн эндэгдэл багасч, дархжаалуулалт болон вакцинжуулалт сайжирч, тэрчлэн ДОХ-ын халдварыг эмчлэхэд ахиц гарч байна. Олон улсын санаачлага дэмжлэгт тулгуурласан үндэсний хүчтэй бодлого ч зохих ёсны үр дүнгээ өгч байна. Гэхдээ өнөөдрийн хүчин зүтгэл шаардлагатай хэмжээнд хүрэх болоогүй байна. Хүүхдийн эндэгдэл, өвчлөлтийг дорвитой бууруулж чадахгүй байгаа нь боловсролд хүрэх зорилтыг хэрэгжүүлэх явцыг удаашруулсаар байна.

Хүүхдийн эндэгдэл: Алгуур ахиц гарч байгаа ч тэгш бус байдал. Жилд ойролцоогоор 10 сая хүүхэд 5 нас ч хүрэлгүй нас барж байна. Олонхи тохиолдолд, энэ нь ядууралтай холбоотой. Мянганы хөгжлийн 4 дэх зорилтын дагуу Засгийн газрууд 2015 он гэхэд хүүхдийн нас баралтыг 2/3-оор бууруулах зорилт тавьсан. Тодорхой амжилтанд хүрсэн: 1990 онтой харьцуулахад 2006 онд 5 хүртэлх

Хүүхдийн хүнс тэжээлийн хомсдол нь бүх нийтээр бага боловсрол эзэмшихэд саад болж байгаа гол хүчин зүйлүүдийн нэг бөгөөд 5 наснаас бага хүүхдийн 1/3-тэй тэнцэхийг хамарч жилд ойролцоогоор 3.5 сая хүүхэд нас барж байна.

Мексик болон Эквадорт бага насны хүүхэд, эхчүүдийн халамж үйлчилгээг дэмжих зэрэг нийгмийн хамгааллын хөтөлбөрүүдийг боловсруулан амжилттай хэрэгжүүлж байна.

насны хүүхдийн нас баралт 3 саяар буурсан нь энэ үзүүлэлт 1/4-ээр бага байгаа юм. Бангладеш, Мозамбик, Балба, Этиоп зэрэг улсад 5 хүртэлх насны хүүхдийн нас баралт 40%-иар буурсан. Судалгаанаас үзэхэд, корийн эсрэг вакцин хүүхдийн нас баралтыг дэлхийн хэмжээгээр 60%-иар бууруулсан байна.

Гэхдээ л ихээхэн эрчимтэй хүчин чармайлт гаргахгүйгээр Мянганы хөгжлийн зорилт хэрэгжихээргүй төлөв байдалтай байна. 5 хүртэлх насны хүүхдийн нас баралтын бүх тохиолдлын тэн хагас нь ноогддог Өмнөд Сахарын орнуудад хүүхдийн нас баралтын бууралтын явц тавьсан зорилгын зөвхөн 1/4-тэй тэнцэж байна. 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн бүх тохиолдлын 1/3 нь ноогддог Өмнөд Азийн орнуудад байдал яльгүй дээр, нас баралтын бууралтын явц шаардлагатай хэмжээний 1/3-тэй тэнцэж байна. Энэ үзүүлэлтээр Бангладеш, Балба улсууд нь орлого, эдийн засгийн өсөлт харьцангуй өндөр хэдий ч хүүхдийн эндэгдлийн бууралт шаардагдах хэмжээний дөнгөж 1/3-тэй тэнцэж байгаа Энэтхэгээс илүү үр дүнд хүрсэн байна. Хэрэв Энэтхэгт хүүхдийн нас баралтыг Бангладешд хүрсэн түвшинд бууруулж чадах юм бол, 2006 онд хүүхдийн нас баралт 200 мянгаар буурах байлаа. Саяхан явуулсан судалгааны дүнгээс үзэхэд, ядуу гэр бүлийн хүүхдүүд илүүтэй эндэгдэлд өртөж байгаа нь харагдсан. Чинээлэг гэр бүлийн хүүхдүүдийн нас баралтын түвшин нэн ядуу гэр бүлийн хүүхдүүдийн нас баралтын түвшнээс харьцангуй доогуур байна. Нигерт нас баралтын дундаж үзүүлэлт буурсан ч баян, ядуу гэр бүлийн хүүхдүүдийн нас баралтын үзүүлэлтийн ялгаа улам ихсэж байна.

Хүүхдийн хүнс тэжээлийн хомсдол нь тэдний чадавхийг бууруулж, өсөлт хөгжлийг нь сааруулж байна. Хүүхдийн хоол тэжээлийн хомсдол нь бүх нийтээр бага боловсрол эзэмшихэд саад болж байгаа гол хүчин зүйлүүдийн нэг юм. Энэ нь дэлхий нийтийг хамарсан тахал болж, 5 хүртэлх насны бүх хүүхдийн 1/3-нь үүнд өртөж, жил бүр ойролцоогоор 3,5 сая хүүхдийн нас баралтын шалтгаан

болж байгаа юм. Хоол тэжээлийн хомсдол нь хүүхдийн бие бялдрын өсөлт хөгжил, оюуны чадавхи боломж, цаашилбал, сурах чадварт урт хугацааны муу үр дагавар учруулна. Хоол тэжээлийн хомсдолтой хүүхдүүд бусдаас оройтож сургуульд орж, сурах чадавхи сул дорой байдаг зэргээс шалтгаалан тэдний сурлагын амжилт доогуур байгаа нь Филиппинд хийсэн судалгаагаар харагдаж байна. Зарим улс эх хүүхдийн эрүүл мэндийг хамгаалах талаар цогц арга хэмжээг авч хэрэгжүүлэн, энэ асуудлыг амжилттай шийдвэрлэсэн байна. Энд Танзаны Нэгдсэн БНУ болон Этиопын эрүүл мэндийг хамгаалах хөтөлбөрүүдийг жишээ болгон нэрлэж болно. Гэвч хүүхдийн хүнс, хоол тэжээлийн хомсдлыг бууруулах асуудлыг шийдвэрлэх ажлын ерөнхий явц хязгаарлагдмал шинжтэй, олон оронд байдал улам доройтож байна (График 2). Зөвхөн Өмнөд Сахарын орнуудад хүнс, хоол тэжээлийн хомсдолтой хүний тоо 1990-2003 оны хооронд 169 саяас 206



Тэжээллэг хоол хүнс, Лесото

График 2. Хоол тэжээлийн дутагдал нь дутуу жинтэй төрөх болон биеийн хөгжлийн хоцрогдлын шалтгаан болдог¹. Энэ асуудал нь хөгжиж буй орнууд, ялангуяа Өмнөд Азийн орнуудад илүүтэйгээр мэдрэгдэж байна.



¹ Сүүлийн жилийн тоо баримтууд.

² Төв болон Зүүн Европ, Тусгаар Улсуудын Хамтын Нөхөрлөлийн Орнууд

Эх сурвалж: 2009 оны БНБ-ын Хяналт үнэлгээний Дэлхийн Тайлангийн График 2.4-ийг үзнэ үү.

сая хүртэл өссөн байна. Үнийн өсөлт нь ялангуяа ядуу айл өрхөд хүндээр тусах учраас олон улсын хүнсний хямрал энэ байдлыг улам доройтуулж болзошгүй.

Бага насны хүүхдэд чанартай боловсрол олгох: Адил тэгш шударга байдлын үндэс суурь

3 хүртэлх насны хүүхдэд үзүүлэх халамж үйлчилгээ, дархлаажуулалт, хүнс тэжээлийн хангамж хөгжингүй болон хөгжиж байгаа орнуудад эрс ялгаатай байна. Хөгжиж байгаа орнуудад энэ нь хязгаарлагдмал, зохицуулалт муутай байдаг учраас хүүхдэд тавих анхаарал халамж үндсэндээ гэр бүлийн хүрээнд л явагддаг. Нэн ядуу зарим орнуудын Засгийн газрууд бага насны хүүхэд, эхчүүдийн халамж үйлчилгээг дэмжих зэрэг нийгэм хамгааллын өргөн хүрээний хөтөлбөрүүдийг боловсруулан амжилттай хэрэгжүүлж байна. Мексикт нийгмийн халамжийн мөнгөн тэтгэлгийн «Боломж» хөтөлбөрт 2007 онд 5 сая айл өрхийг хамруулан 3.7 тэрбум долларын төсөв зарцуулсан байна. Эквадорын «Хүний

хөгжлийн бон» тунхаглалын хүрээнд хүнд нөхцөлд байгаа эмэгтэйчүүдэд тодорхой нөхцөлгүйгээр мөнгөн тусламж олгодог байна. Сүүлийн үеийн үнэлгээгээр, эдгээр хүчин зүйлс нь хүүхдийн хөгжил, биеийн болон оюуны чадавхийг нэмэгдүүлэхэд нөлөөлсөн байна. Сар бүр 15 хүртэлх долларын мөнгөн тэтгэлэг олгож байгаа нь сургуульд хамрагдалт 75%-иас 85% хүртэл өсөхөд, нэн ядуу хүн амын хүүхдүүдийн хөдөлмөр эрхлэлтийн түвшинг 17%-иар буурахад хүргэсэн байна.

3-аас дээш насны хүүхдийг сургуулийн өмнөх албан боловсролд хамруулах: Хамрагдалт жигд бус, тэгш бус байдал их байна.

Дэлхий нийтээр сургуулийн өмнөх боловсролд хамрагдах хүүхдүүдийн тоо тогтмол өсч байна. Бага насны хүүхдийг боловсролд хамруулах хөтөлбөрүүдэд 2006 онд ойролцоогоор 139 сая хүүхэд, харин 1999 онд дөнгөж 112 сая хүүхэд хамрагдаж байсан байна. Гэтэл, баян ядуу орнуудын хооронд, мөн тухайн нэг улсын дотор ч ихээхэн ялгаа зөрүү байсаар байна. Сургуулийн өмнөх боловсролд хамрагдалтын цэвэр хэмжээ 2006 онд хөгжингүй орнуудад дунджаар 79%, хөгжиж байгаа орнуудад 36%-тай байв. Сургуулийн өмнөх боловсролд хамрагдалтын байдал Өмнөд Сахарын орнууд болон Арабын улсуудад хамгийн доогуур байна. Өмнөд Сахарын 35 оронд судалгаа явуулахад 17-д нь хамрагдалтын цэвэр жин 10-аас доош хувьтай байхад, мөн тийм судалгаанд хамрагдсан Арабын 18 орны 6-д нь энэ үзүүлэлт 10%-иас, 3-т нь 20%-иас доош байна. Сургуулийн өмнөх боловсролд хамрагдалт үндэсний дундаж орлоготой холбоотойгоор өсөх хандлагатай байна. Гэхдээ энэ нь аяндаа өсөхгүй. Өндөр орлоготой Арабын зарим улсад боловсролд хамрагдах хувь хэмжээ Гана, Кени, Балба зэрэг нэн ядуу орныхоос доогуур байна. Үр дүнгийн үзүүлэлт нь Засгийн газрууд бага насны хүүхдийн боловсролын асуудлыг эн тэргүүний зорилтоо болгон тавьж байгаа эсэхтэй холбоотой. Бага орлоготой

Бага насны хүүхдийг боловсролд хамруулах хөтөлбөрийн үр шимийг ядуу болон хөдөө алслагдсан орон нутгийн эмзэг бүлгийн хүүхдүүд харьцангуй илүү хүртэж байгаа хэдий ч олон улсын судалгаагаар, эмзэг бүлгийн хүүхдүүдийн сургуульд хамрагдалтын хэмжээ хамгийн доогуур байна.

улс орнууд санхүүгийн бэрхшээлтэй тулгардаг нь нэгэнт ойлгомжтой. Гэхдээ зөв, шийдэмгий төрийн бодлогоор энэ байдлыг өөрчилж, амжилтанд хүрч болно. Бага насны хүүхдийн боловсролыг дэмжихэд гадаад тусламж дэмжлэг үлэмж их ач тустай. Өнөөдөр боловсролд үзүүлж буй нийт тусламжийн дөнгөж 5% нь бага насны хүүхдийн боловсролд зориулагдаж байна. Сургуулийн өмнөх боловсролд хамрагдахад тухайн улсын дотор ч ялгаа их байна. Бага насны хүүхдийг боловсролд хамруулах хөтөлбөрийн үр шимийг ядуу болон хөдөө алслагдсан орон нутгийн эмзэг бүлгийн хүүхдүүд харьцангуй илүү хүртэж байгаа хэдий ч олон улсын судалгаагаар, эмзэг бүлгийн хүүхдүүдийн сургуульд хамрагдалтын хэмжээ хамгийн доогуур байна. Орлогын түвшин, оршин суугаа газар нутаг, нийгэм-соёлын бүлгээс хамааран тэгш бус байдал гарсаар байна.

- **Орлогын түвшин.** Нэн ядуу гэр бүлийн хүүхдүүдийн сургуулийн өмнөх боловсролд хамрагдах үзүүлэлт чинээлэг гэр бүлийн хүүхдүүдийнхээс нилээн доогуур түвшинд байна. Бага насны хүүхдийн боловсролын хөтөлбөрт хамрагдалт Сирийн Араб улсад, хамгийн баян хүн амын хүүхдүүдийн 20% нь хамгийн ядуу хүн амын хүүхдүүдийн 20%-иас даруй 5 дахин олон байна. Эдгээр шалтгааны дотроос сургалтын таатай нөхцөл бүрдээгүй, түүнд зориулах хөрөнгө мөнгө дутмаг, хөтөлбөрүүдийн чанар, үр дүн хангалтгүй байгаа тухай эцэг эхчүүдийн санал, дүгнэлт зэргийг тэмдэглэх нь зүйтэй.

- **Оршин суугаа байршил.** Олон оронд хот хөдөөгийн хоорондын ялгаа, бас газарзүйн байршлаас үүдэлтэй ялгаа асар их байна. Кот Дивуар улсад сургуулийн өмнөх боловсролд хамрагдах түвшин 19%-иас Абиджаны зүүн хойд алслагдсан хэсгээр 1-ээс доош хувь хүртэл ялгаатай байна. Бангладешт ядуучуудын хорооллын оршин суугчид хамгийн тааламжгүй нөхцөлд амьдарч байна.

- **Нийгэм-соёлын бүлгүүд.** Бага насны хүүхдэд боловсрол олгох хөтөлбөрүүдэд хамрагдах, түүнд оролцоход хэл, гарал угсаа, шашин шүтлэг зэрэг хүчин зүйлүүд нөлөөлж байна.

Бага насны хүүхдийн боловсролыг адил тэгш хүртээмжтэй болгох асуудал зөвхөн хөгжиж буй орнуудын асуудал ч биш юм. Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын орнуудын дотор ч сургуулийн өмнөх боловсрол олгоход ихээхэн ялгаа зөрүү байсаар байна. Жишээлбэл, Франц болон Скандиновын зарим оронд сургуулийн өмнөх боловсролд бараг бүх хүүхэд хамрагдаад байхад, АНУ-д 10 хүүхэд тутмын 6 нь л хамрагдаж байна. Бусад баян чинээлэг орнуудаас ялгаатай нь гэвэл АНУ-д бага насны хүүхдийг боловсролд хамруулах үндэсний стандарт болоод зохицуулалтын тогтсон бүтэц байдаггүй нь боловсролын чанар болон түүний хамралтанд ихээхэн ялгаатай байдлыг бий болгож байгаа юм. Тус улсын Холбооны улсуудаа Head start зэрэг санаачлагууд ядуу хүн амд чиглэгдсэн хэдий ч үр дүн нь харилцан адилгүй байна. АНУ-д бусад олон улсын нэгэн адил сургуулийн өмнөх боловсролд хандах өнөөгийн чиг хандлага нь бүх хүүхдийг амьдралын гараагаа эхлэх адил тэгш боломжоор хангаж чадахгүй байна.

Бүх нийтээр бага боловсрол олгох явц: улс орнууд салаа замын уулзвар дээр байна.


Зорилт 2. 2015 он гэхэд хүүхэд бүр, ялангуяа охидууд, хүнд нөхцөлд амьдардаг болон үндэстний цөөнхийн хүүхдүүд чанартай бага боловсролд үнэ төлбөргүйгээр заавал хамрагдаж, түүнийгээ бүрэн дүүргэсэн байх нөхцлийг бүрдүүлэх

2015 он гэхэд бүх нийтийг бага боловсролд хамруулах амласан зорилтдоо Засгийн газрууд хүрч чадах нь уу, үгүй юү? гэдэгт хариу өгөхөд 7-хон жил үлдээд байна. Хэрэв одоогийн байдал хэвээр үргэлжилбэл, энэ

амлалт биелэгдэхгүй. Зорилтдоо хүрэхэд явц дэндүү удаан, үр дүн харилцан адилгүй байна. 2006 онд 1999 онтой харьцуулахад 40 саяар илүү хүүхэд бага сургуульд суралцаж байна. Дэлхийн хэмжээнд энэхүү өсөлт нь бараг бүгдээрээ Өмнөд Сахарын орнууд, Арабын улсууд, Өмнөд болон Баруун Азийн орнуудад гарчээ. Бусад бүс нутагт боловсролд хамрагдалтын ерөнхий үзүүлэлт, сургуулийн насны хүүхдийн тоо цөөрснөөс болж яльгүй буурсан.

Бага сургуульд хамрагдвал зохих насны хүүхдийн хэдэн хувь нь хамрагдсан болохыг хамран сургалтын цэвэр жингээр харуулдаг. Энэ насны бүлгийн хүүхдүүдийн боловсролд хамрагдсан байдал хөгжиж байгаа орнуудын хувьд дундаж цэвэр жин 1990-ээд оныхоос 2 дахин өсч, 2006 онд 85%-д хүрсэн байна (График 3). Олон оронд бага боловсролыг эн тэргүүнд тавьж байгаа нь үүний гол шалтгаан болж байна.

График 3. Бага боловсролд хамрагдалтын цэвэр жин, бүс нутгийн дундаж үзүүлэлтээр, 1999- 2006



1999 он ► 2006 (1999 оноос хойшхи өсөлт)
 ▲ 2006 (1999 оноос хойшхи бууралт)

Эх сурвалж: 2009 оны БНБ-ын Хяналт үнэлгээний Дэлхийн Тайлангийн Хүснэгт 2.3-ыг үзнэ үү.

70%-д хүрсэн байна. Мөн Өмнөд болон Баруун Азид 75%-иас 86% болтлоо огцом өссөн.

Зарим нэг гайхамшигтай амжилтаас дурдвал: Этиопод боловсролд хамрагдалтын цэвэр хэмжээг 2 дахин өсгөж чадсан ба хөдөөд сургуулийн барилга барих чухал хөтөлбөрийг хэрэгжүүлснээр сургуульд суралцагчдын тоог нэмэгдүүлэх болон тэгш бус байдлыг арилгахад томоохон амжилтанд хүрсэн. Балбад иргэний зөрчилдөөн гарч байсан хэдий ч боловсролд хамрагдалтын хэмжээг 1999-2006 оны хооронд 65%-иас 79% хүртэл нэмэгдүүлсэн (Оруулга 2). Арабын улсуудын дотроос, 1999 оны байдлаар боловсролд хамрагдалтын хэмжээгээр доогуур байсан 4 оронд (Джибути, Йемен, Мавритани, Марокко) бүгдэд нь мэдэгдэхүйц амжилт гарсан. Энэ нь сургалтыг төлбөрөөс чөлөөлж, сургууль, багш болон сургалтын материаллаг баазаар хангахад төрөөс олгох зардлыг нэмэгдүүлж, тэгш бус байдлыг бууруулахад чиглэгдсэн эрчимтэй арга хэмжээ авч хэрэгжүүлсэн зэргээр төрөөс явуулсан бодлогын үр дүн юм. Үүнд олон улсын тусламж ч чухал үүрэг гүйцэтгэжээ.

Оруулга 2. Балба улс бүх нийтээр бага боловсролтой болох зорилтод хүрэхэд ойрхон байна

Балбад 2006 он хүртэл иргэний хурц зөрчилдөөн гарч байсан хэдий ч, 2000 оноос хойш бүх нийтийг бага боловсрол эзэмшүүлэхэд ололт амжилт тогтвортой гарсаар байна. 2001 оноос 2006 он хүртэлх хугацаанд боловсролд хамрагдалтын хэмжээг 81-ээс 87%-д хүргэсэн байна. Сургууль завсардалт буурсан. 5-р анги хүртэлх суралцагчдын тоо 1999 онд 58% байсан бол, 2005 онд 79% болж өссөн. Сургууль завсардсан хүүхдийн тоо Дакарын бага хурлын өмнө 1 сая байсан бол, 2006 онд 700000 хүртэл буурсан. Балбын туршлага нь үр дүнд түргэн хугацаанд хүрэх боломжийг бүрдүүлсэн төрийн бодлогын шинэчлэлт өөрчлөлтийн хүч нөлөөг бэлхнээ илтгэн харуулж байна. Гол хүчин зүйлүүд гэвэл: орон нутгийн хариуцлагыг дээшлүүлэх, хүнд нөхцөлд амьдарч байгаа хүүхдүүдэд тэтгэлэгт хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх замаар илүү тэгш шударга байдлыг хангах, дэд бүтцийг өргөжүүлэх, хандивлагчийн тусламжийн чанар, үр өгөөжид анхаарах зэрэг асуудал болно.

1999-2006 оны хооронд Өмнөд Сахарын орнуудад хамран сургалтын жилийн дундаж цэвэр жин Дакарын Бага хурлын өмнөх 10 жилийн үзүүлэлтээс 6 дахин нэмэгдэж,

Сургууль завсардсан хүүхдүүд: бас л урт замыг туулахаар байна.

2006 онд сургууль завсардсан хүүхэд 1999 оныхоос 28 саяар буурсан. 1990-ээд оны үетэй харьцуулахад, Дакарын Бага хурлаас хойш хүрсэн амжилт ололт үнэхээр бишрэм. Гэтэл, бага сургуулийн насны 75 сая хүүхэд, тэдгээрийн 55% нь охид, сургууль завсардсан хэвээр байна. Сургууль завсардалт нь зарим бүс нутаг, улс оронд илүү ихээр төвлөрсөн байна. Зөвхөн ганц Өмнөд Сахарт гэхэд л сургууль завсардсан нийт хүүхдийн бараг тэн хагас (47%) нь ногдож, мөн тийм хүүхдийн ¼ нь Өмнөд ба Баруун Азийн орнуудад амьдарч байна. 8 оронд¹ сургууль завсардсан хүүхдийн тоо тус бүртээ 1 саяас давж байгаа бөгөөд 1999 оноос хойшхи хугацаанд эдгээр орнуудын үзүүлэлт янз бүр байна.

Сургууль завсардсан хүүхдийн тооны цаашдын төлөв байдал анхаарал татаж байна. Энэ хандлага цаашид хэвээр үргэлжилбэл, 2015 он гэхэд, судалгаанд хамрагдсан 134 оронд сургууль завсардах хүүхдийн тоо 29 саяас багагүй байх нь харагдаж байна². 2015 он гэхэд сургууль завсардах хүүхдийн тоо Нигерид хамгийн их (7.6 сая), түүний дараа Пакистанд (3.7 сая), Буркина-Фасо болон Этиопод (тус бүр 1.1 сая), Нигер болон Кенид (тус бүр 0,9 сая) байхаар харагдаж байна. Сургууль завсардсан хүүхдийн тоо харьцангуй өндөр байдаг 17 орноос Бангладеш, Бразил, Энэтхэг гэсэн зөвхөн 3 улс 2015 он гэхэд боловсролд хамрагдалтын хэмжээг 97% давсан үзүүлэлтэд хүргэхээр байна (График 4).

Өнгөрсөн хугацаанд хийсэн судалгаа, төслүүдийн үр дүнд үндэслэн энэ графикийг гаргасан юм. Гэхдээ эдгээр тоо баримт нь эцэслэн гарах хугацаа болоогүй байна. Эдгээр нь зөвхөн төрийн бодлогоо зөв чиглүүлэхэд туслах юм. Хүүхдийн сургуульд хамрагдалтын байдлаар Балба, Танзаний БНУ, Этиоп зэрэг бага орлоготой зарим улс Нигери, Пакистан зэрэг баян орнуудаас ч илүү амжилтанд хүрсэн. Танзаны Нэгдсэн БНУ төрөөс авч хэрэгжүүлсэн зөв бодлогын ачаар 7 жилийн дотор сургууль завсардсан хүүхдийн тоог 1999 онд 3 сая гаруй байсныг 2006 онд 150000 хүрэхгүй болтол

График 4. Дараахи орнуудад 2006 оны байдлаарх сургууль завсардсан хүүхдүүдийн тоо болон 2015 оны төлөв байдал¹




¹ 2006 оны байдлаар сургууль завсардсан хүүхдүүдийн тоо 500.000-аас давсан гэсэн тоо баримт бүхий улс орнууд багтсан. Эх сурвалж: 2009 оны БНБ-ын Хяналт үнэлгээний Дэлхийн Тайлангийн Хүснэгт 2.4-ийг үзнэ үү.

Энэ хандлага цаашид хэвээр үргэлжилбэл, 2015 он гэхэд, судалгаанд хамрагдсан 134 оронд сургууль завсардах хүүхдийн тоо 29 саяас багагүй байх нь харагдаж байна.

1. Бангладеш, Буркина Фасо, Этиоп, Энэтхэг, Кени, Нигер, Балба болон Пакистан.

2. 2006 онд судалгаанд хамрагдсан 134 оронд дэлхийн сургуулиас завсардсан бүх хүүхдүүдийн буюу 75 сая хүүхдийн гуравны хоёр нь болох 48 сая хүүхэд амьдарч байна.

График 5. ЭЗХАХБ-ын орнуудад дээд боловсрол эзэмшсэн байдал болон хөгжиж буй орнуудад бага сургуулийн төгсөлтийн байдал хоорондын ялгаа



¹ Эдгээр орнуудын мэдээ баримт нь бага боловсрол эзэмших магадлал илүү өндөр эсвэл ижил байх бага сургуулийн төгсөх ангийн сурагчдад хамаатай болно. Эх сурвалж: 2009 оны БНБ-ын Хяналт үнэлгээний Дэлхийн Тайлангийн График 2.19-ийг үзнэ үү.

бууруулсан. Сургууль завсардсан нийт хүүхдийн 1/8 нь оногдож байгаа Нигери, мөн Пакистанд удирдлагын сул дорой байдал, санхүүгийн болон сурах нөхцөл боломжийн тэгш бус байдал өндөр байгаагаас ийм байдалд хүрч байна.

Бага сургуульд суралцах явц: Сургууль завсардалт, анги улиралт ба үргэлжлүүлэн суралцагчдын доогуур хувь

Хөгжиж буй олон оронд бага сургуульд тасралтгүй сурч, дүүргэх явдал зохих хэмжээнд хангагдахгүй байна. Анги улиран сурах явдал их байна. Судалгаанд хамрагдсан Өмнөд Сахарын 31 орноос 11-д нь 1 дүгээр ангид, 9-д нь 2 дугаар ангид улиран сурах хүүхдүүдийн тоо 20%-иас давсан байна. Бурунди, Камерун болон Коморын арлын орнуудад 1 дүгээр ангидаа улиран суралцах хүүхдүүдийн тоо 30% давжээ. Анги улиран суралцах нь төрөөс зардлыг хариуцахад улам ихээхэн хүндрэл учруулж байна. Улиран суралцагчдад Мозамбикт боловсролд зориулсан нийт төсвийн 12%, Бурундид 16%-ийг зарцуулж байна гэсэн тооцоо гарчээ. Латин Америк болон Карибын Тэнгисийн орнуудад улиран суралцагчдад жил бүр 12 тэрбум доллар зарцуулжээ. Түүнээс гадна, анги улиралт нь гэр бүлийн, ялангуяа ядуу гэр бүлийн ачааллыг ихээхэн хүндрүүлж, улмаар сургууль завсардах магадлалыг нэмэгдүүлж байна.

Бүх нийтэд бага боловсрол эзэмшүүлэхийн тулд улс орнууд боловсролд хамрагдалт болон төгсөлтийг нэмэгдүүлэх ёстой. Сургуульд хамруулах болон бага боловсролыг бүрэн эзэмшүүлэх гэсэн хоёр зорилго байна. 2000 оноос хойш зарим улс боловсролд



Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд тоглоомонд оролцож байгаа нь. Английн Нэгдсэн Вант улс

хамрагдалтын хэмжээг харьцангуй нэмэгдүүлсэн хэдий ч, үргэлжлүүлэн суралцагчдын тооны өсөлтөнд тэр бүр анхаарсангүй. Мадагаскарт бүх нийтээр боловсролд хамрагдах талаар багагүй амжилтанд хүрсэн хэдий ч бага сургуулиа бүрэн төгсч чадаагүй хүүхдийн тоо тэр хэмжээгээр буурсан байна. Балбад харин боловсролд хамрагдалтын хэмжээг эрс нэмэгдүүлж чадсан төдийгүй, энэ хэмжээгээр үргэлжлүүлэн сурах хүүхдийн тоо бас өссөн байна. Төгсөх ангид орно гэдэг нь түүнийг амжилттай дүүргэнэ гэсэн үг хараахан биш юм. Сенегалд бага сургуулийн насны хүүхдүүдийн дөнгөж 30% нь бага сургуулиа бүрэн төгсөж байна.

Харилцан адилгүй нөхцөл, боломж

Баян, ядуу орнуудад нөхцөл, боломжийн хувьд харилцан адилгүй байна. Канад, Япон зэрэг улсад 25-34 насны хүн амын тэн хагасаас илүү нь дээд боловсрол эзэмшиж байхад, Бангладеш, Гватемал зэрэг ядуу оронд бага сургуулиа ч төгсгөж чадахгүй байна. Францад дээд боловсрол эзэмших боломж Бенин, Нигер зэрэг улсын хүүхдүүд бага сургууль төгсөх нөхцөл, боломжоос 2 дахин илүү байна (График 5).

Улс орнуудын доторхи орлогын түвшин, оршин сууж буй газар нутаг, хэл, хүйсийн байдал, гарал угсаа зэргээс үүдэлтэй тэгш бус байдал нь улмаар боловсролд хүрэх боломж, нөхцөлийг тодорхойлоход нөлөөлж, бүх нийтэд бага боловсрол эзэмшүүлэх зорилтод саад учруулж болох юм.

- **Орлогын түвшнээс үүдэлтэй тэгш бус байдал.** Дэлхийн нэн ядуу Вьетнам, Индонез, Перу, Филиппин зэрэг улс оронд харьцангуй чинээлэг гэр бүлүүд бүх нийтээр бага боловсролд хамрагдаад байхад, нэн ядуу гэр бүлүүд үүнд хүрэх өдий байна. Улс орны амьдралын дундаж түвшин, сургуульд хамрагдалтын ерөнхий түвшнээс үл хамааран тухайн улс бүрийн харьцангуй чинээлэг гэр бүлийн 20%-д төрсөн хүүхдүүдийн сургуульд хамрагдалтын түвшин ойролцоо байна гэж судалгаанаас харагдаж байгаа нь сонин юм. Тухайлбал, хэдийгээр Нигер улсын амьдралын дундаж үзүүлэлт Энэтхэг улсыг бодвол нилээн доогуур хэдий ч тус 2 орны харьцангуй чинээлэг гэр бүлийн 20%-ийнх нь хүүхдүүдийн сургуульд хамрагдах хэмжээ адилхан байна.

Оруулга 3. Бүх нийтээр бага боловсролд хүрэх зорилт: амжилттай хэрэгжүүлж буй туршлагаас

Бүх нийтээр бага боловсролд хүрэх явцыг түргэсгэх тусгай тогтсон жор, төлөвлөгөө байдаггүй ч, энэхүү Тайланд зорилтоо амжилттай хэрэгжүүлж байгаа зарим орнуудын туршлагад үндэслэсэн 5 ерөнхий сургамжийг тодорхойлж байна:

- Улс төрийн хүчин зүтгэл, үр дүнтэй төлөвлөгөөнд тулгуурласан тодорхой тууштай зорилтуудыг дэвшүүлж тавих
- Тэгш байдлыг хангах асуудалд анхааралтай хандаж, ядуу болон бусад хүнд нөхцөлд амьдардаг хүүхдүүдэд нөлөөлөх бүтцийн тэгш бус хандлагыг бууруулах
- Тасралтгүй суралцах болон сургалтын үр шимийг онцгойлон анхаарч, боловсролын хүртээмжийг нэмэгдүүлэхийн зэрэгцээ чанарыг нь дээшлүүлэх
- Ядуурлын эсрэг тэмцэх хүчин чармайлтаа өргөжүүлэн бэхжүүлж, ядуу гэр бүлийг дэмжих
- Тэгш байдлыг хангах асуудалд хамааралтай бүхий л салбарын удирдлагыг бэхжүүлэх

3. 15-аас доош насны хүүхдүүд хөдөлмөр эрхлэх нь тэдний боловсрол эзэмших эрхийг боогдуулах төдийгүй бие болоод оюуны хөгжилд нь муугаар нөлөөлнө хэмээн Олон улсын Хөдөлмөрийн Байгууллагаас тодорхойлжээ.

Сургуульд хамрагдаагүй нийт хүүхдийн дийлэнх нь нэн ядуу гэр бүлд амьдарч байгаа болохоор, Дакарын зорилгод хүрэх аливаа оролдлогууд нь энэ бүлгийн хүүхдүүд рүү илүү чиглэгдэх ёстой.

- **Хот хөдөөгийн ялгаа.** Олон оронд хөдөө орон нутагт амьдарч байгаа хүүхдүүд хотын хүүхдүүдтэй харьцуулахад сургуульд хамрагдах магадлал бага, завсардах магадлал өндөр байдаг. Сенегальд хотын хүүхдүүдийн сургуульд хамрагдах магадлал хөдөөгийн хүүхдүүдээс 2 дахин өндөр байна. Энэ байдлыг гол төлөв ядууралтай, тэр дотроо түүнээс үүдэлтэй хүүхдийн хөдөлмөр, хүнс тэжээлийн хомсдолтой холбон тайлбарлаж байна.
- **Ядуусын хорооллынхонд тохиолддог тэгш бус байдал.** Ядуусын хороололд ядуурлын түвшин өндөр, хүүхдүүдийн эрүүл мэнд сул дорой, сургуульд хамрагдах боломж хязгаарлагдмал байдаг нь нийтлэг. Бенин, Нигер орнуудад ядуусын хорооллын хүүхдүүдийн сургуульд хамрагдалтын түвшин нь хотын бусад хүүхдүүдийнхээс бараг 20%-иар доогуур байна. Бангладеш, Гватемал зэрэг 6 улсад ядуусын хорооллын хүүхдүүдийн сургуульд хамрагдах түвшин хөдөө орон нутгийн хүүхдүүдийнхээс ч доогуур байна.
- **Хэлний асуудалтай холбоотой тэгш бус байдал.** Хэлний янз бүрийн бүлгүүдийн хооронд сургуульд хамрагдах болон сургалтыг бүрэн дүүргэхэд ихээхэн ялгаа гарч байна. Төрөлх хэлдээр явагддаг сургалт нь сургуульд хамрагдалтын хэмжээг нэмэгдүүлдэг болохыг саяхны судалгаа харуулж байна.

Бүх нийтээр бага боловсролд хүрэхэд учирч буй 3 саад: Хүүхдийн хөдөлмөр, эрүүл мэндийн сул дорой байдал, хөгжлийн бэрхшээл

Бүх нийтээр бага боловсролд хүрэхэд

улс орон бүрт янз бүрийн бэрхшээлүүд тулгардаг. Эдгээрийн дотор нийтлэг байдаг 3 асуудал бол:

- **Хүүхдийн хөдөлмөр.** Бага боловсролд хамрагдах болон түүнийг бүрэн дүүргэх явдлыг хангах нь хүүхдийн хөдөлмөрийг устгах асуудлыг хэрхэн шийдэж байгаатай холбоотой. 2004 оны байдлаар, ойролцоогоор 218 сая хүүхэд ажил хийж байгаагийн 166 сая нь 5-14 насны хүүхдүүд байлаа. Хүүхдийн хөдөлмөрийг мөлжих нь сурч боловсрох эрх төдийгүй, хүүхдийн хөдөлмөрийн тухай олон улсын Конвенцийг зөрчиж байгаа хэрэг мөн. Хүүхдийн хөдөлмөр эрхлэлт нь сургуульд оройтож элсэх, сургуульд хамрагдалтын хэмжээг бууруулах, эрт сургууль завсардах зэрэг хор уршигтай.
- **Хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн шалтгаан нь цогц шинжтэй:** Сургуулийн байршил хол байх, сургалт төлбөртэй байх, боловсролын чанар муу байх болон ядуу зүдүү амьдрал зэрэг нь хүүхдийг хөдөлмөр эрхлэхэд өөрийн эрхгүй хүргэж байгаа юм. Энэ асуудлыг шийдвэрлэхийн тулд сургалтын төлбөрийг чөлөөлөх, сургууль дээр сурагчдыг хооллох хөтөлбөрийг хэрэгжүүлэх болон бусад санхүүгийн боломжуудыг нэмэгдүүлэх практик арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх шаардлагатай байгаа юм. Гана, Камерун, Кени, Танзаний Нэгдсэн улс зэрэг улс оронд сургалтыг төлбөргүй болгосноор хүүхдийн хөдөлмөрийг мөлжих явдлыг бууруулж чадлаа.
- **Бүх нийтийн бага боловсролд хүрэхэд эрүүл мэндтэй холбоотой саад бэрхшээлүүд.** Дэлхий даяар сая сая хүүхэд өлсгөлөн, хоол тэжээлийн илчлэг муу, халдварт өвчин зэрэг шалтгаанаас болж зовж шаналж байгаа нь сургуульд хамрагдалт, суралцах явц болон сургуулиа бүрэн дүүргэх боломж зэрэгт муугаар нөлөөлж байна. Сургуулийн насны 60 сая гаруй

Сенегальд хотын хүүхдүүдийн сургуульд хамрагдах магадлал хөдөөгийн хүүхдүүдээс 2 дахин өндөр байна.

хүүхэд йодын дутагдалтай байгаа нь тэдгээрийн танин мэдэхүйн хөгжлийг хязгаарлаж байна. Ойролцоогоор 200 сая хүүхэд анеми буюу цус багадах өвчнөөр өвчилсөн нь тэдний анхаарал төвлөрөлтөнд нөлөөлж байна. Энэ нөхцөлд сургуульд чиглэгдсэн эрүүлийг хамгаалах хөтөлбөр, үйл ажиллагаагаар өөрчлөлт хийж болно. Кенид гэдэсний цагаан хорхойг эмчлэх зорилгоор сургуульд суурилсан нийтийг хамарсан аян өрнүүлснээр өвчний тархалтыг бууруулж чадсан бөгөөд ингэснээрээ хичээл таслалтыг 1/4-ээр багасгаж чаджээ. Түүнчлэн эрүүлийг хамгаалахад чиглэгдсэн бусад олон аян, арга хэмжээнүүд нь бүх нийтээр бага боловсролд хүрэх зорилтод ноцтойгоор саад учруулж байгаа ДОХ-оос урьдчилан сэргийлэхэд чухал нөлөө үзүүлж байна.

- **Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд.** 2008 оны 5-р сард хүчин төгөлдөр болж батлагдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тухай НҮБ-ын Конвенц нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн боловсрол эзэмших эрхийг дэмжин хамгаалсан эрхзүйн хамгийн сүүлийн баримт бичиг юм. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд өнөөдөр хамгийн шоовдорлогдсон бүлэгт урьдын адил орж, тэдний сургуульд хамрагдах боломж ч хамгийн бага байна. 6-11 насны хөгжлийн бэрхшээлтэй болон жирийн хүүхдүүдийн хооронд сургуульд хамрагдах хэмжээ, жишээ нь Энэтхэгт 10%, Индонезид бараг 60%-ийн зөрөөтэй байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн хувьд сургуульд хамрагдан суралцахад сургуулийн байршил, тэдний нөхцөлд тохирсон сургуулийн барилга, тоног төхөөрөмжийн зохион байгуулалт болон тусгайлан бэлтгэгдсэн багш нар дутагдалтай байдаг зэрэг нь тэдний сурч боловсроход саад болж байна. Ноцтой саад болж байгаа бас нэг зүйл бол хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хандах сөрөг хандлага юм. Төрийн удирдлагын зүгээс дээрх саад бэрхшээлүүдийг шийдвэрлэж,

сургалтыг аль болох хүртээмжтэй болгох, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хандах нийгмийн хандлагыг өөрчлөх зайлшгүй шаардлагатай байна. Уганда улсын сайхан жишээг дурьдвал, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг Үндсэн хуулиар баталгаажуулж, дохионы тэмдэгтүүдийг тэдний албан ёсны хэл болгон хүлээн зөвшөөрч, сонсголын согогтой хүүхдүүдийн сургалтанд зохих дэмжлэг туслалцаа үзүүлэх замаар тэднийг сургуульд хамруулан сургаж байна.

Дунд боловсрол болон түүний дараагийн боловсрол: зарим ололтууд

Дунд боловсролд хамрагдах хүрээ ерөнхийдөө өргөжиж байна. 2006 онд дэлхийн хэмжээнд, 513 сая хүүхэд дунд сургуульд бүртгэгдсэн нь 1999 онтой харьцуулахад 79 саяар нэмэгджээ. Дунд боловсролд хамрагдсан дэлхийн дундаж үзүүлэлт бүс нутаг, улс орнуудын дотор нилээд ялгаатай байсан хэдий ч 52%-иас 58% хүртлээ өслөө.

Хөгжингүй болон шилжилтийн үеийн ихэнх орнууд бүх нийтийн боловсролын зорилгодоо хүрэхэд ойртож байна. Гэтэл хөгжиж буй бүс нутгуудад байдал янз бүр байна. 2006 оны байдлаар, Өмнөд Сахарын орнуудад дунд боловсролд хамрагдсан үзүүлэлт дөнгөж 25%, Өмнөд болон Баруун Азид 45%-тай байв. Дунд боловсролын эхний шатнаас дараагийн ахлах шатанд шилжих явцад улс орнуудын боловсролын янз бүрийн олон системд сурагчид сургуулиа орхих явдал элбэг байдаг. Ялангуяа, Зүүн Ази, Латин Америк, Карибын тэнгисийн орнууд, Арабын орнууд, Өмнөд Сахарын орнуудад энэ үзэгдэл илүү харагдаж байна. Дэлхийн хэмжээнд авч үзвэл, 2006 онд хамран сургалтын бохир жин дунджаар дунд боловсролын эхний шатанд (78%) дараагийн ахлах шатнаасаа (53%) харьцангуй өндөр байлаа.

Улс орон доторхи дунд боловсролд хамрагдалтын ялгаа нь улс орон хоорондын

ялгаанаас ч илүү тод мэдрэгдэж байна. Дунд боловсролд хамрагдах байдал болон үргэлжлүүлэн суралцах явдал нь орлогын түвшин, сургалт явуулах хэл зэрэг хүчин зүйлээс шалтгаалан ялгаатай байна. Ихэнх хөгжиж буй оронд дунд боловсролыг бүрэн гүйцэд эзэмших магадлал нэн ядуу гэр бүлийн хүүхдүүдийн хувьд хамгийн бага байдаг. Мозамбикт 16-49 насны, Португал хэлээр ярьдаг бүх хүний 43% нь дунд сургуулийн дор хаяад дунд боловсролын нэг ангийг дүүргэсэн байхад, харин нутгийн аялга, хэлээр ярьдаг хүмүүсийн дөнгөж 6-16% нь л тэр хэмжээний боловсролыг эзэмшиж байна.

Дакарын Бага хурлаас хойш дээд боловсрол эзэмших явдал хурдацтай өссөн. 2006 онд дэлхийн хэмжээгээр, дээд сургуульд 144 сая оюутан элсэн орсон нь 1999 онтой харьцуулахад 51 сая орчмоор өссөн байна. Дээд сургуульд суралцагчдын тоо нь 1999 онд 47 сая байсан бол, 2006 онд 85 сая хүртлээ өссөн хөгжиж буй орнуудын дээд боловсролын байгууллагуудад их хэмжээний орон тоо бий болсон байна. Хэдийгээр түргэн өсөлттэй байгаа хэдий ч дэлхий нийтээр авч үзвэл ихээхэн ялгаа зөрүү байсаар байна. Дээд боловсролд хамран сургалтын бохир жин Хойд Америк, Баруун Европоос Латин Америкийг хамарвал 70%-иас 32% хүртэл, Арабын Улсуудад 22%, Өмнөд Сахарын орнуудад 5% байна. Хэдийгээр энэ их ялгаа нь зөвхөн тоон үзүүлэлт талаас нь авч үзэж байгаа болохоос чанарын ялгааг мөн авч үзэх нь чухал юм. Долларын ханшаар Францийн их дээд сургуулиудийн нэг оюутанд 2004 онд Перу юмуу Индонезоос 16 дахин их мөнгө зарцуулжээ.

Насанд хүрэгчдийн бичиг үсгийн боловсрол: Одоо ч үл ойшоосоор байна

Зорилт 4. 2015 он гэхэд, насанд хүрэгчид, ялангуяа эмэгтэйчүүдийн бичиг үсгийн боловсролын түвшинг 50%-иар дээшлүүлж, бүх насанд хүрэгчдэд суурь болон тасралтгүй боловсрол олгоход адил тэгш хамруулах.

Оруулга 4. Залуучууд, насанд хүрэгчдийн насан туршдаа сурч боловсрох хэрэгцээ шаардлагыг хангах

Зорилго 3: Бүх залуучууд, насанд хүрэгчдийг зохих шатны сургалтанд адил тэгш хамруулж, амьдралын наад захын чадвар дадлыг олгох замаар тэдний хэрэгцээ шаардлагыг хангах

Зорилго 4. 2015 он гэхэд, насанд хүрэгчид, ялангуяа эмэгтэйчүүдийн бичиг үсгийн боловсролын түвшинг 50%-иар дээшлүүлж, бүх насанд хүрэгчдэд суурь болон тасралтгүй боловсролд адил тэгш хамрагдах боломж олгоно.

Насанд хүрэгчдэд зориулсан сургалтын хөтөлбөрүүд ихээхэн хангалтгүй байна. Дэлхийн хэмжээгээр, сургуулийн боловсролд хамрагдаагүй олон сая залуучууд, 776 сая гаруй насанд хүрэгчид бичиг үсгийн суурь боловсролыг эзэмшээгүй, насан туршдаа сурах боломж байхгүй юмуу, бараг байхгүй, амьдралын наад захын чадвар дадалд сураагүй байна. Олон улсын засгийн газрууд өөрийн бодлого, стратегитээ албан бус боловсролд тэргүүлэх ач холбогдол өгөхгүй, хэрэгжүүлж байгаа хөтөлбөрүүдийг зохицуулах талаар онцгой хүчин чармайлт гаргахгүй, насанд хүрэгчдэд зориулсан сургалтын хөтөлбөрүүдийг төрөөс санхүүжүүлэхэд бага хэмжээний зардал гаргаж байна. "Насанд хүрэгчдийн боловсрол", "амьдрах ухаан", "албан бус боловсрол" зэрэг ойлголтууд нь ямагт тодорхой бус, янз бүрээр тайлбарлагдсан байдаг. 2008 оны БНБ-ын хяналт үнэлгээний тайланд албан бус боловсролын 30 орчим тогтолцоог дэлгэрэнгүй авч үзэж, орон орны гол гол ялгаатай зүйлийг олж тогтоосон байна. Мексик, Балба, Сенегал зэрэг улсад албан бус боловсролыг үндсэндээ насанд хүрэгчдийн боловсрол байдлаар үзэж байна. Бангладеш, Индонез зэрэг улсад албан бус боловсролын нэмэлт хөтөлбөр байдлаар илүү уян хатан, олон янзын хэмээн нэлээд өргөн хүрээнд авч үзэж байна. Ийнхүү янз бүрийн хандлагууд нь энэ зорилтын хэрэгжилтэнд тогтмол хяналт үнэлгээ тавихад бэрхшээл учруулж байна.

Зорилгоо илүү тодорхой болгох, мэдээллийн урсгалыг сайжруулах, насан туршдаа сурах нөхцөлийг хангахад бодлогын хэмжээнд зоригтой алхам, хүчин зүтгэл гаргахын төлөө шийдвэртэй тэмцэх хэрэгтэй байна. Илүү үр өгөөжтэй мэдээлэл цуглуулах, хяналт, шалгалт хийхийн тулд эхний ээлжинд янз бүрийн байгууллагууд насанд хүрэгчдийн боловсролын хэрэгцээг хэрхэн тодорхойлж байгаа, ямар бүлгүүдэд чиглэгдэж байгаа, ямар төрлийн чадвар дадлуудыг эзэмшүүлж байгаа, хөтөлбөр хэрхэн хэрэгжиж байгаа, санхүүгийн одоогийн эх сурвалжуудыг ашиглахад тогтвортой байж чадаж байгаа талаар үнэн зөв, нягт нямбай мэдээллийг олж авах шаардлагатай.

Хэрхэн уншиж, бичиж сурах нь өнөөгийн нийгэмд амьдрахад чухал ач холбогдолтой. Энэхүү дадал чадвар нь насан туршдаа сурахад хамгийн гол хүчин зүйл бөгөөд цаашилбал, хүүхдийн эндэгдлийг бууруулж, эрүүл мэндийг сайжруулж, хөдөлмөр эрхлэх боломжийг

Дэлхийн насанд хүрэгч хүн амын 16% буюу 776 сая насанд хүрэгчид урьдын адил бичиг үсгийн боловсрол эзэмших эрхээ эдэлж чадахгүй байгаа бөгөөд үүнээс бараг 2/3 нь эмэгтэйчүүд байна гэсэн тооцоо гарчээ.

Бодит тоон үзүүлэлтээр, дэлхийн хэмжээний бичиг үсэг үл мэдэгч насанд хүрэгчдийн 80% нь зөвхөн 20 оронд, түүний тэн хагас нь Бангладеш, Энэтхэг, Хятад улсад амьдарч байна.


нэмэгдүүлнэ. Гэхдээ бичиг үсэгтэн болох зорилгод урьдын адилаар бага анхаарч байна. Дэлхийн насанд хүрэгч хүн амын 16% буюу 776 сая насанд хүрэгчид урьдын адил бичиг үсгийн боловсрол эзэмших эрхээ эдэлж чадахгүй байгаа бөгөөд үүнээс бараг 2/3 нь эмэгтэйчүүд байна гэсэн тооцоо гарчээ. Бичиг үсэг үл мэдэгч насанд хүрэгчдийн дийлэнх нь Өмнөд болон Баруун Ази, Өмнөд Сахарын орнуудад амьдарч байна.

Бичиг үсэгтэн болох зорилтын явц дэлхий даяар хангалтгүй байна. 1984-1994, 2000-2006 оны хооронд бичиг үсэг үл мэдэгч насанд хүрэгчдийн тоо, гол нь БНХАУ-д бичиг үсэг үл мэдэх явдлыг эрс бууруулсантай холбоотойгоор бараг 100 саяар буурсан. Гэтэл, Өмнөд Сахар, Номхон далайн орнууд, Арабын улсуудад бичиг үсэг үл мэдэгч насанд хүрэгчдийн тоо нийт хүн амын өсөлттэй холбоотойгоор нэмэгдсэн. Энэ хандлага хэвээр үргэлжилбэл, 2015 он гэхэд 700 гаруй сая насанд хүрэгчид бичиг үсгийн суурь мэдлэг эзэмшиж чадахгүй нь (График 6).

Бодит тоон үзүүлэлтээр, дэлхийн хэмжээний бичиг үсэг үл мэдэгч насанд хүрэгчдийн 80% нь зөвхөн 20 оронд, түүний тэн хагас нь Бангладеш, Энэтхэг, Хятад улсад амьдарч байна. 1985-1994 оноос хойш бичиг үсэг үл мэдэгчдийн тоо Алжир, Египед, Энэтхэг, Индонез, Ираны Исламын БНУ, Хятад, Турк зэрэг улсад үлэмж хэмжээгээр буурсан хэдий ч ахиц дэвшил бага харагдаж байна. 1985-1994, 2000-2006 оны хооронд насанд хүрэгчдийн бичиг үсгийн боловсролын дэлхийн түвшин 76%-иас 84% болтлоо өслөө. Хөгжиж байгаа орнуудад 68%-иас 79% болтлоо өсчээ. Ингэснээр бараг бүх бүс нутагт энэ үзүүлэлт өслөө. Гэтэл Өмнөд Сахар, Өмнөд ба Баруун Ази, Карибийн тэнгисийн орнууд, Арабын улсуудад насанд хүрэгчдийн бичиг үсгийн боловсролын бүс нутгийн үзүүлэлт хөгжиж байгаа орнуудын дундаж түвшнээс доогуур хэвээр байна.

Мэдээнд хамрагдсан 135 орны 45-д нь гол төлөв Өмнөд Сахар, Өмнөд болон Баруун Азийн орнуудад насанд хүрэгчдийн бичиг үсгийн боловсролын түвшин хөгжиж

График 6. 2015 оны байдлаарх 15-аас дээш насны бичиг үсэг үл мэдэгч хүмүүсийн тооны төлөв байдал, хүйсээр болон бүс нутгаар



Эх сурвалж: 2009 оны БНБ-ын Хяналт үнэлгээний Дэлхийн Тайлангийн Хүснэгт 2.11-ийг үзнэ үү.

байгаа орнуудын дундаж үзүүлэлт 79%-иас доогуур байна. Тэдгээр орнуудын 19-д нь бичиг үсгийн боловсролын түвшин маш доогуур, 55%-д хүрэхгүй байна. Тэдгээрийн 13-д нь туйлын ядууралтай байгаа бөгөөд хүн амынх нь $\frac{3}{4}$ -с доош хувь нь өдөрт 2 хүрэхгүй доллараар амьдарч байна. Одоогийн энэ хандлагаар бол эдгээр 45 орны цөөхөн хэсэг нь 2015 он гэхэд насанд хүрэгчдийн бичиг үсгийн боловсролын зорилгодоо хүрэхээр байна.


Дэлхийн хэмжээнд 15-24 насны, бичиг үсгийн боловсрол эзэмшээгүй залуучуудын тоо 1985-1994 онд 167 сая байсан бол, 2000-2006 онд 130 сая болтлоо буурсан байна. Нийт хүн амын өндөр өсөлт, сургуульд хамрагдах түвшин мөн түүнийг бүрэн дүүргэх үзүүлэлтийн түвшин ямагт доогуур байдаг зэргээс шалтгаалан бичиг үсэг үл мэдэгч залуучуудын тоо 7 саяар өссөн Өмнөд Сахарын эс тооцвол бичиг үсгийн бодит тоон үзүүлэлт ихэнх бүс нутгуудад нэмэгджээ. Дэлхийн хэмжээнд залуучуудын бичиг үсгийн боловсролын түвшин энэ хугацаанд 84%-иас 89% болтлоо өссөн нь Өмнөд Сахар, Өмнөд болон Баруун Ази, Карибийн Тэнгис, Арабын улсуудад мэдэгдэхүйц нэмэгдсэнтэй холбоотой.

Бичиг үсэг үл мэдэх явдал болон бичиг үсгийн боловсролын үзүүлэлт доогуур байгаа асуудал бол зөвхөн ядуу орнуудад байгаа юм биш. Нидерландад 1,5 сая орчим насанд хүрэгчид бичиг үсгийн мэдлэг хангалтгүй гэсэн бүлэгт хамрагдаж байгаа бөгөөд тэдгээрийн 1 сая орчим нь төрөлх Голланд хэлээр ярьдаг нутгийн иргэд байна. Төрөлх Голланд хэлээр ярьдаг иргэдийн $\frac{1}{4}$ нь бараг огт бичиг үсгийн чадваргүй байна. 2004-2005 оны үнэлгээгээр Францын томоохон хотуудад хөдөлмөр эрхлэх насны (18-65 нас) насанд хүрэгчдийн 9% нь (3 сая гаруй хүн) сургуульд суралцсан хэдий ч бичиг үсгийн боловсролын асуудалтай хэвээр байна. Тэдний 59% орчим нь эрэгтэйчүүд байсан. Бичиг үсгийн боловсролын чадвар муутай Францын ихэнх хүмүүс 45-аас дээш насныхан ба тэдний тэн хагас нь хөдөөгийн буюу алслагдсан газар нутгуудад амьдардаг гэсэн судалгаа гарчээ.

Бичиг үсгийн боловсрол, тэгш бус байдал ба алагчлахуй

Улс орнуудын хооронд үндэсний бичиг үсгийн боловсролын түвшин ихээхэн ялгаатай байна. Хүйс, ядуурал, амьдран суугаа газар нутаг, гарал угсаа болон хэлний бүлгүүд зэрэг нь мөн адил бичиг үсгийн боловсролын түвшингийн ялгааг гүнзгийрүүлж байна.

- Насанд хүрэгчдийн бичиг үсгийн боловсрол дахь **хүйсийн ялгаатай байдал** нь, ялангуяа бичиг үсгийн түвшин доогуур байгаа улс орнуудад ихээхэн харагдаж байна. Хүйсийн ялгаа, ядуурал хоёр үргэлж нэг нэгнээсээ хамааралтай байдаг. Гамбиад хамгийн ядуу эмэгтэйчүүдийн бичиг үсгийн боловсролын түвшин 12% байхад хамгийн баян эрэгтэйчүүдийн түвшин 53% хүртэл ялгаатай байна.
- Өмнөд Сахарын насанд хүрэгчдийн бичиг үсгийн боловсролын түвшин



Бага сургуулийн багш сурагчиддаа тусалж байгаа нь

хамгийн багад тооцогддог 7 оронд хамгийн ядуу, хамгийн баян гэр бүлүүдийн хоорондахь бичиг үсгийн боловсролын ялгаа 40%-иас илүү байна. Хамгийн ядуу орнуудаас Энэтхэг бичиг үсгийн боловсролын түвшингээр хамгийн доогуурт ордог.

- Бичиг үсгийн боловсролын түвшин хөдөө, орон нутагт хотынхоос ямагт доогуур байдаг. Этиоп орны хувьд бичиг үсгийн боловсролын түвшин Аддис Абаба бүс нутгуудад 83%-тай байхад хөдөөгийн Амхара бүс нутагт дөнгөж 25% байна.
- Нутгийн уугуул иргэдийн бичиг үсгийн боловсролын түвшин уугуул бус иргэдээс доогуур байх нь нийтлэг.

Боловсрол дахь хүйсийн тэнцвэргүй байдал болон тэгш бус байдлыг үнэлэх нь

Зорилт 5: 2005 он гэхэд бага, дунд боловсролын хүрээнд хүйсийн тэнцвэргүй байдлыг арилгах ба 2015 он гэхэд боловсрол дахь хүйсийн тэгш байдлыг баталгаажуулан хангах, ингэхдээ охидууд чанартай суурь боловсролыг бүрэн дүүрэн, тэгш хүртээмжтэйгээр эзэмших явдалд илүү анхаарал хандуулна.


Дэлхий даяар хүйсийн тэгш байдлыг хангахад ахиц дэвшил гарсаар байгаа хэдий ч олон орон энэ зорилтыг биелүүлэхэд бас л хол байна. 2006 онд судалгаанд хамрагдсан 176 орны зөвхөн 59 нь бага болон дунд боловсролын түвшинд хүйсийн тэнцвэртэй байдлыг хангаж чадсан⁴. Энэ нь 1999 онтой харьцуулахад 20-иор нэмэгдсэн ч, энэхүү баримтаас харахад эдгээр орнуудын хагасаас илүү нь тэгш байдалд хүрч чадаагүй нь анхаарлын төвд хэвээр байна.

4. Хүйсийн тэнцвэрт байдлын (ЖТБ) үзүүлэлт нь эрэгтэй эмэгтэй сурагчдын хамралтын тооны харьцааг харуулна. Хэрэв 97-103 эмэгтэй сурагчид 100 эрэгтэй сурагчдад ногдох байвал хүйсийн тэнцвэрт байдал хангагдана (СХБЖ-ийн ЖТБ 0.97-1.03 хувьтай байна).

Бага боловсрол: жинтэй амжилт гарсан хэдий ч зарим улс орон хүйсийн тэнцвэрт байдалд хүрэхэд өдий байна.

Мэдээнд орсон 187 орны ойролцоогоор 2\3 нь 2006 он гэхэд бага боловсролын хүрээнд хүйсийн тэнцвэрт байдалд хүрч чадсан боловч үлдсэн 71 орны ихэнх нь 1999 оноос хойш амжилт дэвшил гаргасан байна (График 7). Сургуульд хамрагдалтын нийт хэмжээн дэх хүйсийн тэнцвэрт байдлын үзүүлэлт 1999 оноос 2006 оны хооронд 0.84-0.95 хүртэл өссөн Баруун болон Өмнөд Азийн олон орнуудад гайхалтай амжилт гарсан (Өөрөөр хэлбэл 100 эрэгтэй сурагч тутамд 84-өөс 95 охид ногдож байна). Бутан, Энэтхэг, Балба зэрэг орнууд бүгд бага боловсролын түвшинд хүйсийн тэнцвэрт байдлыг хангаж чадсан ба хангахад ойрхон байна. Тэгсэн хэдий ч Пакистанд бага сургуулийн хүрээнд 100 эрэгтэй сурагч тутамд зөвхөн 80 эмэгтэй сурагч ногдож байна. Өмнөд Сахарт хүйсийн тэгш байдлыг хангах явдал удаан бөгөөд жигд биш явж байна. Тус

График 7. Бага болон дунд сургуульд нийт хамрагдалтан дахь хүйсийн тэнцвэрт бус байдлын өөрчлөлт, 2006 оны байдлаар, бүс нутгаар



Эх сурвалж: 2009 оны БНБ-ын Хяналт үнэлгээний Дэлхийн Тайлангийн График 2.33, Хавсралт, Статистикийн хүснэгт 5-ыг үзнэ үү.

Өмнөд Сахарын ихэнх улс, Өмнөд ба Баруун Азийн улсууд, Арабын орнуудад 2006 оны байдлаар хүйсийн тэгш байдал хангагдаагүй бөгөөд дурдсан улсуудын ихэнхи нь энэ зорилтод хүрэх хол байна.

бүс нутгийн хүйсийн тэнцвэрт байдлын үзүүлэлт 1999 онд 0.85 байснаа 2006 онд 0.89 болж өссөн. Гэвч Котдвуарь, Нигер, Мали, Төв Африкийн Бүгд Найрамдах Улс, Чад зэрэг улсад 100 эрэгтэй сурагч тутамд 80 хүрэхгүй эмэгтэй сурагч ногдож байна. Нөгөө талаар Гана, Кени, Танзаний Нэгдсэн Улс зэрэг нэлээд олон улсад бага боловсрол дахь хүйсийн тэнцвэрт байдал хангагдсан байна. Хэдийгээр ийм ахиц байгаа боловч Өмнөд Сахарын ихэнх улс, Өмнөд ба Баруун Азийн улсууд, Арабын орнуудад 2006 оны байдлаар хүйсийн тэнцвэрт байдал хангагдаагүй бөгөөд дурдсан улсуудын ихэнхи нь энэ зорилгод хүрэхэд хол байна.

Ихэнх улсад бага сургуульд сурч байгаа эмэгтэй сурагчид эрэгтэй сурагчдаас сайн суралцаж байна. Тэд нар анги улирах нь бага ангид дэвшин суралцаж, бага сургуулиа төгсөх нь илүү их байна. 2006 оны судалгааны материалаас үзэхэд 146 орноос 114 орны анги улирсан эмэгтэй хүүхдийн тоо эрэгтэй сурагчдынхаас бага байна. 2005 оны байдлаар Афганистанд сургуульд орж байгаа 100 эрэгтэй хүүхэд тутамд 70-аас цөөн эмэгтэй хүүхэд ногдож, бага сургуульд улиран суралцагчдын үзүүлэлтийг хувиар илэрхийлвэл эмэгтэй сурагчид 14%, эрэгтэй сурагчид 18% байна. 2005 оны материалаас үзвэл 115 улсаас 63 улсад сургуулиа төгссөн эрэгтэй, эмэгтэй сурагчдын тоо адилхан байна. Үлдсэн 52 орноос 36-д нь хүйсийн тэнцвэрт бус харьцаа хэвээр үлдэж, харин сургуулиа төгссөн эмэгтэй сурагчдын тоо илүү байна.

Дунд болон дээд боловсрол дахь хүйсийн тэнцвэрт бус байдал: янз бүрийн харьцаа, төрөл бүрийн бүтцийн онцлогууд

Дунд боловсролд хамран сургах цар хүрээ нэмэгдэж, Өмнөд Сахарын улсуудаас бусад бүх бүс нутагт хүйсийн тэгш бус байдал багасаж байна. Гэвч 2006 он гэхэд судалгаанд хамрагдсан улсуудын зөвхөн 37 хувьд дунд боловсролд хүйсийн тэнцвэрт байдал хангагдсан байна. Дэлхийн хэмжээнд авч үзвэл, зарим улс орнууд

охидуудын эрхийг илүү дээдэлсэн байхад заримд нь эрэгтэй сурагчдад илүү чиглэсэн байна.

Өндөр хөгжилтэй болон шилжилтийн эдийн засагтай орнуудын хувьд дунд боловсролын түвшинд тэнцвэрт байдал хангагдсан бол хөгжиж буй орнуудыг бүлэг болгон үзэхэд энэ үзүүлэлт 2006 оны дэлхийн дундаж түвшин болох 100 эрэгтэй сурагч тутамд 94 эмэгтэй сурагч ногдож байгаа үзүүлэлтээс доогуур байна. Дунд боловсролд хамрагдагсдын тоо болон хүйсийн тэнцвэрт байдлын аль аль нь Арабын орнууд, Өмнөд болон баруун Азийн улсууд, Өмнөд Сахарын орнуудад доогуур байна. Харин Латин Америк, Карибийн тэнгис орчмын ихэнх оронд дунд сургуульд, ялангуяа дунд боловсролын ахлах ангид эрэгтэйчүүдээс олон эмэгтэй сурагчид суралцаж байна. Латин Америкийн орнуудад эрэгтэй хүүхдүүд хичээл сургуульдаа муу явдгийн шалтгаан нь нийгэм эдийн засгийн онцлог, хөдөлмөр эрхэлдэг, сургуульд хүйсээр ялгаварладаг зэрэг болж байна.

Улсын түвшинд авч үзвэл дунд сургуулийн хүйсийн тэнцвэрт бус байдал судалгаанд хамрагдсан 142 орны хагасаас илүүд нь багассан байна. Нэлээд улсад бахдам ахиц дэвшил гарсан. Бенин, Гамби, Гвинэй, Иемен, Кампуч, Балба, Того, Уганда, Чад зэрэг улсад хүйсийн тэнцвэртэй байдал 20 гаруй хувиар нэмэгдсэн байна. Бангладеш улсын төрийн бодлого, өөрчлөлт нь бүх нийтийн боловсролд хүйсийн тэнцвэрт байдлыг хангах зорилт хугацаанаасаа өмнө биелэхэд чухал нөлөө үзүүлсэн. (Оруулга 5) Зарим улс орнуудад дунд боловсролд хамрагдах эмэгтэйчүүдийн оролцоо багасч, Аргентин, Грузин, Молдова, Сальвадор, Тунис зэрэг зарим улсад эрэгтэйчүүдийг илүү анхаарч хүйсийн тэнцвэрт байдал алдагдах явдал ихэссэн байна.

Дэлхийн хэмжээнд авч үзэхэд эрэгтэйчүүдээс илүү эмэгтэйчүүд дээд боловсрол эзэмшиж байна. Хүйсийн тэнцвэрт байдлын үзүүлэлт 1999 онд 0.96 байсан бол 2006 онд 1.06 болж өсчээ. Гэвч бүс нутаг бүрийн хувьд харилцан

Мали улсад баян чинээлэг гэр бүлээс гаралтай эмэгтэй хүүхдүүдийн сургуульд сурах магадлал ядуу гэр бүлээс гаралтай хүүхдүүдээс 4 дахин их, дунд сургуульд 8 дахин их байна.

адилгүй байна. Хөгжиж байгаа орнуудын хувьд ч байдал өөр өөр байна. Дээд боловсрол эзэмшихэд эмэгтэйчүүдийн оролцоо Карибийн тэнгисийн бүс (1,69), Номхон далайн бүс нутагт (1.31) хамгийн их, Өмнөд буюу Баруун Ази (0.76), Өмнөд Сахарын орнуудад нэлээд доогуур (0.67) байна. 2006 оны байдлаар зарим улсад дээд сургуульд суралцаж байгаа 100 эрэгтэй хүн тутамд 30 хүрэхгүй эмэгтэй ногдож байна.

Тухайн улс доторх хүйсийн тэгш бус байдал

Бага болон ялангуяа дунд боловсрол дахь хүйсийн тэнцвэрт бус байдал нь ядууралтай хамгийн их холбоотой байна. Жишээлбэл, Мали улсад баян чинээлэг гэр бүлээс гаралтай эмэгтэй хүүхдүүдийн сургуульд сурах магадлал ядуу гэр бүлээс гаралтай хүүхдүүдээс 4 дахин их, дунд сургуульд 8 дахин их байна.

Оруулга 5: Бангладешийн гайхамшигт ололт: 2005 он гэхэд хүйсийн тэгш байдалд хүрсэн нь

Бангладеш нь 2005 он гэхэд бага болон дунд боловсролд хүйсийн тэгш байдалд хүрсэн цөөн орнуудын тоонд орох бөгөөд Өмнөт болон Баруун Азийн тийм үр дүнд хүрсэн Шри-Ланкийг эс тооцвол цорын ганц улс юм. Үүнд зүй ёсны удирдлага чухал үүрэг гүйцэтгэснээс гадна охидуудын хичээл сургуульдаа хамрагдах нөхцлийг бүрдүүлсэн тэтгэлэгт хөтөлбөрүүд ач холбогдлоо өгчээ. Охидын дунд боловсролын түвшин дээшилсэн нь нийгмийн амьдралын бусад салбарт эерэг нөлөө үзүүлж, ингэснээрээ хүүхдийн эндэгдлийг бууруулах, хоол тэжээлийн хангамжийг сайжруулах, эмэгтэйчүүдийг илүү цалин хөлстэй ажлын байраар хангах боломжийг нэмэгдүүлсэн юм.

Мөн орлогын түвшин янз бүр байх нь нийгэм эдийн засаг, соёлын хүчин зүйлийн охидуудад үзүүлэх тааламжгүй нөлөөг улам нэмэгдүүлж байна. Тухайн улсыг бүхэлд нь хамруулсан судалгаанаас үзэхэд уугуул оршин суугчид, үндэсний цөөнх, газар зүйн хувьд тусгаарлагдсан хэсгийн оршин суугчид энэ талаар таагүй нөхцөлд орж байна. Гватимали улсад уугуул оршин суугч охидын сургуульд хамрагдах магадлал бусад үндэстний хэсгийн охидоос бага

байна. Тэдгээр 7 настай охидын дөнгөж 54 хувь нь сургуульд хамрагдаж байхад уугуул биш оршин суугч үндэстний охидын 75 хувь нь сургуульд хамрагдаж байна. Ийнхүү охидод тохиолдож байгаа тэгш бус байдлыг даван туулахын тулд улс төрийн удирдагчдын анхаарал, хууль тогтоомжийн зохицуулалт бүхий онцгой арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Боловсрол дахь хүйсийн тэнцвэрт байдлыг хангах нь хэцүү зорилт болж байна.

БНБ-ын хүйсийн талаарх зорилт. 2005 он гэхэд суурь болон дунд боловсролд хүйсийн тэнцвэрт бус байдлыг арилгах зорилтын хамт 2015 он гэхэд боловсрол дахь тэгш байдлыг хангахыг чухалчилж байна. Ингэхдээ чанартай суурь боловсролд бүрэн, тэгш хүрэх, ялангуяа охидын амжилттай боловсрол эзэмшихэд онцгойлон анхаарлаа хандуулах учиртай. Энэ бол хүйсийн тэнцвэрт байдлыг хангах аас ч түвэгтэй зорилт гэдгийг сургалтын үзүүлэлт, сургуулийн практикт хийсэн судалгаа нотолж байна.

Хичээлийн сонголт ба сурлагын амжилт: Хүйсийн тэнцвэрт бус байдал хадгалагдаж байна. Охид хөвгүүд сургалтын ерөнхий амжилтаараа төдийгүй тухайн нэг хичээлийн хувьд ч адилгүй амжилт гаргадаг. Сурагчдын сурлагын дүн хүйсийн ялгааг харуулдаг. Эдгээр ялгаануудаас 4 онцлог зүйлийг тодорхойлбол. Нэгдүгээрт: Янз бүрийн улс орнуудад охидууд унших дадлага, хэлний хичээлээр хөвгүүдээс илүү байдаг. Хоёрдугаарт: Уламжлалт хэлбэрээр бол бага ба дунд сургуульд хөвгүүд математикийн хичээлдээ охидоос илүү амжилт гаргадаг гэдэг боловч сүүлийн үеийн судалгаанаас үзэхэд охидууд энэ талаар гүйцэж, бүр түрүүлсэн амжилт гаргаж байгааг харуулж байна. Гуравдугаарт: Хөвгүүд байгалийн шинжлэлийн хичээлээр охидоос илүү сурдаг боловч энэ ялгаа бага байгаа юм. Эцэст нь: Дээд боловсролд зарим хичээлүүдэд ялангуяа байгалийн ба инженерийн шинжлэх ухааны хичээлүүдэд эрэгтэйчүүд давамгайлж байна. Судалгаанд хамрагдсан улс орнуудын тэн хагаст нь аль

хэдийнээс «эмэгтэй» гэж нэрлэгдэж ирсэн боловсрол, эрүүлийг хамгаалах, нийгэм халамжийн чиглэлээр суралцагчдын 2/3-оос илүү хувь нь эмэгтэйчүүд байна.

Судалгаанаас үзэхэд яагаад охидууд сурлагын амжилтаар өөр байдаг юм? Охид хөвгүүдийн сурлагын амжилт өөр өөр байдаг нь олон зүйлээс хамаардаг. Сурлагын дүн хүйсээс хамаарч өөр өөр байдагт сургалтын систем яаж зохион байгуулагдсан, ангид болж байгаа үйл явдал зэрэг нь тодорхой нөлөө үзүүлдэг. Хэрэв багш охид хөвгүүдэд ялгавартай харьцдаг бол энэ мэдээж хүйсийн тэгш бус байдал бий болж хөгжихөд нөлөөлнө. Мөн сурах бичиг ийм нөлөөлөл үзүүлж болох юм. Ихэнх улсуудын сурах бичгүүдэд хүйсийн нэг талыг барьж ялгаварласан, охид эмэгтэйчүүдэд хангалттай анхаарал хандуулаагүй, хүйсийн асуудлыг хуучирсан заншлаар авч үзсэн байдаг. Хэдийгээр илэрхий эр эмээр ялгаварлах байдал устсан ч энэ салбарт дэвшил удаан гарч, эмэгтэй хүнд тоомсор муутай хандсан сургалтын материал байсаар байна.

Сургалтын тэгш, шударга байдал болон чанарыг хангах нь

Зорилт 6: Хүлээн зөвшөөрөгдсөн, амжилттай сургалтын үр дүн, ялангуяа бичиг үсгийн, тоо бодох болон амьдрах ухааны чухал мэдлэг, ур чадварыг хүн бүрт эзэмшүүлэхийн төлөө боловсролын чанарыг бүх талаар сайжруулах

Бүх нийтийн боловсролын эцсийн зорилт бол хүүхдүүдэд амьдралаа улам баяжуулан тэлж, өөрсдийн боломжоо улам өргөжүүлэх болон нийгмийн амьдралд оролцоход шаардлагатай суурь чадварыг эзэмшүүлэх явдал юм. Үүнд тэдний боловсролын чанар гол үүрэг гүйцэтгэдэг.

Сургалтын үр дүн: улс орнуудын хоорондын ялгаа

Олон улс, бүс нутаг, үндэсний хэмжээн дэх сурагчдын сурлагын амжилтын үнэлгээнд хийсэн судалгаанаас үзэхэд ихэнх улсад хүүхдүүд зөвхөн хамгийн наад захын суурь

чадварыг эзэмшин сургуулиа төгсдөг байна. Хөгжиж буй орнуудад сургалтын түвшин хамгийн доогуур байна. 2007 онд Энэтхэгт явуулсан судалгаанаас үзэхэд 3 дугаар ангид сурч байгаа сурагчдын тэн хагас хүрэхгүй хэсэг нь энгийн текст уншиж чаддаг, зөвхөн 58 хувь нь хасах, хуваах үйлдэл хийж чаддаг байна. Зүүн Өмнөд Африкийн Боловсролын Чанарын Хяналт, Үнэлгээний Консорциум II⁵ (SACMEQ)-ийн дүгнэлтээс үзэхэд Ботсвани, Кени, Свазиланд, Өмнөд Африк зэрэг улсуудад 6 дугаар ангид суралцагсдын 25 хүрэхгүй хувь нь, Замби, Лесото, Малив, Мозанбик, Намбий, Уганда улсуудад зөвхөн 10 хүрэхгүй хувь нь уншихдаа хангалттай дүн үзүүлсэн байна. Бусад түвэгтэй хичээлүүдийн талаар бол бүр сэтгэл түгшүүлсэн дүнтэй байна. Саяхан Латин Америкийн улсуудад Бүсийн 2 дугаар харьцуулсан болон тайлбар судалгаа (SERCE)-ны дүнгээс үзэхэд Гватимал, Доминикан, Эквадор улсуудын 3 дугаар ангийн сурагчдын хагас нь унших чадвараар хамгийн доогуур байна. Хөгжилтэй ба хөгжиж буй орнуудын ялгаа маш их байна. 2006 оны байдлаар Бразил, Индонез, Тунис улсуудад суралцагсдын 60 хувь нь байгалийн шинжлэх ухааны хичээлээр хамгийн доогуур дүнтэй байхад Канад, Финлянд улсуудад ийм үнэлгээтэй сурагчдын тоо зөвхөн 10 хувь байна. 2006 онд хийсэн Олон улсын унших, бичих чадварыг судлах судалгаанаас үзвэл дунд ба түүнээс доогуур орлоготой Европын биш улсуудын 4 дүгээр ангид суралцагсдын унших чадвар олон улсын түвшингээс их доогуур байна. Энэ бол зөвхөн сургуульд сурч байгаа хүүхдүүдийн хувьд хийсэн дүгнэлт ба үүн дээр сургуульд хамрагдаагүй хүүхдийг нэмж оруулвал улам зөрүүтэй ялгаа гарна.

Үндэсний дундаж үзүүлэлтийн цаана юу нуугдаж байна вэ? Сургалтын амжилтын эрс ялгаатай байдал

Сурлагын амжилт тухайн улсын доторч харилцан адилгүй байна. Энэ нь ядуурал болон бусад сөрөг хүчин зүйлтэй холбоотой. Сургалтын чанар бүс нутаг, бүлэг, хамт олон, анги, сургуулийн аль

Олон улс оронд хүүхдүүд зөвхөн хамгийн наад захын суурь чадварыг эзэмшин сургуулиа төгсдөг байна.

5. 2009 оны БНБ-ын Хяналт үнэлгээний Дэлхийн Тайлангийн 2 дугаар бүлгээс илүү дэлгэрэнгүй мэдээлэл авах ба олон улсын болон үндэсний янз бүрийн сургалтын үнэлгээнүүдийн нэрсийг харж болно.

Бүх нийтийн боловсролын зорилтыг хангахын тулд Засгийн газрууд багш нарыг бэлтгэж, тоог нэмэгдүүлэх шаардлагатай байгаа юм.

ч түвшинд ялгаатай байна. 2006 онд явуулсан судалгаагаар Өмнөд Африкт 4 дүгээр ангийн хамгийн сайн сурлагатай сурагчдын 5 хувийн унших чадвар, хамгийн тааруу сурлагатай сурагчдын 5 хувийн унших чадвараас даруй 5 дахин илүү байв. Тухайн нэг улсын хувьд сурлагын амжилт өөр өөр байгааг сурагчдын суурь бэлтгэл, боловсролын тогтолцооны онцлог болон сургуулийн орчин нөхцөлтэй холбон тайлбарлах ёстой.

- **Сурагчдын суурь бэлтгэл.** Сурлагын амжилт нь хувь хүний авъяас чадвараас гадна хүйсийн ялгаа, нутгийн хэл, эцэг эхийн эрхэлдэг ажил, эзэмшсэн боловсрол, ам бүл, цагаачлалын статус зэрэг нийгэм, эдийн засаг, соёлын хүчин зүйлээс хамаардаг. Эдгээр хүчин зүйл нь сурагчдын сургуулиар олж авч байгаа мэдлэгийн хэмжээг үлэмж хэмжээгээр тодорхойлно.
- **Боловсролын систем.** Боловсролын системийн зохион байгуулалт нь сурлагын амжилтад их хэмжээгээр нөлөөлнө. Зохион байгуулалтын эдгээр хүчин зүйлүүдэд анги дэвшүүлэн сургах бодлого, сурагчдыг авъяас чадвараар нь ангилан нэгтгэх, сурлагын түвшнээр зохион байгуулсан анги бүлгүүдэд хичээл заах, төгсөлтийн шалгалт авах зэрэг орно. Жишээлбэл, бага насны хүүхдийн боловсролд хамрагдах хүрээг өргөжүүлэх, сургуулийн бие даасан байдлыг дээшлүүлэхэд чиглэсэн бодлого явуулах нь тэгш байдлыг хангах ач холбогдолтой байдаг бол, сурагчдыг сонгон ангилж бүлэг болгон хуваах нь тэнцвэргүй байдлыг улам гүнзгийрүүлэхэд хүргэж болох сөрөг талтай.
- **Сургуулийн орчин.** Сургалтын үр бүтээлтэй орчинг бүрдүүлэхэд үндсэн дэд бүтэц, мэргэжлийн удирдлага, чадварлаг багш сурган хүмүүжүүлэгчид, сургалтын хангалттай хугацаа ба нөөц боломж, хяналт шалгалт, үнэлгээний үр дүнг дээшлүүлэх арга болон хүрэлцээтэй санхүүжилт

шаардлагатай. Хөгжилтэй орнуудад баталгаатай хангагдсан байдаг заавал байх ёстой зарим чухал материаллаг бааз тухайлбал, эрчим хүч, ширээ сандал, хичээлийн самбар, сурах бичиг зэрэг зүйлүүд зарим хөгжиж байгаа орнуудад дутагдалтай байна. Өмнөд Сахарын 6 улсад 6 дугаар ангид суралцагчдын тэн хагас нь ангидаа ганц ч сурах бичиггүй байна. Хөгжиж буй олон оронд сургуульд зайлшгүй шаардлагатай тоног хэрэгслүүдийг хот, хөдөөд тэгш бус хуваарилж байна. Латин Америк болон бусад бүс нутагт ядуу гэр бүлийн хүүхдүүд сургалтын наад захын хэрэгсэлгүйгээр сургуульд явж байгаа нь тэгш бус байдлыг улам ихэсгэж байна.

Багшийн хүрэлцээ ба багш бэлтгэх ажлын чанар

Чанартай боловсролыг олгоход багш хамгаас чухал. Сурагчид амжилттай суралцахад сайн бэлтгэгдсэн, ажиллах хүсэл тэмүүлэлтэй багш нарын хүрэлцээ хангамж ба багш сурагчдын зохистой харьцаа чухал нөлөөтэй.

2006 онд дэлхий даяар 27 сая багш бага сургуульд ажиллаж байсны 80 хувь нь хөгжиж байгаа орнуудын багш нар байна. Тэдгээр багш нарын тоо 1999-2006 онд 5 хувиар өссөн бөгөөд тэдний дийлэнх хувийг Өмнөд Сахарын улс орнууд эзэлж байна. Латин Америк, Карибийн улсуудад ч багш нарын тоо өссөн байна. 1999 оноос дунд сургуулийн багш нарын тоо 5 саяар нэмэгдэж 2006 он гэхэд 29 сая болсон байна.

Бүх нийтийн боловсролын зорилтыг хангахын тулд Засгийн газрууд багш нарыг бэлтгэж, тоог нэмэгдүүлэх шаардлагатай байгаа юм. 2015 он гэхэд дэлхий даяар нэмж 18 сая бага сургуулийн багш шаардлагатай бөгөөд Өмнөд Сахарын улсуудад нэмж шаардлагатай байгаа (1.6 сая) багш нарын асуудал хурцаар тавигдаж байна. Хэрэв тэтгэвэрт гарах багш нарыг тооцоолж үзвэл энэ тоо 3.8 сая болж өснө. Тэтгэвэрт гарах болон бусад шалтгааныг

оролцуулан тооцвол Зүүн Ази, Номхон далайн орнуудад 4 сая багш, Өмнөд ба Баруун Азийн орнуудад 3.6 сая багш шаардлагатай болно.

Сурлагын амжилт гаргах сургалтын орчинг бий болгоход нэг ангид 40 -өөс илүүгүй сурагчдад 1 багш ногдох харьцааг ерөнхийдөө дэлхий нийтээр хүлээн зөвшөөрч байна. (40:1). Үндэсний болон бүсийн хэмжээнд нэг багшид олон хүүхэд ногдож байгаа газруудад, ялангуяа Өмнөд ба Баруун Азийн улс орнууд, Өмнөд Сахарын орнуудад энэ харьцааг багасгах талаар төдийлөн амжилт олохгүй байна. Харин Афганстан, Кени, Танзани, Руанду зэрэг улсад энэ харьцаа бүр эрс өссөн. Афганстан, Мозамбик, Руанде, Чад зэрэг улсуудад бага ангийн багш сурагчийн тооны харьцаа үндэсний хэмжээнд 60:1 байна. Латин Америк, Карибийн улсууд, Хойт Америк, Баруун Европод эсрэгээрээ сурагчдын тоо цөөрөх юмуу эсвэл багш нарын тоо өссөнөөс бага боловсрол дахь энэ харьцаа буурсан байна. Дунд боловсролд багш, сурагчдын тооны харьцааны үзүүлэлт Өмнөд Сахарын улсууд, Өмнөд ба Баруун Азийн улсуудад их байгаа юм.

Бэлтгэгдсэн мэргэжилтэй багш нарын хүрэлцээ хангамж олон оронд төдийлөн хангалттай биш байна. Бага боловсролын хүрээнд авч үзэхэд, 2006 онд бэлтгэгдсэн багш нарын үзүүлэлт Баруун ба Өмнөд Азийн орнуудад нийт багшлах боловсон хүчнийхээ 68%-ийг эзэлж байсан бол Арабын улсуудад 100% байсан байна. Мэдээнд хамрагдсан нийт 40 орны бараг тэн хагаст 1999 оноос 2006 оны хооронд бэлтгэгдсэн багш нарын тоо хэмжээ нэмэгдсэн байна. Бахама, Мянмар, Намиб, Рванда зэрэг орнуудад бэлтгэгдсэн багш нарын тоо 50%-иар өссөн боловч дээрх 40 орны 1/3-ээс илүүд нь бэлтгэгдсэн багш нарын тоо буурсан байна. Үүнд Бангладеш, Балба, Нигер зэрэг орнууд багтаж байна.

Түүнчлэн багш, сурагчдын тооны харьцаа нэг улс үндэстэн дотор ч сургуулийн хэв маяг, орлогын түвшин, байрлалаас хамаарч ихээхэн ялгаатай байна. Жишээ

нь, Нигерийн Байлса мужид энэ харьцаа Лагос мужийг бодвол 5 дахин илүү байна. Чинээлэг гэр бүлийн хүүхдүүдийн хувьд багш, сурагчдын тооны харьцаа илүү сайтай ба бэлтгэгдсэн багш нарын тоо өндөр байна. Багш, сурагчдын харьцаа түүнчлэн сургууль төсвөөс санхүүждэг эсэхээс хамаараад өөр юм. Жишээ нь Бангладеш улсын сургуулиудад багш, сурагчдын тооны харьцаа дунджаар 64:1 байхад төрийн бус сургуулиудад 40:1 байв.

Сургах болон суралцах үйл ажиллагааны чанарт түүнчлэн багш нарын ажил хаялт, ёс суртахууны доройтол (бага цалин, ажлын нөхцөл), ДОХ-ын улмаас нас барах зэрэг бусад хүчин зүйлүүд нөлөөлнө.

Бүх нийтийн боловсрол: Нийтлэг ололтуудыг дүгнэх нь

БНБ-ын зорилго бүр чухал болохын зэрэгцээ эцсийн дүнд бүхий л талбарт ахиц гаргах явдал нэн чухал. БНБ-ын Хөгжлийн Үзүүлэлт нь БНБ-ын бүхий л явцыг ерөнхийд нь дүгнэн тодорхойлоход туслах бөгөөд тоон үзүүлэлтээр хамгийн хялбар хэмжиж болох 4 зорилт дээр их анхаардаг. Үүнд: Бүх нийтийн бага боловсрол, насанд хүрэгчдийн бичиг үсгийн боловсрол, хүйсийн тэгш байдал ба боловсролын чанар юм. БНБ-ын Хөгжлийн Үзүүлэлтийн хамгийн сүүлийн тайланд эдгээр 4 чиглэлээр 129 орны 2006 оны хичээлийн жилийг дуусталх бүх мэдээллийг багтаасан болно. Энэ тайланд ороогүй олон орны ихэнх нь хямрал, зөрчил, мөргөлдөөнтэй байгаа буюу зөрчил, мөргөлдөөний дараах цаг үед байгаа эмзэг хэмээгдэх орнууд байна.

Тайланд орсон 129 орноос:

- 2005 онтой харьцуулахад 5 орноор илүү буюу 56 орон бүгд дээрх 4 зорилтоор БНБ-ын Хөгжлийн Үзүүлэлтээр дунджаар 0.95 буюу түүнээс дээш хувьд хүрсэн болон хүрэхэд нилээн ойрхон амжилттай байна. Амжилтад хүрсэн эдгээр орнуудын ихэнх нь хөгжингүй бүс нутгуудад байна.

Хамрагдсан нийт 35 орны бараг бүгдэд нь янз бүрийн орлоготой бүлгүүдийн БНБ-ын салбарт гарсан ерөнхий ололт, амжилт ихээхэн ялгаатай байна.

- Гол төлөв Латин Америк ба Карибийн орнууд (18), Арабын орнууд (9), Өмнөд Сахарын орнууд (9), Зүүн Ази, Ази Номхон далайн орнууд (5) зэрэг 44 орон БНБ-д хүрэх замынхаа хагасд буюу БНБ-ын Хөгжлийн Үзүүлэлт 0.80-0.94 хооронд байна. Хэдийгээр бага боловсролд хамрагдалт эдгээр орнуудад өндөр байгаа ч гэсэн насанд хүрэгчдийн бичиг үсгийн боловсрол, боловсролын чанар зэрэг бусад асуудал хоцрогдонгүй байгаа нь тэдгээр орнуудын ерөнхий амжилтыг бууруулж байна.
- БНБ-ын Хөгжлийн үзүүлэлтэд багтсан тэдгээр орны 1/5-ээс илүү буюу 29 улс 0.80 ба түүнээс доогуур үзүүлэлттэйгээр бусдаас хоцорчээ. Буркина Фасо, Чад, Этиоп, Мали, Нигер, ялангуяа Өмнөд Сахарын орнууд 0.60-аас доогуур үзүүлэлттэй орнуудад багтжээ. Бусад бүс нутгуудаас Арабын 4 орон, Өмнөд Азийн 6 орны 5 нь түүнчлэн энэ бүлэгт багтаж байна. Эдгээр орнуудын ихэнх нь 4 зорилтод хүрэхэд доогуур үзүүлэлттэй байгаа юм.

1999-2006 оны БНБ-ын Хөгжлийн Үзүүлэлтээр зөвхөн 45 орны өөрчлөлт, шинэчлэлтэд дүгнэлт гаргажээ. Тэдгээрийн 31 нь зарим нэг талаараа гайхалтай амжилтанд хүрсэн болохыг тэмдэглэсэн байна. Этиоп, Мозамбек болон Балбад БНБ-ын Хөгжлийн үзүүлэлт үнэхээр доогуур байдаг ч 20 гаруй хувиар өсчээ. БНБ-ын Хөгжлийн үзүүлэлт 14 оронд буурсан байна. Чад улс БНБ-ын Хөгжлийн үзүүлэлтээрээ бусад орнуудаасаа хол хоцорч, хамгийн сүүлд оржээ.

БНБ-ын Хөгжлийн үзүүлэлт өссөн хамгийн гол хүчин зүйл нь сургуульд хамрагдалтын байдал байв. Бага сургуульд хамрагдалтын хэмжээ өссөн явдал юм. Бага сургуульд хамрагдалтын нийт хэмжээ тэдгээр 45 оронд дунджаар 7.3%-иар нэмэгдсэн⁶. БНБ-ын Хөгжлийн үзүүлэлт буурсан 14 орны ихэнх нь чанаргүй боловсролын үзүүлэлтээс шалтгаалсан байна.

БНБ-ын ерөнхий ололт амжилт:

Улс орнуудад тэгш бус байдал тодорхой хэмжээнд байсаар ажээ.

Дээр дурьдсан БНБ-ын Хөгжлийн стандарт үзүүлэлт нь үндэстэн бүрийн дундаж үзүүлэлтийг үндэслэн гаргасан ерөнхий дүр зураг юм. Харин улс орон доторх ялгаа зөрүүг төдийлөн гаргаж өгдөггүй. Энэ дутагдлыг арилгахын тулд боловсролын шинэлэг хэмжүүр үзүүлэлт болох БНБ-ын тэгш бус байдлыг орлогын түвшин ялгаатай бүлгүүдээр индексжүүлэх болсон бөгөөд түүнийг (EIIIG) 35 хөгжиж буй улс орон хэрэглэж байна (График 8). Энэхүү хэмжүүр үзүүлэлтээр аж байдлын түвшин, оршин суугаа газар нутаг (хот, хөдөө) зэрэг хүчин зүйлийг тооцон улс орон доторхи БНБ-ын салбар дахь ерөнхий ололт, амжилтыг ялган харах боломжтой юм. Энэхүү индекс нь:


- Хамрагдсан нийт 35 орны бараг бүгдэд нь янз бүрийн орлоготой бүлгүүдийн БНБ-ын салбарт олсон ерөнхий ололт, амжилтанд ихээхэн ялгаа байна. Тухайн улс орон доторх ялгаа нь улс орнуудын хоорондын ялгаатай бараг адилхан байна. Ялангуяа Бенин, Буркина Фасо, Чад, Этиоп, Мали, Мозамбек болон Нигерт энэ ялгаа их. БНБ-ын тэгш бус байдлын орлогын түвшин ялгаатай бүлгүүдийн үзүүлэлт (EIIIG)-ээс харахад, эдгээр орнуудын хамгийн баян чинээлэг бүлгийнх хамгийн ядуу бүлгийнхээс 2 дахин өндөр байв.
- Боловсролын системийн үйл ажиллагаа сайтай улс орнуудад зөвхөн БНБ-ын ерөнхий ололт амжилт өндөр байгаа төдийгүй, тэгш бус байдлын ялгаа ч бага байна.
- БНБ-ын зорилгод хүрэх явцад гарч байгаа ололт амжилт нь ихэнх орнуудын хүн амын ядуу давхаргад ашиг тусаа өгч байна. Хамгийн баян чинээлэг болон хамгийн ядуу хүн амын 1/5-ийн хоорондын ялгаа эдгээр 35

6. Бага болон дунд боловсролд хамрагдаж байгаа сургуулийн насны хүүхдүүдийн хувь хэмжээ

орны ¼-т нь буурсан. Бенин, Этиоп, Энэтхэг, Балбад хамгийн баян болон хамгийн ядуу хүн амын ялгаа 15 ба түүнээс дээш хувиар буурсан үзүүлэлт гарчээ.

- БНБ-ын ерөнхий ололт амжилт, орлогын түвшингээс үл хамааран, хөдөө орон нутгийг бодвол хот, суурин газруудад илүү өндөр байна. Буркина Фасо, Чад, Этиоп болон Малид (EIIIG) энэ үзүүлэлт хот суурин газруудад хөдөө орон нутгаас 2 дахин өссөн байна.

График 8. Улс орнуудын хөрөнгө, чинээний байдлаас хамаарах БНБ-ын тэгш бус байдал, сүүлийн үеийн мэдээ баримт



Эх сурвалж: 2009 оны БНБ-ын Хяналт үнэлгээний Дэлхийн Тайлангийн График 2.44-ийг үзнэ үү.

БҮЛЭГ 3.

Чанарыг дээшлүүлж, тэгш шударга байдлыг хангахад удирдлагын үүрэг, нөлөө

Боловсрол дахь зөв сайн удирдлага гэдэг нь хоосон үзэл санаа биш юм. Энэ нь хүүхдүүд орон нутгийн хэрэгцээг хангахуйц, санхүүжилт сайтай, сайн бэлтгэгдсэн, эрч хүчтэй багш

нар заадаг тийм сургуульд хамрагдах явдлыг хангах тухай асуудал юм. Удирдлага нь яамнаас эхлээд сургууль, хамт олныг хамарсан боловсролын системийн бүхий л түвшинд шийдвэр гаргах бүрэн эрхийг тэгш



Өөр өөрдсийн замаар явж байгаа нь: сурагч охидууд болон гудамжны хүүхдүүд, Шинэ Дэли

хангах явдал юм. Бүлэг 3-т удирдлагын доор дурьдсан 4 үндсэн чиглэлээр засгийн газрууд бодлого, шинэчлэлээ хэрхэн хэрэгжүүлж байгаа талаар голлон анхаарсан. Үүнд: боловсролын санхүүжилт; сургуулийн сонголт, өрсөлдөөн, ба «дуу хоолой»; багш ба хяналт үнэлгээ; болон ядуурлыг бууруулах бодлого стратеги. Түүнчлэн боловсролын удирдлага нь сургалтын чанарыг дээшлүүлэх болон тэгш бус байдлыг бууруулахад нөлөөлж чадаж байна уу, үгүй юу, ямар замаар үүнд хүрч болохыг тодорхойлох оролдлого хийв.

Боловсролын удирдлага: Дакарын үйл ажиллагааны хүрээ болон бусад арга хэмжээ

Удирдлагын салбарын шинэчлэл нь БНБ-ын үндсэн асуудлын салшгүй нэг хэсэг юм. Дакарын үйл ажиллагааны хүрээ нь хариуцлагатай, хяналттай оролцоог хангасан боловсролын уян хатан тогтолцоог бий болгох явдлыг багтаасан өргөн цар хүрээтэй зарчмуудыг дэвшүүлэн тавьсан. Сайн засаглалын хувьд бүгдэд тохирох нэг загварыг бий болгохыг урьтал болгохгүйгээр, Дакарын үйл ажиллагааны хүрээ нь боловсролын системийг илүү тэгш, шударга болгох үүднээс төвлөрлийг сааруулах, бүх шатанд, бүр доод түвшинд хүртэл шийдвэр гаргахад оролцох оролцоог нэмэгдүүлэхийг хөхиүлэн дэмжиж байна.

Удирдлагын шинэчлэлийн хүрээнд улс орнууд арвин туршлагатай болж байгаа бөгөөд үр дүн нь харилцан адилгүй байгаа нь судалгаанаас харагдаж байна. Энд томоохон 2 бэрхшээлийг дурьдаж болох юм. Тухайн орон нутгийн нөхцөл байдалд үл тохирох загвар хэрэглэх хандлага болон тэгш байдлыг хангахад зохих ёсны анхаарал тавихгүй байгаа зэрэг юм. Түүнчлэн олонх тохиолдолд ядуурлыг бууруулах болон тэгш байдлыг арилгахад стратеги, бодлогоо шинэчлэл өөрчлөлтийн гол цөм болгож чадахгүй байгаа явдал юм. БНБ-ын зорилтод түргэн хүрэхийн тулд улс орнууд удирдлагын шинэчлэлд шударга байдлыг хангах асуудалд илүү анхаарах шаардлагатай.

Тайланд боловсролын удирдлагын 4 үндсэн чиглэл болон тэгш бус байдлыг шийдвэрлэхэд тэдгээр нь хэрхэн нөлөөлж байгаа талаар авч үзээд дараах 4 гол дүгнэлтэд хүрлээ.

- **Боловсролын санхүүжилт:** Хэдийгээр төвлөрлийг сааруулах нь чухал хэдий ч, төв удирдлага нь боловсролын санхүүжилтийн хуваарилалтын тэнцвэртэй байдлыг хангахад урьдын нэгэн адил хүчтэй нөлөөлөх ёстой.
- **Сургуулийн удирдлага:** Хамт олон, эцэг эх, боловсролын үйлчилгээ үзүүлдэг хувь хүмүүс, байгууллагад хариуцлагыг шилжүүлэх нь суурь боловсролын төрийн тогтолцоог бий болгоход саад учруулахгүй.
- **Багш нар ба хяналт үнэлгээ:** Засгийн газрууд багшлах боловсон хүчнээ бэхжүүлэх, тэдгээрийн хүсэл сонирхлыг татах, хариуцлагыг өндөржүүлэх, мөн илүү ил тод хяналт, шударга байдлыг дээшлүүлэх, сургалтын чанарыг сайжруулах үүднээс урамшууллын тогтолцоо бий болгох, сургуулиудад дэмжлэг үзүүлэхэд чиглэгдсэн хяналт шинжилгээний бодлого боловсруулах ёстой.
- **Төлөвлөлт ба ядуурлыг бууруулах:** Ядуурлыг бууруулах болон ноцтой тэгш бус байдлыг арилгахад чиглэгдсэн өргөн цар хүрээтэй бодлого стратегийн хүрээнд боловсролыг нэгтгэн зангидах шаардлагатай байна.

Тэгш байдлыг хангах үүднээс боловсролыг санхүүжүүлэх нь

Дэлхий нийтээр Дакарын зорилтуудад хүрэхийн тулд нэмэлт санхүүжилт шаардлагатай. Гэвч санхүүжилтыг нэмэгдүүлэх нь боловсролын салбар дахь бодлогын олон бэрхшээлүүдийн нэг юм. БНБ-д хүрсэн байхын тулд санхүүгийн эх үүсвэрээ нэмэгдүүлж, үр ашгийг нь сайжруулах хэрэгтэй байна. Түүнчлэн боловсролын санхүүжилтын тэгш бус

БНБ-ын зорилтод түргэн хүрэхийн тулд улс орнууд удирдлагын шинэчлэлд шударга байдлыг хангах асуудалд илүү анхаарах шаардлагатай.

байдлыг арилгах стратеги бодлогоо боловсруулах шаардлагатай.

Засгийн газрын боловсролд зарах төсөв

Боловсролд зориулагдах үндэсний орлогын хувь хэмжээ нь бүс нутаг болон орлогын янз бүрийн түвшинтэй улс орнуудын бүлгүүдийн хувьд харилцан адилгүй байна (Хүснэгт 1). Нийт хүүхдийн 80% орчим нь сургууль завсардсан Өмнөд Сахарын болон Баруун, Өмнөд Азийн бага орлоготой орнууд ҮНБ-ийхээ хамгийн бага хувийг боловсролд зарцуулж байна. Мэдээнд орсон Өмнөд Сахарын бага орлоготой 21 орны 11 нь ҮНБ-ийнхээ 4 хүрэхгүй хувийг боловсролд зарцуулж байна. Өмнөд Азийн орнуудаас Бангладеш үндэсний орлогынхоо зөвхөн 2.6%-ийг, Энэтхэг 3.3%, Пакистан 2.7%-ийг боловсролд зориулж байна. Бага орлоготой нэлээд орнуудын хувьд ч энэ үзүүлэлт ихээхэн ялгаатай байна. Төв Африкийн Бүгд Найрамдах улс ҮНБ-ийхээ 1.4%-ийг боловсролд зарцуулж байхад Этиоп 6%-ийг зориулж байна.

Дакарын хурлаас хойш мэдээнд хамрагдсан ихэнх орнууд боловсролд зориулах Засгийн газрын төсвөө нэмэгдүүлсэн байна. Зарим оронд БНБ-ын зорилтуудад дорвитой ахиц дэвшил гарсантай холбогдуулан төсөв үлэмж хэмжээгээр нэмэгдсэн. Этиоп, Кени, Мозамбек болон Синегал ҮНБ-ийхээ боловсролд зориулагдах

хэмжээг эрс нэмэгдүүлснээр эдгээр улсад сургууль завсардсан хүүхдийн тоог үлэмж хэмжээгээр бууруулж чадсан байна.

Гэтэл мэдээнд хамрагдсан 105 орны 40-д нь 1999- 2006 оны хооронд боловсролд зориулагдах үндэсний орлогын хэмжээ буурсан байна. 12 оронд бүхэл бүтэн нэг хувиас ч илүүгээр буурсан байна. Энэ бүлэгт сургуулиас завсардсан хүүхдийн тоо харьцангуй өндөр байдаг Конго, Энэтхэг зэрэг орнууд орж байна. Баруун болон Өмнөд Ази, Өмнөд Сахарын бусад орнуудад улсын төсөв хуучин хэмжээндээ байна. Өнөөдөр боловсролд оруулж буй хөрөнгө оруулалтын доогуур түвшинд байгаа улс орнууд боловсролд зориулах улсынхаа төсвийн хэмжээ, үр өгөөж, тэгш байдлыг хангах шаардлагатай.

Дэлхий даяарх орлогын тэгш бус байдал нь боловсролын төсвийн хуваарилалтын тэгш бус байдалд нөлөөлж байдаг. 2006 оны байдлаар бага сургуулийн төвшинд, нэг сурагчид ноогдох зардал хамгийн доогуур байсан Өмнөд Сахарын орнуудад \$300 ам.доллараас бага байсан бол ихэнх хөгжилтэй улс орнуудад \$5000 ам. доллароос ч өндөр байна. Бүсийн хувьд авч үзвэл, Өмнөд Сахарт дэлхийн 5-25 насны хүн амын 15% нь амьдардаг боловч боловсролд зарцуулагдах зардал нь дэлхий нийтийн төсвийн зөвхөн 2%-ийг эзэлж байна (График 2). Өмнөт болон Баруун

Хүснэгт 1. ҮНБ-ний болон улсын нийт зардлын боловсролд зарцуулах төсвийн хэмжээ, бүс нутгаар, 2006 он

Өмнөд Сахарын орнууд	Арабын Нэгдсэн улс	Төв Ази	Зүүн Ази болон Номхон далайн орнууд	Баруун болон Өмнөд Ази	Латин Америк болон Карибын тэнгисийн орнууд	Хойд Америк болон Баруун Европ	Төв болон Зүүн Европ
ҮНБ-ний боловсролд зарцуулах улсын төсвийн хэмжээ							
4.4	4.6	3.4	...	3.3	4.1	5.5	5.3
Улсын нийт зардлын боловсролд зарцуулах улсын төсвийн хэмжээ							
18	21	15	15	12	13

Эх сурвалж: 2009 оны БНБ-ын Хяналт үнэлгээний Дэлхийн Тайлангийн Хүснэгт 3.2 болон Хавсралт, Статистикийн хүснэгт 11-ийг үзнэ үү.

Азид энэ насны хүн амын ¼-ээс илүү нь амьдардаг боловч боловсролд төсвийн 7% нь зарцуулагдаж байна.

Үр ашгийг нэмэгдүүлэх ба зарим гажуудал,

График 9. Боловсролд зарцуулах дэлхийн нийт зардлын хуваарилалт, бүс нутгаар, 2004



Эх сурвалж: 2009 оны БНБ-ын Хяналт үнэлгээний Дэлхийн Тайлангийн График 3.4-ийг үзнэ үү.

авилгыг бууруулах нь

Төсвийг нэмэгдүүлэх нь санхүүгийн үр ашгийг дээшлүүлж, санхүүгийн удирдлагыг бэхжүүлэхэд түлхэц болдог. Янз бүрийн улс орны боловсролд зарцуулагдах төсвийн үр ашгийг тоон үзүүлэлтээр тодорхойлох нь амаргүй хэдий ч энэхүү үр ашгийн тухай санхүүгийн орлого, сургуульд хамрагдалт, түүний төгсөлт, сурлагын амжилт зэрэг тодорхой үр дүнг харьцуулсан дүгнэлтүүд тодорхой харуулж чадна. Жишээ нь: Сенегал, Этиоп улсуудад 2006 онд бага сургуульд хамрагдалтын хэмжээ ижил (71%) байхад нэг сурагчид ноогдох зардал Сенегалд Этиопоос 2 дахин илүү байсан байна. Энэ үзүүлэлт нь 2 улсын боловсролын чанар харилцан адилгүй байна уу үгүй юу гэдгийг шүүн тогтоохгүй хэдий ч Этиопын боловсролын тогтолцоо нь боловсролд зориулсан санхүүжилтийг ашиглах тал дээр илүү үр ашигтай ажиллажээ гэж үзэх боломжийг олгож байна.

Зарим гажуудал, авилга нь боловсролд

гүн гүнзгий хор уршиг учруулна. Олон оронд төсвийг янз бүрийн түвшинд зохисгүй ашиглаж байгаа нь сургуулиуд өөрт ноогдсон төсвийн үлэмж хэсгийг авч чадахгүйд хүргэж байна. 2003 онд Мексикт хийсэн судалгаагаар хуулийн дагуу үнэ төлбөргүйгээр сургах ёстой улсын сургуулиудад хүүхдээ оруулахын тулд айл өрхүүд бараг \$10 сая долларын хээл хахууль (нэг гэрт дунджаар \$30 ногдох) төлсөн байна. Гажуудал, авилга нь юуны түрүүнд эмзэг, дорой бүлгийнхэнд хүчтэй цохилт болдог. Учир нь тэд бусдыг бодвол илүү төрийн тогтолцооноос хамааралтай байдаг бөгөөд хуулиар эрхээ хамгаалуулах эх үүсвэр, бололцоо хязгаарлагдмал, «албан бус төлбөр» төлөх боломж муу юм. Гажуудлыг багасгахад чиглэгдсэн үндэсний хөтөлбөр, санаачлагын нэг жишээ бол удирдлагыг бэхжүүлэх болон гажуудлыг зогсооход захиргааны бүтцүүдийг нэгтгэж чадсан Индонезийн Сургуулийн үйл хэргийг сайжруулах Тэтгэлэгт Хөтөлбөр юм.

Санхүүжилтын тэгш, шударга байдлыг хангах бодлого стратеги. Боловсролыг төрөөс санхүүжүүлэх нь тэгш бус байдлыг арилгах боломж олгодог ч бас түүнийг ихэсгэх тал бий. Баян бүс нутаг болон чинээлэг хүмүүс, ядуу бүс нутаг болон эмзэг бүлгийнхнээс илүү их санхүүжилт шаарддаг. Зарим тохиолдолд, тэгш бус санхүүжилт нь угсаатны нөхцөл, байдалтай ч холбоотой байдаг. Хуучнаар Югославийн Бүгд найрамдах Улс Македонд, жишээ нь, Албани гаралтай сурагчтай сургуулиуд нь Македон гаралтай сурагчидтай сургуулиас бараг 20% бага төсөв авдаг бол энэ ялгаа хөдөө орон нутагт 37% хүртлээ өссөн байна.

Шударга зарчмыг бэхжүүлэхийн тулд засгийн газрууд янз бүрийн арга хандлагаар ажиллаж байна. Өмнөд Сахарын зарим онд улсад ядуу гэр бүлийн хүүхдүүдийг сургуульд хамрагдах боломж, нөхцөлийг бүрдүүлж, сургалтыг төлбөрөөс чөлөөлснөөр төсвийн хуваарилалт илүү тэгш шударга болж, сургуульд хамрагдалт нэмэгдсэн байна. Жишээ нь, Сенегал, Уганда, Танзаны Нэгдсэн Бүгд Найрамдах Улс болон Замби зэрэг улс бага сургуулийн түвшинд санхүүжилтийг нэмэгдүүлж,

сургалтын төлбөрийг чөлөөлөх тухай улс төрийн удирдагчдийнх нь гаргасан шийдвэр нь төрийн санхүүжилтийн хуваарилалтанд тэгш шудрага байдлыг улам бэхжүүлж чадсан ба сургуульд хамрагдалтанд эерэгээр нөлөөлсөн байна.

Бас өөр нэг арга хандлага бол төвийн удирдлагын зүгээс орон нутгийн сургуулиуд болон бүлэг, хамт олонд хөрөнгө мөнгө зарцуулах замаар тэтгэмж, тэтгэлэг олгодог болсон явдал юм. Тэтгэлгийн энэ хэлбэр нь эмзэг болон чадавхи бололцоогүй хүүхдүүдэд нэмэлт санхүүгийн эх үүсвэр, тусламж олгох замаар тэгш бус байдлыг бууруулахад ач холбогдолтой. Ганад сургуулийн тэтгэлэгт хөтөлбөр нь сургуульд хамрагдалтыг эрс нэмэгдүүлсэн байна. Ялангуяа, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн сургуульд хамрагдалт өсчээ.

Төвлөрлийг сааруулах нь: тэгш бус байдлыг арилгах гол хүчин зүйл

Удирдлага, санхүүгийн үүрэг хариуцлагыг төрийн удирдлагын хамгийн доод шат, нутгийн хамт олон, бүлэг, сургуулийн үйлчилгээ явуулдаг байгууллагад шилжүүлэх хандлагыг баримталж байгаа орнуудын тоо улам бүр өсч байна. Нийгэм, хамт олонд илүү ойр дөт шийдвэр гаргах боломж олгож байгаа энэхүү төвлөрлийг сууруулах бодлого нь боловсролын тогтолцоонд тухайн нутаг орны хэрэгцээ шаардлагыг илүү тусгаж, хүн амын ядуу давхаргаас дуу хоолойгоо нэгтгэх илүү өргөн боломжийг олгож байгаа юм.

Тийм хэдий ч, санхүүжилтын төвлөрлийг сааруулснаар тэгш байдалд хэрхэн нөлөөлөх тухайд үр дүн нь тодорхой биш байна. Хятад, Индонези, Филиппин зэрэг олон орны туршлагаас харахад санхүүгийн хариуцлагыг ийнхүү шилжүүлснээр баян чинээлэг бүс нутгууд санхүүгийн эх үүсвэрээ илүү дайчлан ашиглах тул тэгш бус байдал улам даамжрах магадлалтай. Нигерт гэхэд боловсролд хамрагдах түвшин өндөртэй баян бүс мужууддаа улсын төсвийнхөө дийлэнх хувийг зориулдаг бөгөөд зарим тохиолдолд ядуу орон нутгаасаа даруй 5 дахин илүү зарцуулсан байна. Энэ нөхцөл

байдал доогуур орлоготой нэн ядуу бүс нутгуудын байдлыг улам доройтуулж байна. Ингэснээр боловсролын санхүүжилтийн тэнцвэргүй байдлыг улам гүнзгийрүүлдэг.

Иймэрхүү үр дагавраас зайлсхийх гол түлхүүр нь төв удирдлагын зүгээс нөөц баялгийг ядуу буурай бүс нутгуудад болон бүлэг хүмүүст дахин хуваарилах явдал юм. Ийм арга хэмжээг Бразил, Этиоп, Өмнөд Африк, Вьетнам зэрэг улсуудад янз бүрийн түвшинд авч хэрэгжүүлсэн байна. Төвлөрлийг сааруулах нь мөн чанартаа тэгш, шударга зарчмыг тогтооход эерэг болон сөрөг талуудтай. Төвлөрлийг сааруулах эсэх нь чухал биш харин юуны төвлөрлийг сааруулах, хэрхэн яаж сааруулах вэ гэдэг нь гол асуудал юм. Төвлөрлийг тэгш, шударгаар сааруулах стратеги төлөвлөгөөнд доорхи зорилтууд орно. Үүнд:

- Орон нутгийн удирдлагуудын суурь боловсролд татвар ноогдуулах явдлыг хориглох зэргээр улсын төсвийн бүрдүүлэлтэд төвлөрлийг сааруулахад зориулсан ойлгомжтой, тодорхой удирдамжаар хангах;
- Төв засгийн газраас ядуурал, боловсрол, эрүүл мэндийн үзүүлэлтүүдийг харгалзан орон нутгийн түвшинд санхүүжилт олгох, мөн бүх нийтийн боловсролын үндэсний зорилтуудад хүрэхэд шаардагдах төсвийг тооцож тусгасан тэгш, шударга санхүүгийн бүтцийг бий болгох;
- Дакарын үйл ажиллагааны хүрээний болон ядуурлыг бууруулах үндэсний зорилтуудад хүрэхэд тууштай үүрэг хариуцлагуудыг тусгасан бодлогын шинжтэй тодорхой зорилтуудыг дэвшүүлэн тавих;

Сонголт, өрсөлдөөн ба үгээ хэлэх эрх: Сургуулийн удирдлагын шинэчлэл ба БНБ

Сургуулийн санхүүжилт ба зохицуулалтад засгийн газар, эцэг эх, нийгэм болон хувийн

Өмнөд Сахарын зарим улс оронд ядуу гэр бүлийн хүүхдүүдэд сургуульд хамрагдах боломж, нөхцөлийг бүрдүүлж, сургалтыг төлбөрөөс чөлөөлснөөр сургуульд хамрагдалт нэмэгдсэн байна.

хэвшлийнхэн ямар үүрэг гүйцэтгэх вэ? Сургуулийн удирдлагын шинэчлэлтийн 3 үндсэн чиглэлийг дараах байдлаар танилцуулж байна. Үүнд:

- Сургуулиуд ба орон нутгийн иргэдэд эрх мэдлийг шилжүүлэх,
- Сургуулиа сонгох явдал болон сургуулиудын өрсөлдөөнийг өргөжүүлэх,
- Өртөг багатай хувийн сургуулиудын тоог нэмэгдүүлэх асуудлууд орно.

Энэхүү өөрчлөлтүүд нь хүн амын ядуу давхрагын дуу хоолойг хэрхэн сонсож, тэдний сонголтыг хэрхэн нэмэгдүүлж чадах вэ?

Сургууль түшиглэсэн удирдлага: Хандлага болон үр дүнгийн далайц

Сургууль түшиглэсэн удирдлага гэдэг нь сургуулийн хүрээнд шийдвэр гаргахад багш, эцэг эх болон нийгмийн бүлгүүдэд илүү эрх мэдэл олгоход чиглэсэн шинэчлэлтийн үйл ажиллагаа юм.

Сургууль түшиглэсэн удирдлагыг дэмжигчдийн үзэж байгаагаар, энэ нь тухайн сургуулийг орон нутгийн хэрэгцээнд илүү нийцүүлж, эцэг эхчүүдэд дуу хоолойгоо илэрхийлэх бодит боломж олгож, багш нарын оролцоо, идэвхи санаачлага, хариуцан тайлагнах чанарыг бэхжүүлэхэд нөлөөтэй.

Зарим тохиолдолд сургуульд суурилсан менежментийн шинэчлэлүүд нь сурлагын амжилтыг дээшлүүлж, тэгш байдлыг ханган бэхжүүлдэг байна. Жишээлбэл, Эль Салвадорын EDUCO (Нийгмийн удирдлагатай Сургуулийн Хөтөлбөр) хөтөлбөрт хамрагдсан сургуулийн сурагчид бусад сургуулийн сурагчдаас тоо бодлого, хэлний чиглэлийн хичээлүүд дээр илүү өндөр оноо авч байна. Хэдий тийм боловч, Гондураст хэрэгжиж буй үүнтэй төстэй хөтөлбөрүүдэд хамрагдаж буй сургуулиудын оноо нь уламжлалт

сургалттай сургуулиудын онооноос онцгойрон ялгардаггүй. Латин Америк болон бусад бүс нутгуудад багшлах арга барилд мэдэгдэхүйц өөрчлөлт гараагүй байна.

Эдгээр шинэчлэлүүд нь «Дуу хоолойгоо илэрхийлэх»-д янз бүрийн нөлөө үзүүлж байна. Эцэг эх-багш нарын холбоо, сургуулийн удирдах зөвлөл зэрэг сургуулийн хүрээнд албан ёсны бүтцүүдийг байгуулах замаар орон нутгийн шинжтэй шийдвэрүүд гаргахад эцэг эх, нийгмийн бүлгүүдийн оролцоог өргөжүүлж болох юм. Гэвч ингэснээр олон дутагдал, доголдлыг шууд арилгачихна гэж ойлгож болохгүй. Балбад жишээ нь сургуулийн удирдлагыг дээд давхаргын хүмүүс голчлон эрхлэн явуулдаг бол, Австрали болон Шинэ Зеландад сургуулийн удирдах зөвлөлд үндэсний цөөнхийн төлөөлөл бараг байдаггүй байна. Ядуурал зэрэг нийгэмд бугшсан тэгш бус байдал нь оролцоогоор дамжуулан тэгш байдлыг бэхжүүлэх гэсэн хүчин чармайлт, оролдлогуудад саад тотгор болж байна.

Боловсролын үйлчилгээн дэх сонголт ба өрсөлдөөн

Бараг бүх улс оронд төр засаг нь сургуулийн тогтолцоог бүрэн хариуцаж байдаг. Төр засгийн үүрэг роль нь боловсролын салбарт шууд нөлөөлөх хууль эрх зүйн заалтуудыг боловсруулан гаргахаас эхлээд хувийн хэвшлийнхнийг удирдан зохицуулах хүртэл маш өргөн хүрээтэй. Сургуулиа сонгоход эцэг эхийн оролцоог өргөжүүлэх нь чанарыг сайжруулах гол түлхүүр гэж олон улс орон үзэж байгаа. Зарим улс орнуудад засгийн газрын зүгээс хувийн хэвшлийнхэнд санхүүжилт олгодог бөгөөд энэ нь төрийн болон хувийн сургуулиудын хамтын ажиллагаа нь сургуулийн сонголт болон өрсөлдөөнийг нэмэгдүүлэх хамгийн гол хүчин зүйл болж байна.

Хөгжингүй болон хөгжиж буй улс орнуудын аль алинд сургуулийн сонголт, өрсөлдөөний асуудал нь заримдаа хэт туйлширсан маргаан, мэтгэлцээний гол сэдэв болж байдаг. Эцэг эхийн сонголтыг өргөжүүлэх

нь сурлагын амжилт, тэгш шудрага байдлыг нэмэгдүүлж чадаж байна уу? Үүний баталгаа нь харагдахгүй байна.

Сурагчдын олон улсын үнэлгээний хөтөлбөрийн судалгааны үр дүнгүүдээс харахад сургуулийн өрсөлдөөний үр дүнд сурлагын амжилт тууштай өсөж байгаа нь ажиглагдахгүй байна. АНУ-ын хувьд давуу эрхт сургуулиудыг (charter school-төрөөс санхүүгийн дэмжлэг авдаг хувийн сургууль бөгөөд төр, хувийн хэвшлийн хамтын ажиллагааны тод жишээнүүдийн нэг) хөгжүүлж, ваучер хөтөлбөрийг хэрэгжүүлсэн боловч сургалтын амжилтыг мэдэгдэхүйц нэмэгдүүлж, тэгш бус байдлыг арилгаж чадаагүй байна. Чилийн хувьд ч адил. Хэдийгээр сонголт, өрсөлдөөнийг удирдлагын шинэчлэлийн гол загвар гэж үзэж байгаа боловч үр дүн нь харагдахгүй байна. Нийгэм, эдийн засгийн зохицуулалтуудыг хийсэн хэдий ч төрөөс санхүүжилт авдаг хувийн сургуулиуд нь төрийн сургуулиудаас давуу гэдгээ харуулж чадахгүй байна.

Боловсролын чанар, тэгш байдлыг дээшлүүлэхэд сургуулийн сонголт, өрсөлдөөн чухал гэдгийг Америк, Чилийн

жишээ төдийлөн харуулж чадсангүй. Харин Шведийн туршлага илүү нааштай үр дүнтэй байна. 1990-ээд оны эхэн үеэс эцэг эхчүүд төрийн бус сургуулиудыг сонгож, түүндээ төрөөс санхүүжилт авах боломжийг бүрдүүлж эхэлсэн бөгөөд энэ нь олон нийтийн дэмжлэгийг хүлээсэн байна. Хэдий тийм боловч энэ тогтолцоог цаашид өргөжүүлэн хэрэгжүүлэх асуудал маргаантай хэвээр байна. Хүүхэд бүрт чанартай сайн боловсрол олгож буй боловсролын төрийн тогтолцоотой бөгөөд тэгш бус байдлын төвшин нэлээд доогуур байгаа улс орнуудад энэхүү өрсөлдөөний загварыг нэвтрүүлж ирсэн. Энд түүнчлэн хувийн хэвшлийнхнийг хянах, зохицуулах талаар төрийн чадавхи хүчтэй юм. Энэхүү нөхцөлүүд нь хөгжиж буй орнууд байтугай хөгжингүй олон оронд хараахан бүрдээгүй байна.

Хэрвээ засгийн газрууд хүн амын эмзэг давхрагын эрх ашгийг хамгаалах урьдчилсан арга хэмжээ авч хэрэгжүүлэхгүйгээр сургуулийн сонголтыг өргөжүүлэх явдлыг дэмжвэл сургуулиад нь тэгш бус байдлын үүр, уурхай болно. Төрийн санхүүжилтын зөв зохистой, бүгдэд хүртээмжтэй тогтолцоог ханган баталгаажуулах нь ялангуяа ядуу буурай улс орнуудад нэн тэргүүний зорилт юм.

Төлбөр багатай хувийн сургуулиуд: Төр бүтэлгүйтэхийн шинж тэмдэг

Сүүлийн жилүүдэд Гана, Энэтхэг, Кени, Нигер, Пакистан зэрэг улс орнуудад төлбөр багатай хувийн бага сургуулиудын тоо эрс өсч байна. Засгийн газрын зүгээс бэлтгэлгүй байгаа болон улсын сургуулиуд цөөн байгаа нь ийм байдал үүсэхэд ихээхэн нөлөөлж байна. Хэдийгээр төлбөр багатай хувийн сургуулиудын тархалтын цар хүрээ нь улс орнуудад янз бүр боловч эдгээр сургуулиуд нь хамгийн эмзэг бүлгийн хүүхдүүд, түүний дотор ядуусын хорооллын хүүхдүүд төвлөрсөн газруудад илүү олноор байгуулагдаж байна.

Зарим хүмүүс төлбөр багатай хувийн сургуулиудыг олон хүнийг боловсролтой

Эцэг эхийн сонголтыг өргөжүүлэх нь сурлагын амжилт, тэгш шудрага байдлыг нэмэгдүүлж чадаж байна уу? Үүний баталгаа нь харагдахгүй байна.



Ажил үйлстээ бие сэтгэлээ зориулсан багш Боловсрол эзэмшихийн ач тус, баяр баясгаланг хүүхэд залуучуудад түгээж байгаа нь. Хөдөөгийн Малид.

болгоход ихээхэн ач холбогдолтой хэмээн үздэг. Эцэг эхчүүд эдгээр сургуулиудад төлбөр төлж хүүхдүүдээ суралцуулж байгаа нь тэдгээр сургуулиуд нийгмийн бодит эрэлт хэрэгцээг үнэхээр хангаж, тэдэнд жинхэнэ сонголт хийх боломжийг олгож байгаагийн нотолгоо гэж үзэж байна.

Гэвч ихэнх тохиолдолд энэ нь батлагдахгүй байна. Нийгмийн хамгийн ядуу бүлгийн хүмүүс тэдгээр сургуулийн төлбөрийг төлөхийн тулд нилээн их зардал гаргаж, өөрсдийн амьдралыг золиослох шаардлагатай болдог байна. Иймэрхүү сургуулиудад боловсролын чанар муу байх нь бий. Зарим тохиолдлуудад энэ нь зарим газруудад төрийн сургууль байдаггүйтэй холбоотой байна. Тухайлбал, Кени улсын нийслэл Найробигийн ядуусын хороололд ямар ч улсын сургууль байхгүй учир оршин суугчид сонголт хийх боломжгүй болж, хүүхдүүдээ улсын сургуульд хамруулж чаддаггүй байна.

Төр, хувийн хэвшлийн хоорондын хамтын ажиллагааны түншлэлийг хөгжүүлэхэд төлбөр багатай хувийн сургуулиудыг хамруулах зарим нэг оролдлогууд хийгдэж байна. Үүний нэг тод жишээ бол Пакистан улс юм. Өргөн хүрээг хамарч байгаа тэгш бус байдал, сургуульд хамралт доогуур үзүүлэлттэй байгаа нөхцөлд төлбөр багатай хувийн сургуулиудад Швед, Америкт хэрэгжиж байгаагийн адил ваучер болон улсын төсөв олгох хөтөлбөрүүдийг нэвтрүүлж байгаа нь зарим нааштай үр дүнг харуулж байна. Гэвч, төрийн чадавхи муу, гадны санхүүжилтээс хэт хамааралтай байгаа зэрэг нь энэхүү хөтөлбөрийг цаашид тогтвортой хэрэгжүүлж чадах эсэхэд эргэлзээ төрүүлж байна. Хамгийн ядуу айл, өрхүүд төрийн боловсролын тогтолцооноос ихээхэн хамааралтай үлдэж байгаа нь анхаарлаа хандуулах чухал асуудал юм. Төлбөр багатай хувийн сургуулиудын тоо эрс нэмэгдэж байгаа нь амьдралын бодит эрэлт хэрэгцээнд нийцэж болох хэдий ч тэдгээр нь өртөг зардлын хувьд үнэхээр боломжийн төдийгүй сайн чанарын боловсрол олгож байна гэсэн нотолгоо хомс байна. Хувийн санхүүжилт болон хувийн хэвшлийнхэн үүнд өөрийн гэсэн

тодорхой үүрэг гүйцэтгэх ёстой бөгөөд тэдний хүчин чармайлтыг үндэсний стратегид нийцүүлэх явдлыг төрийн зүгээс баталгаажуулах хэрэгтэй юм. Хэдий тийм боловч, ялангуяа ядуу буурай орнуудын суурь боловсролын хувьд хувийн хэвшлийн санхүүжилт болон хангалт, нийлүүлэлт нь чанартай боловсролыг бүх нийтэд олгож чадах төрийн тогтолцоог орлож чадахгүй.

Багшийн удирдлага, хяналт үнэлгээг бэхжүүлэх нь

Боловсролын чанар, тэгш байдлын хамгийн наад захын шаардлагыг хангахгүй боловсрол олгож байгаа сургууль олон байна. Ийм нөхцөл байдлаас болж сая сая хүүхдүүд бичиг үсгийн болон тоо бодох хамгийн суурь мэдлэг, чадвар эзэмшиж чадахгүй байгаагаас гадна сургууль төгссөний дараа ч тийм хэвээр байсаар байна. Доорхи хэсэгт боловсролын чанарыг сайжруулах болон тогтвортой байлгахад чухал ач холбогдол бүхий багш болон түүний хяналт үнэлгээ гэсэн хоёр асуудлыг авч үзэх болно.

Багшийн ажил олголт, хуваарилалт ба дур сонирхол

Боловсролын салбар дахь бодлогын гол асуудал нь хамгийн хэрэгтэй байгаа газруудад хангалттай чадварлаг багш нарыг ажиллуулах явдал юм. Энэхүү тайланд багштай холбоотой удирдлагын 4 гол хүчин зүйлийг авч үзсэн ба үүнд: цалин болон амьдралын түвшин, ажил олголт, хуваарилалт, мөн тэдний дур сонирхол орж байна.

Цалин ба амьдралын түвшин. Багшийн цалинг тогтоохдоо засгийн газрууд багшид зарцуулах хөрөнгө мөнгө болон боловсролын бусад салбаруудад зарцуулах зардлын тэнцвэрийг хадгалахын сацуу багш нарын орон тоог нэмэгдүүлэх болон тэдний ажиллах урам зориг, сонирхлыг хөгжөөх алхмуудыг хийх шаардлагатай болдог.

Багшийн ажиллах сонирхлын талаар хийсэн сүүлийн үеийн судалгаануудаас харахад, зарим улс оронд багшийн

Суурь боловсролын хувьд хувийн хэвшлийн санхүүжилт болон хангалт, нийлүүлэлт нь чанартай боловсролыг бүх нийтэд олгож чадах төрийн тогтолцоог орлож чадахгүй.

БНБ-ын үндсэн үзэл санааны үүднээс авч үзэхэд багш нарын орон тоог нэмэгдүүлэхдээ боловсролын чанарын стандартыг бууруулах нь цаг хугацаа, хөрөнгө санхүүгийн хувьд хохиролтой юм.

цалингийн түвшин тэдний амьжиргааны наад захын хэрэгцээг хангаж чадахааргүй байна. Өмнөд Сахарын болон Өмнөд Азийн нэлээд хэдэн улсад багшийн цалингийн хэмжээ нь ядуурлын түвшний ойролцоо буюу түүнээс ч доогуур байна. Цалин бага байх болон цалингаа цагт нь өгдөггүй явдал чадварлаг багш нарыг ажиллуулахад саад болж байна. Энэ байдлууд нь улмаар багшлах чанарт муугаар нөлөөлж, багш нарын ёс суртахууныг доройтуулахаас гадна эцэст нь тэднийг өөр ажил хийхэд хүргэж байна. Төв Азийн ихэнхи улс оронд орлогоо нэмэгдүүлэхийн тулд хувиараа багшилдаг багш нар маш ихээр бүртгэгдсэн байна.

Гэрээт багш нар: чанар, тэгш шудрага байдлыг хангахын тулд багш нарын тоог нэмэгдүүлэх үү? Багшийн орон тооны хомсдлыг арилгахын тулд зарим улс орнууд төрийн албаны журмыг дагаж мөрдөлгүйгээр багш нарыг гэрээгээр ажиллуулж байна. Олон оронд гэрээт багш нарыг ажиллуулах байдлаар багшийн орон тоог нэмэгдүүлж байна. Энэ нь ялангуяа, Баруун Африкт их байгаа бөгөөд Гвиней, Нигер, Тогод багш нарын гуравны нэгээс илүү хувийг гэрээт багш нар эзэлж байна.

Багш нарыг гэрээгээр авч ажиллуулах нь сөрөг үр дагавар авчирч болзошгүйг харуулсан баримтууд бас байна. Тогод одоогийн байдлаар улсын бага сургуулиудын багш нарын 55% нь гэрээгээр ажиллаж байна. Гэтэл гэрээт багш нараар заалгаж байгаа сурагчид үндсэн багш нарын сурагчдын хэмжээнд хүртэл сайн сурлагын амжилт үзүүлж чадахгүй байна. Энэтхэгийн алслагдмал бүс нутгуудад сургуулиудын багшийн орон тоог нэмэгдүүлэх зорилгоор гэрээт багш нарыг ажиллуулж байна. Үндсэн багш нартай харьцуулахад гэрээт багш нар чадвар, туршлага багатай байдаг бөгөөд энэ байдлаас үүдэн улсын хэмжээнд нийтэд нь адил тэгш, чанартай боловсрол олгох тухай асуудал санаа зовоосон хэвээр байна.

БНБ-ын үндсэн үзэл санааны үүднээс авч үзэхэд багш нарын орон тоог нэмэгдүүлэхдээ боловсролын чанарын

стандартыг бууруулах нь цаг хугацаа, хөрөнгө санхүүгийн хувьд хохиролтой юм. Гэтэл төсөв, мөнгө нь хязгаарлагдмал засгийн газруудын хувьд үүнийг зохицуулах боломж тун хомсхон байна. Хамгийн ядуу буурай орнуудын хувьд, багш нарын орон тоог хангахад үндэсний хүчин зүтгэл гаргахын зэрэгцээ гадны тусламж дэмжлэгийг нэмэгдүүлэх нь зүйтэй байж болох юм.

Багш нарын хуваарилалт дахь тэгш бус байдалтай тэмцэх нь. Алслагдмал, ядуу буурай болон нийгмээс гадуурхагдсан хүүхдүүдийн амьдардаг газар нутгуудад чадварлаг багш нар хангалтгүй байдаг. Багш нарт сонголт хийх боломж байгаа үед тэд алслагдмал газар, амьдралын харьцангуй хэцүү нөхцөлд ажиллахыг хүсэхгүй байж болох талтай. Хөдөө орон нутгийн сургуулиудад ажиллаж буй мэргэшсэн, туршлагатай багш нарын тоо цөөн байгаа нь ялангуяа тэгш бус байдлын ноцтой эх үүсвэр болж байна. Намибид л гэхэд, хойд нутгийн хөдөөгийн сургуулиудын багш нарын зөвхөн 40% нь мэргэшсэн багш нар байхад, нийслэлийн сургуулиудын багш нарын 92% нь мэргэшсэн багш нар байна.

Иймэрхүү газруудад багш нарыг татан ажиллуулах зорилгоор багш нарт санхүүгийн урамшуулал олгох буюу орон нутгийн багш нарын орон тоог нэмэгдүүлэх зэрэг бодлогуудыг баримталдаг бөгөөд зарим тохиолдолд багш нарын сургалтанд төлөөлөл багатай бүлгийнхнийг хамруулахад квот тогтоодог байна. Орон нутгаас багш нарыг ажиллуулах нь хангамж, үйлчилгээ тааруу газруудад багш нарын хангамжийг сайжруулах, багш нарын дур сонирхолыг дээшлүүлэх, эцэг эхийн зүгээс багш нарт тавих хяналтыг ойртуулах зэрэг ач тустай. Хэдий тийм боловч бодит амьдрал дээр төлөөлөл багатай бүлгүүдээр багшлах орон тоог бүрдүүлэх нь тэднийг удирдан зохион байгуулахад бэрхшээлтэй байж болох юм. Камбож болон Бүгд Найрамдах Ардчилсан Лаос улсын засгийн газрууд багш бэлтгэх сургалтанд үндэсний цөөнхийн бүлгүүдээс илүү хамруулахыг чухалчилсан боловч тэдгээр сургасан багш нарыг орон нутагт нь эргүүлэн очуулж

багшлуулахад бэрхшээлтэй тулгарсан. Бразилд төв засгийн газраас олгодог санхүүжилтыг дахин хуваарилахдаа ядуу буурай нутгуудад багш нарын орон тоо болон сургалтын чанарыг нэмэгдүүлэхэд зориулж байна.

Зөрчил, мөргөлдөөнд нэрвэгдсэн эмзэг улс орнуудад багш нарын хуваарилалт нэлээн хурц асуудлуудтай тулгарч байна. Үүний нэг тод жишээ болгож Афганистаныг дурьдаж болно (Оруулга 6).

Оруулга 6. Эмзэг улс орнуудын багш хуваарилалтын асуудал: Афганистаны туршлага

Афганистанд сургуульд хамрагдалтын хэмжээ харьцангуй ихсэж байгаа ч, сургууль завсардсан хүүхдүүдийн тоо өндөр байгаа ийм нөхцөлд багш нарыг бэлтгэх, орон тоог эрс нэмэгдүүлэх, оновчтой хуваарилах явдал нэн чухал юм. Энэ асуудлыг шийдвэрлэхийн тулд Афганистаны засгийн газар багш бэлтгэх 38 коллеж шинээр байгуулсан байна. Гэвч багш бэлтгэх сургуулийн оюутнуудын 20 гаруй хувь нь буюу нийт эмэгтэй оюутнуудын бараг 40% нь нийслэл Кабул хотод суралцаж байгаа нь багш хуваарилалт хот суурин газруудад төвлөрөх магадлалтай байгааг харуулж байна.

Энэхүү тэнцвэргүй байдлыг арилгах үүднээс Боловсролын Яам нь орон нутгийн иргэдийн байгууллагын хувийн сургуулиудыг засгийн газрын тогтолцоонд оруулах бодлого хэрэгжүүлсэн байна. Үүний нэг чухал арга хэмжээ бол урьд нь багш нарт нутгийн иргэдийн байгууллагаас алдаг оног цалин олгодог байсан бол төрийн цалингийн сүлжээгээр цалинждаг болсон байна. Энэхүү санаачлага, үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд Боловсролын Яам болон төрийн бус 4 байгууллага онцгой үүрэг гүйцэтгэсэн.

Сургалтын үр дүнгээс хамааран цалин, хөлс тогтоох нь. Сурагчдын сурлагын амжилтаас шалтгаалан багш нарыг урамшуулах нь багшийн ажиллах дур сонирхол, хариуцлагыг дээшлүүлэхэд чиглэсэн нэг арга юм. Гэхдээ үүнийг бодлогын үүднээс авч үзэхэд төвөгтэй бөгөөд нилээн маргаантай юм. Үүнтэй санал нэг биш хүмүүс төстийн үнэлгээг үндэслэж багш нарт урамшуулал олгох нь заах хичээлийн хүрээг багасгах, тааруу сурлагатай хүүхдүүдийг орхигдуулах зэрэг муу үр дагавартай гэж үзэж байна.

Цөөн хэдэн улс орон л боловсролын

тогтолцоондоо сургалтын үр дүнгээс хамааран цалин, хөлс олгох шинэчлэлийг өргөн хүрээтэйгээр нэвтрүүлсэн хэдий ч хөгжингүй болон хөгжиж буй улс орнуудын аль алинд тодорхой үр дүн харагдахгүй байна. Америкийн Нэгдсэн Улсад хийсэн судалгаануудаас харахад сургалтын үр дүнгээс хамааран цалин, хөлс олгох явдал нь багшийн ажлын үр дүнд төдийлөн нөлөөлөхгүй байна. Түүнчлэн, сургалтанд төстийн аргыг хэт ашиглах нь тэгш байдлыг хангахад сөрөг үр дагавар авчирч болох юм. Чилид жишээлбэл, ажлыг нь сайжруулах шаардлагатай байгаа сургуулиудад анхааралгүйгээр үйл ажиллагаагаа амжилттай явуулдаг сургуулиудыг дэмжин, урамшуулахад чиглэгдсэн хөтөлбөрийг хэрэгжүүлж байна. Энэтхэг, Кенид хийсэн жижиг туршилтуудаас үзэхэд төстийн сургалтын үр дүн сайжирсан нь багш нар хичээлээ заахдаа сургалтын хөтөлбөрийн бусад талуудыг орхигдуулан зөвхөн төстэнд бэлтгэж, ихэвчлэн хамгийн шилдэг сурагчидтай ажиллаж байгаа хандлагуудыг олж тогтоосон байна. Харин Кенийн хувьд, сурлагын амжилтын сайн үр дүн богино настай байгааг харуулжээ.

Сурагчдын сурлагын амжилт олон хүчин зүйлээс шалтгаалдаг зэрэг олон зүйлээс үүдэн сургалтын үр дүнгээс хамааруулан багш нарын хөдөлмөрийг урамшуулах нь амархан асуудал биш юм. Үүний хамт ажилдаа сэтгэл ханамжтай байх төрийн сургуульд ажиллах нэр хүнд болон ажиллах нөхцөл зэрэг хүчин зүйлүүд нь мөнгөн урамшууллаас илүүтэйгээр багш нарыг идэвхжүүлэхэд нөлөөлж болох юм.

Боловсролын чанар болон тэгш байдлыг хангахад чиглэсэн хяналт үнэлгээ

Боловсролын хяналт үнэлгээг сайжруулахын тулд өргөн цар хүрээтэй хоёр бодлогыг батлан гаргасан. Үүнд: өргөн хүрээг хамарсан сурлагын амжилтын үнэлгээг хэрэглэх болон сургуулийн үйл ажиллагаанд тавих хяналт, шалгалтын тогтолцоонд шинэчлэлт хийх явдал юм.

Сурлагын амжилтын үнэлгээ: өргөн хүрээний хамралт ба төлөвлөлтийн

уялдаа холбоо сул байна. Өнөөдөр ажиглагдаж байгаа Сурлагын амжилтанд улс орон даяар нэгдсэн үнэлгээ хийх явдал нь сүүлийн үед тооны хувьд өсч байгаа нь сургалтын үр дүнд онцгой анхаарал тавьж байгаагийн илрэл болж байна. 2000-2006 оны хооронд дэлхийн улс орнуудын бараг хагас нь доод тал нь нэг удаа үндэсний хэмжээнд сурлагын амжилтын үнэлгээ хийсэн байна. Эдгээр орнуудын эгнээнд хөгжиж буй орнууд өргөнөөр хамрагдах хандлагатай байна.

Хамгийн сүүлийн үед хийсэн сурлагын амжилтын үнэлгээнүүд нь боловсролын системийн үр дүнгийн үзүүлэлтийг бүхэлд нь тоон үзүүлэлтээр тодорхойлоход чиглэгдсэн байна. Сургуулийн төгсөлтийн шалгалт зэрэг бусад төрлийн үнэлгээнүүд нь багш, сурагчдын ажлын үр дүнгийн үзүүлэлтийг үнэлж, тогтооход чиглэгдсэн байна. Баримтаас харахад дунд сургуулийн тогтсон стандартаар төгсөлтийн шалгалтаа өгдөг улс орнуудад дунд сургуулийн сурагчид илүү амжилттай суралцаж байна. Сургуулийн сурлагын дундаж дүнг өсгөхөд сул сурлагатай хүүхдүүд саад болж байна. Кенид хийсэн судалгаагаар 6-аас 7 дугаар ангид олон сурагч дэвшин суралцаж чадаагүй байна. Үүний учир нь бага сургуулийн төгсөх шалгалтанд сурлага муутай хүүхдүүдийг хамруулаагүйгээс болсон байна. Сургуулийн сурлагын дундаж үзүүлэлтээ сурлагын түвшин доогуур сурагчдаас болж бууруулахыг сургуулиуд тэр бүр хүсдэггүй.

Бодлого боловсруулахдаа хяналт үнэлгээг хэрэглэх нь. Улсын хэмжээний сурлагын амжилтын үнэлгээний үр дүн нь бодлого боловсруулахад мэдээллээр хангах чухал үүрэг гүйцэтгэнэ. Дараах жишээнүүд энэ талаар үйл ажиллагааны үндсэн чиглэлүүдийг тодорхойлж байна.

- **Сургалтын доод стандартыг тогтоосон хяналтын үзүүлэлтүүд.** Лисото болон Шри Ланкад үндэсний сурлагын үнэлгээ нь сургалтын хамгийн доод стандартыг тогтооход хэрэглэгддэг ба үүнтэй холбоотойгоор сурагчдын сурлагын амжилтыг муж,

аймаг бүрээр хянан шалгадаг байна.

- **Сургалтын хөтөлбөрийг шинэчлэхэд мэдээллээр хангах нь:** Румынд Олон улсын математик, шинжлэх ухаан судлалын хүрээнд (TIMSS) хийсэн үнэлгээний дүн муу гарсан нь түгшүүрийн дохио болсон. Үүний үр дүнд, засгийн газар нь математик болон шинжлэх ухааны хичээлийн сургалтын хөтөлбөрөө өөрчилж, багш нарт зориулсан шинэ гарын авлага сургалтын материалуудыг бэлтгэн гаргажээ.
- **Бодлогыг хянан үзэх нь:** Сенегалд 1995 оноос 2000 онд хийсэн үнэлгээгээр анги улиран сурах нь бага сургуулийн сургалтын үр дүнд сөрөг нөлөө үзүүлж байгаа нь тогтоогдсон байна. Иймээс зарим бага ангиудад давтан сургах явдлыг хориглосон байна.
- **Боловсролын төлөвлөлт, шинэчлэлд хувь нэмрээ оруулах нь:** Өмнөд Сахарт хийсэн Боловсролын чанарыг хянах Өмнөд Африкийн Консерциум (SACMEQ)-аас явуулсан сургалтын үнэлгээний үр дүнг Мауритиус, Намиб, Замби, Занзибар, болон Зимбабид боловсролын салбар ба дэд салбарын шинэчлэлийг төлөвлөхөд хэрэглэж ирлээ.

Засгийн газрууд боловсролын чанар, тэгш байдлыг хянан шалгах үр дүнтэй систем боловсруулж, хангалттай санхүүжүүлэх болон үнэлгээнээс гарсан сайн үр дүнг бодлого боловсруулалт ба хэрэгжүүлэлтэд ашиглах шаардлагатай.

Үндэсний хэмжээний үнэлгээг сургуулийн түвшинд явуулах хяналт үнэлгээтэй хослуулах нь

Сургууль нь хичээлийн анги танхимыг боловсролын яамдтай шууд холбох цорын ганц байгууллага болохын хувьд сургуулийн хяналт шалгалт бол боловсролын системийг удирдахад шийдвэрлэх ач холбогдолтой. Сургуулийн

ажилтай ирж танилцсанаар хяналтын мэргэжилтнүүд сургуулийн бодит байдлын талаар шийдвэр гаргагчдад мэдээлэл өгөхийн зэрэгцээ сургуулийн хэмжээнд бодлогын хэрэгжилтэд хяналт үнэлгээ хийх, түүнийг дэмжих боломжтой болдог юм. Хөгжиж буй орнуудад сургуулийн үйл ажиллагаанд хийх хяналт шалгалтын системийн талаар тун бага судалгаа хийж байна. Зарим ажиглалтаас үзэхэд ийм судалгаанд бараг мөнгө зардаггүй байна. Зарим оронд хамгийн сул муу сургуулиудад илүү чиглэж ажилласан байна. Чили улсад хэтэрхий олон байгууллагыг хянан шалгаж, ажиллахын оронд хянан шалгагч нар харьцангуй цөөн сургуультай хамтран ажиллаж, тэдэнд дэмжлэг тусалцаа үзүүлж байна. Хянан шалгагч нарыг сургуулийн үйл ажиллагааг илүү дэмжин туслахад чиглүүлэхийн тулд ажил үүргийн шинэ хуваарь гаргаж, шинэ ажлын байр бий болгож, шинэ ажиллах хүчнийг бэлтгэх санаачлагыг гаргасан байна.

Боловсрол болон ядуурлыг бууруулах асуудалд цогцоор хандах нь: тасарсан холбоос

Засгийн газрууд Дакарт уулзалдахдаа БНБ-ын бодлогыг ядуурлыг бууруулах болон хөгжлийн бодлого, стратегитэй нягт уялдуулахыг уриалсан. Боловсролыг ядуурал болон тэгш бус байдлыг бууруулах өргөн хүрээтэй бодлого, ялангуяа ядуурлыг бууруулах стратегийн баримт бичгүүдийн хүрээнд яаж, ямар хэмжээнд нэгтгэж болох вэ?

Боловсролын төлөвлөлт: хүчтэй тууштай байх ёстой гэвч хараахан тийм биш байна.

Засгийн газрууд өөрсдийн зорилго, эн тэргүүнд шийдэх асуудал болон стратеги, мөн тэдгээрийг хэрэгжүүлэх санхүүгийн үүрэг амлалт болон зорилтуудаа үндэснийхээ төлөвлөгөөнд тодорхой зааж, оруулсан байдаг. 2000 оноос хойш олон оронд боловсролын төлөвлөлт сайжирч тодорхой үр дүнд хүрч, стратегийн тэргүүлэх чиглэл, Салбар дамнасан

хандлага, арга барил (SWAp) болон дунд, урт хугацааны төлөвлөгөөг илүү тодорхой боловсруулан гаргадаг болжээ.

Хэдийгээр олон зүйл дээр амжилт гарсан хэдий ч боловсролын салбарын системчилсэн төлөвлөлт дор хаяад 4 хүрээнд асуудалтай хэвээр байна. Нэгдүгээрт, Стратеги болон төсвийн холбоо, харилцан уялдаа сул байгаа бөгөөд төлөвлөгөөг төсвийн бодит хуваарилалтаар дэмжиж чадахгүй байна. Хоёрт, төлөвлөлтийн баримт бичгүүдэд нийгэм, эсвэл улс төрийн нөхцөл байдлыг тэр бүр тооцоолж үзэхгүй байна. Гуравт, бага насны хүүхдийн халамж үйлчилгээ, боловсрол (ЕССЕ)-ын үндсэн асуудлууд, бичиг үсэг болон албан бус боловсролын талаарх асуудлууд ихэнх төлөвлөгөөнд орхигдож байна. Дөрөвт, төлөвлөлт нь боловсролд нөлөөлөх бусад салбарууд болох бүх нийтийн эрүүл мэнд, хүүхдийн хоол тэжээл зэрэг асуудалтай уялдаа холбоо тийм ч хангалттай биш байна. Эдгээр хүчин зүйл нь бүх нийтийн боловсролын хүртээмж, чанарыг хангах талаарх зорилтуудыг хэрэгжүүлэх боловсролын төлөвлөлтийн боломжийг хаан боогдуулж байна.

*Ядуурлыг бууруулах стратеги:
Шинэ үеийнхэн, хуучин асуудлууд*

Ядуурлыг бууруулах стратеги төлөвлөгөөнүүддээ засгийн газрууд хөгжлийн эн тэргүүний зорилтуудаа өргөнөөр тусгаж, олон улсын тусламж үзүүлэх салбаруудаа тодорхойлдог. Одоогийн байдлаар 54 орон Ядуурлыг бууруулах үйл ажиллагааны стратеги төлөвлөгөөтэй ажиллаж байна. Тэдгээрийн ихэнх нь бага орлоготой орнууд бөгөөд тэн хагасаас илүү нь Өмнөд Сахарт оршдог. Энэхүү тайлангаар анхны буюу хоёрдахь удаагийн Ядуурлыг бууруулах стратеги төлөвлөгөөгөө боловсруулсан 18 оронд хийсэн дүн шинжилгээг танилцуулна. Цөөн хэдэн ололт амжилт гарсан ч гэлээ Ядуурлыг бууруулах олон стратеги төлөвлөгөө нийгмийн хамгийн эмзэг бүлгийнхний боловсролын асуудлуудыг шийдвэрлэх талаар хагас дутуу оролдлого хийсэн байна. Тодруулж хэлбэл, Ядуурлыг

Засгийн газрууд боловсролын чанар, тэгш байдлыг хянан шалгах үр дүнтэй систем боловсруулж, хангалттай санхүүжүүлэх болон үнэлгээнээс гарсан сайн үр дүнг бодлого боловсруулалт ба хэрэгжүүлэлтэд ашиглах шаардлагатай.

бууруулах стратеги төлөвлөгөө нь дараах 4 үндсэн хүрээ, чиглэлээр боловсролыг орхигдуулж байна. Үүнд: БНБ-ын хөтөлбөртэй уялдаа холбоотой байх; тодорхой зорилтууд тавих, засгийн газрын өргөн хүрээний шинэчлэл, салбар дамнасан төлөвлөлтийн нэгдэл зэрэг орно.

БНБ-ын хөтөлбөр, зорилттой уялдаа холбоо сул байна: Ихэнх Ядуурлыг бууруулах стратеги төлөвлөгөө нь 2015 он гэхэд бүх нийтийн бага боловсролд хүрэх тоон зорилтыг хэрэгжүүлэхэд БНБ-ын бусад зорилтуудаас илүү өндөр ач холбогдол өгчээ. БНБ-ын өргөн хүрээний зорилтууд нь ядуурлыг бууруулах өргөн хүрээний хөтөлбөрт багаахан байр эзэлсэн эсвэл огт тусгагдаагүй байна. Бага насны хүүхдийн халамж үйлчилгээ, боловсрол (ЕССЕ) болон бичиг үсгийн боловсролын асуудлыг шийдвэрлэхэд олон салбарын зохицуулалт шаардагдана. Гэвч энэ холбоо харилцаа нь харамсалтай нь Ядуурлыг бууруулах стратеги төлөвлөгөөнд орхигдсон нь гайхшрал төрүүлж байна. Үндэсний Ядуурлыг бууруулах стратеги төлөвлөгөөнд бичиг үсгийн боловсрол олгох ухаалаг бодлогыг Засгийн газар болон НҮБ-ын төрөлжсөн байгууллагуудын хоорондын нягт хамтын ажиллагаатай уялдуулан тусган холбож амжилтанд хүрч байгаа Мадагаскарын албан бус боловсролын хөтөлбөрийг жишээ болгон дурьдаж болно. Тодорхой зорилт дэвшүүлэн тавихад гарч байгаа бэрхшээлүүд. Ядуурлыг бууруулах стратеги төлөвлөгөөнд бодит байдалд нийцэхгүй болон таарч тохирохгүй зорилт тавих нь түгээмэл байдаг бөгөөд тийм зорилго, стратеги болон санхүүгийн бололцоо, амлалтууд нийцэхгүй байх нь олонтаа. Жишээ нь: Камбожид дэвшүүлсэн төлөвлөлтийн зорилтууд нь төсвийн боломжтой нийцэхгүй байна. Түүнээс гадна зөвхөн цөөн хэдэн орон боловсрол дахь тэгш байдалд хяналт үнэлгээ хийх тодорхой зорилт тавин ажиллаж байна. Зорилт боловсруулан тавихдаа зарим орон хүйсийн харилцааг илүү анхаардаг хэдий ч үндэс угсаа, ядуурал зэргээс үүдэх тэгш бус байдал их байгаа бусад зарим салбарт тийм биш байна.

Боловсролын бодлого стратеги болон удирдлагын шинэчлэлийн хооронд уялдаа холбоогүй байна. Ядуурлыг бууруулах стратеги төлөвлөгөөнд удирдлагын өргөн хүрээний шинэчлэлтэй холбоотой үндэсний үүрэг амлалтууд ихэнхдээ туссан байдаг. Хэдий тийм ч боловсрол дахь шудрага тэгш байдлыг хангах талаар шинэчлэлтэй холбоотой асуудлууд, тэр бүү хэл сайн үр дүн нь илт тодорхой байгаа шинэчлэлийн асуудлуудыг нарийвчлан авч үзэж тусгах нь нэн ховор байна. Төвлөрлийг сааруулах нь нэг тод жишээ юм. Ерөнхийдөө, цөөн хэдэн орны Ядуурлыг бууруулах стратеги төлөвлөгөөнд боловсролын төлөвлөлт болон ядуурлыг бууруулах өргөн далайцтай хүчин чармайлт хоёрын харилцан уялдаа холбоог бэхжүүлж чадах удирдлагын шинэчлэлийг хангаж чадахгүйц тийм практик стратегийг боловсруулсан байна.

Салбар дамнасан арга хандлагад боловсролын асуудлыг орхигдуулсан нь. Ядуурал, хүйсийн ялгаа, оршин сууж буй газар орны байршил болон соёлын ялгаатай байдал зэрэг хүчин зүйлээс хамааралтай боловсролын салбарт амь бөхтэй оршсоор байгаа тэгш бус байдлыг арилгахын тулд боловсролын салбараас халин гарсан өргөн хүрээтэй бодитой бодлого боловсруулахыг шаардаж байна. Ядуурлыг бууруулах стратеги төлөвлөгөөнүүдэд хийсэн судалгаанаас үзэхэд хүйсийн байдал, хүүхдийн хоол, тэжээлийн хомсдол, ДОХ, хөгжлийн бэрхшээл, ялгаварлан гадуурхах болон зөрчил, мөргөлдөөн зэрэг боловсролын салбараас өөр бусад салбарын санаачлага БНБ-ын хөгжилд онцгой шаардлагатай хүрээ чиглэлд уялдаа холбоо огт байхгүй юмуу хангалтгүй байгаа нь харагдаж байна.

Хүн амын ядуу болон эмзэг бүлгийнхний нийгмийн цогц хамгаалал

Хэдийгээр Ядуурлыг бууруулах стратеги төлөвлөгөө нь цогц асуудлыг бүхэлд нь хангаж чадахгүй байгаа ч гэсэн, зарим нэг ашиглаж болохуйц нааштай туршлага, үр дүн гарч байна. Нийгмийн хамгааллын хөтөлбөрүүд нь эрүүл мэнд, хүнс тэжээл, хүүхдийн хөдөлмөр зэрэг асуудлуудыг

Боловсролын салбарт оршсоор байгаа тэгш бус байдлыг арилгахын тулд боловсролын салбараас халин гарсан өргөн хүрээтэй бодитой бодлого боловсруулахыг шаардаж байна.

шийдвэрлэх замаар боловсролд чухал хувь нэмэр оруулж байна. Бразил, Чили, Эквадор, Мексик зэрэг Латин Америкийн орнуудад мөнгөн хэлбэрээр дэмжлэг, тэтгэмж үзүүлж байгаа нь амжилттай хөтөлбөр болж байна гэж үзжээ. Жишээ нь, Бразилийн Болса Фамилиа хөтөлбөр нь ойролцоогоор 11 сая гэр бүлд хүрч чадсан ба тэдний ихэнх нь ядуучууд юм. Энэ хөтөлбөрийн зорилго нь хүүхдүүдээ сургуульд хамруулах ба тэднийг тогтмол эрүүл мэндийн хяналтанд байлгах нөхцөлтэйгөөр хүүхэдтэй ядуу гэр бүлийнхэнд сард \$35 хүртэлх ам.долларын мөнгөн тэтгэмж олгодог ажээ. Өмнөд Америкт хийсэн саяхны судалгаагаар хүүхэд насанд нь хүүхдийг илүү халамжлах хөтөлбөрт удаан хугацаанд хамрагдсан хүүхдүүд бусдыгаа бодвол илүү сайн хооллож байсан байна. Энэ хөтөлбөр нь түүнчлэн сургуульд хамрагдалтад сайнаар нөлөөлжээ.

Энэ хэлбэрийн хөтөлбөрүүд нь нилээн амжилттайд тооцогддог ба Америк Нэгдсэн Улсад тийм хөтөлбөрийг туршилт байдлаар батлан хэрэгжүүлжээ (Оруулга 7). Ийнхүү өөр бусад нөхцөлтэйгээр ч

салбар хоорондын ийм хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд зориулж, улсын төсөв, тусламжийг нэмэгдүүлэх асуудлыг авч үзэх бүрэн үндэслэл байгаа юм.

Оруулга 7: Нью-Йорк Мексикийн Опортюнитэдэс хөтөлбөрөөс суралцаж байна.

Нью-Йорк хот нь Мексикийн Опортюнитэдэс хөтөлбөрийн үндсэн дээр загвар хөтөлбөрийг туршиж байна. Опортюнити НҮС нь ядуурал, ажилгүйчүүд харьцангуй өндөр дүүргүүдийн 5000 гаруй гэр бүлийг хамарсан туршилтын хөтөлбөр юм. Хоёр жилийн хугацаатай \$53 сая ам.долларын төсөвтэй энэ хөтөлбөрийг Рокфеллер Сан болон бусад хандивлагчдын хамтаар санхүүжүүлж байна. Хөтөлбөрт хамрагдсан айл өрхүүд эрүүл мэндээ хамгаалах, ажилд орох, бэлтгэл сургалтад хамрагдах ба боловсрол эзэмших зэрэг шаардлагыг бүрэн биелүүлнэ гэсэн нөхцөлтэйгөөр жилд \$4000-\$6000 ам.долларын дэмжлэг авах боломжтой юм. Боловсролтой холбоотой нөхцөл гэдэгт хичээл сургуульдаа тасралтгүй явах, багш нарын хуралд эцэг эхчүүдийг оролцуулах, номын санд суух хэрэглэгчийн карттай болох зэрэг орно. Хөтөлбөрийн ерөнхий хандлага нь зөвхөн ядуучуудын өнөөгийн зовлон бэрхшээлийг даван туулах биш харин амьдралынхаа нөхцөл байдлыг өөрчлөхөд нь өдөөн идэвхжүүлэх санхүүгийн дэмжлэг үзүүлэх явдал юм.

Мексикийн Опортюнитэдэс хөтөлбөр ядуу болон уугуул нутгийн хүмүүст хүрч байна.



Ядуурлыг
бууруулах
бодлого
стратегийн
үнэлгээнүүд
нь ядуурал
болон эмзэг
байдлын
үндэс суурь
болсон
шалтгаа-
нуудыг
шинээр
эргэн харах
боломжийг
бий
болгосон
юм.

*Хамгийн эмзэг бүлгийнхэнд зориулсан
өргөн оролцооны төлөвлөлтийг
бэхжүүлэх нь*

Дакарын үйл ажиллагааны хүрээгээр дэмжигдэн, мөн Ядуурлыг бууруулах стратеги төлөвлөгөөний явцын нэг хэсэг болохын хувьд иргэний нийгмийн байгууллагууд болон тийм байгууллагуудын үндэсний эвсэл, холбоод нь үндэсний боловсролын төлөвлөгөөг батлан гаргахад ихээхэн нөлөөтэй. Хэдийгээр ядуучуудад хүргэх тэдний дуу хоолой, үйл ажиллагаа хязгаарлагдмал байдаг ч гэсэн ядуу болон эмзэг бүлгийнхэнд үзүүлэх дэмжлэгийг улам өдөөн идэвхжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг. Эмзэг бүлгийнхнийг шууд хамран оролцуулахад чиглэгдсэн сонирхогч талуудын өргөн оролцоотой ядуурлыг бууруулах стратегийн үнэлгээнүүд нь олон оронд Ядуурлыг бууруулах стратеги төлөвлөгөөг боловсруулахад санал асуулгын хэлбэрээр хийгдсэн байдаг бөгөөд тэдгээр нь ядуурал болон эмзэг байдлын үндэс суурь болсон шалтгаануудыг шинээр

эргэн харах боломжийг бий болгосон юм. Угандад цуглуусан баримт, нотолгоонууд нь үндэсний хэмжээнд ядуурлыг бууруулах эн тэргүүний чиглэлүүдийг тодорхойлоход шууд нөлөөлсөн. Түүнчлэн ядуурлыг бууруулах стратеги төлөвлөгөөний баримт бичгүүдийг нийтэд илүү хүртээмжтэй болгох оролдлого хийгдсэн. Жишээ нь: Балба улс өөрийн хэлдээр орчуулсан байна.

Ийнхүү Зөвлөх байдлаар дэмжлэг үзүүлж байгаа нь сайшаалтай хэрэг боловч тэр нь хязгаарлагдмал шинжтэй байна. Бичиг үсгийн боловсролын асуудал болон байгууллагын сул дорой хүчин чадавхи зэрэг олон шалтгаанаас ядуу, эмзэг бүлгийнхэнд анхаарч ажиллахад олон талын бэрхшээл гардаг. Ядуучуудын хэрэгцээ, шаардлагыг харгалзан үзэх болон тэрхүү хэрэгцээ шаардлагыг засгийн газрын бодлого, шинэчлэлд тусган оруулахад бодитой зөвлөгөө үзүүлэх нь улс төрийн тууштай хүсэл зориг болон үндэсний үүрэг хариуцлага, тэгш байдлыг хангахад чиглэгдсэн хүсэл эрмэлзлэл, зорилгоос хамаарна.

БҮЛЭГ 4.

Тусламжийг нэмэгдүүлэх ба удирдлагыг сайжруулах нь

2000 онд дэлхийн боловсролын зорилгыг дэвшүүлэн тавьж байхад, хөгжиж буй орнууд үндэсний хэмжээнд боловсролын төлөвлөлтийг бэхжүүлэх, тэгш бус байдлыг арилгах болон хариуцлага хүлээж ажиллахын төлөө үүрэг амлалт авцгаасан билээ. Баян орнууд санхүүгийн ямар нэг асуудлаас болж баталгаатай хүлээн зөвшөөрөгдсөн үндэсний төлөвлөгөө хэрэгжихгүй бүтэлгүйтэх явдлыг гаргахгүй байхыг баталгаатай хангах үүрэг амлалт авчээ. Тусламжийг нэмэгдүүлэх ба илүү үр дүнтэй тусламж үзүүлэх нь БНБ-ын зорилгод хүрэхэд чухал ач холбогдолтой. Хандивлагч нар өөрсдийн амлалтаа хэрэгжүүлж байна уу?

Энэхүү Тайлан боловсрол болон суурь боловсролд үзүүлэх тусламжийн талаарх хамгийн сүүлийн үеийн мэдээллийг судлан үзсэний хамт тусламжийг эзэнд нь хүргэх арга замыг сайжруулах талаар хандивлагч болон бусад улс орнуудын санал санаачлагуудыг дүгнэн танилцуулж байна.

Боловсролд зориулсан тусламж

Нийт тусламжийн урсгал: хандивлагч нар өөрсдийн үүрэг, амлалтаа хэрэгжүүлэхгүй байна.

Олон улсын тусламж нь боловсролын хүртээмжийг нэмэгдүүлэх, тэгш байдлыг дэмжих болон боловсролын чанарыг сайжруулахад чиглэгдсэн үндэсний бодлогыг хэрэгжүүлэхэд дэмжлэг тусалцаа үзүүлэхэд шийдвэрлэх үүрэг гүйцэтгэдэг. Танзаны Нэгдсэн БНУ-ын боловсролын

салбарын стратегид дэмжлэг, тусалцаа үзүүлснээр 1999 оноос хойш сургууль завсардсан хүүхдүүдийн тоог 3 саяар бууруулж чадсан. Этиопид гадны хандивын тусламж, дэмжлэгтэйгээр боловсролд зориулсан нийт төсвийн хэмжээ 1999 онд ДНБ-ний 3.6% байсан бол 2006 онд 6% хүртэл өссөн байна. Үүний зэрэгцээ сургууль завсардсан хүүхдийн тоо 7 сая байснаа 3.7 сая болж буурсан. Тусламж, дэмжлэг аваагүй бол үүнээс олон хүүхэд сургууль завсардаж, эсвэл нэг ангид хэтэрхий олноороо хичээллэх буюу ном, сурах бичиг, ширээ сандал хүрэлцэхгүй байх байсан.

Хэдийгээр тусламж нь олон оронд БНБ-ын зорилгууд ба МХЗ-уудыг хэрэгжүүлэхэд чухал нөлөөтэй ч тусламж үзүүлж байгаа дэлхийн чиг хандлага нь анхаарч үзэх

График 10. Боловсрол болон суурь боловсролд зориулах нийт тусламжийн хэмжээ, 1999-2006



Эх сурвалж: 2009 оны БНБ-ын Хяналт үнэлгээний Дэлхийн Тайлангийн График 4.3 -ийг үзнэ үү.



Нутгийн хүмүүст боломж олгож байгаа нь: Эмзэг бүлгийн эмэгтэйчүүд цугларан бие биентэйгээ мэдээлэл солилцож, мөн тэдэнд тулгарсан асуудлуудын талаар бодол сэтгэгдлээ хуваалцаж байна.

сэтгэл зовоосон асуудал болж байна. Ихэнх хандивлагчид хөгжлийн төлөөх албан ёсны тусламж (ODA)-ийг нэмэгдүүлэх талаарх үүрэг, амлалтаа бүрэн хэрэгжүүлж чадахгүй байгаа ба 2010 он гэхэд өмнөө тавьсан зорилтоо хэрэгжүүлэхийн тулд тусламжаа урьд өмнө байгаагүй хэмжээгээр нэмэгдүүлэх хэрэгтэй болоод байна.

Тусламжийн хэмжээ нэмэгдэх хандлагатай байсан 2005 онд хандивлагчид боловсролын салбарт 2004 онд \$80 тэрбум ам.долларын тусламж үзүүлж байсан бол энэхүү тусламжийн хэмжээг 2010 он гэхэд \$130 тэрбум ам. доллар (2004 оны ханшаар) болгон нэмэгдүүлэх амлалт авч байсан.

Хөгжлийн төлөөх албан ёсны тусламж нь 1990 оноос 2005 оны хооронд жил бүр 8%-иар өссөн бөгөөд 110 тэр бум долларт хүрчээ. Гэвч тусламжийн хэмжээ дараагийн 2 жилийн турш буурч \$97 тэрбум доллараас бага болсон байна. Хандивлагч нар Хөгжлийн төлөөх албан ёсны тусламжийг 2010 он гэхэд нэмэгдүүлэхээр төлөвлөж байсан тэр хэмжээнд хүрэхэд хол байна гэдгийг Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагаас хийсэн цаашдын тусламжийн төлөвлөлтийн үнэлгээ харуулж байна. Ийнхүү урьд амласан үүрэг, амлалтаа хэрэгжүүлэхэд дахин \$30 тэрбум доллар шаардагдаж байна.

Боловсролд зориулах тусламж зогсонги байдалтай байна

Хөгжингүй орнууд 2000 онд Дакарын үйл ажиллагааны хүрээнд гарын үсэг зурахдаа БНБ-ын зорилгод хүрэхэд улс орнуудыг дэмжиж, туслах үүднээс шаардлагатай нэмэлт санхүүгийн дэмжлэг үзүүлнэ гэсэн үүрэг амлалт авч байжээ. Тэр цагаас хойш эдгээр амлалтуудаа дахин хэд хэдэн удаа баталгаажуулж байсан. Гэвч хамгийн сүүлийн үеийн баримтаас харахад боловсролд үзүүлэх тусламж, ялангуяа суурь боловсролд үзүүлэх тусламж удаашралтай байгааг харуулж байна.

Боловсролын салбарт үзүүлэх тусламжийн хэмжээ нь тусламжийн ерөнхий чиг хандлагыг бүхэлд нь тусгаж байдаг. 1999 оноос 2004 оны хооронд боловсролд зориулсан тусламж харьцангуй өссөн (\$7.3-\$11 тэрбум доллар болтол) боловч 2005 онд 23%-иар буурсан байна. Суурь боловсролд үзүүлсэн тусламж мөн адил 2004 онд \$5.2 тэрбум доллар байснаа 2005 онд \$3.7 болж буурсан. 2006 он гэхэд үзүүлсэн тусламжийн хэмжээ дахин нэмэгдсэн ч 2004 оны түвшингээс доогуур байлаа (График 10). 2007 оны тайлангаас үзэхэд БНБ-ын зорилтуудаас зөвхөн 3-ыг нь тухайлбал, бүх нийтийн бага боловсрол, насанд хүрэгчдийн бичиг үсгийн боловсрол, бага насны хүүхдийн халамж анхаарал, боловсролын зэргийг доогуур орлоготой орнуудад хэрэгжүүлэхтэй холбоотой үйл ажиллагааг дэмжихэд жил бүр \$11 тэрбум долларын тусламж шаардагдаж байна. Өнөөгийн тусламжийн хэмжээ нь зорилгынхоо хаана нь ч хүрэхгүй байгаа төдийгүй, зорьсон хэмжээнд хүргэхийн тулд энэ хэмжээг 3 дахин өсгөх шаардлагатай байна.

Тухайн жилүүдэд улс орнуудад олгосон тусламжийн хэмжээ нь урьдах жилүүдийн зорилтын хэрэгжилтэд тулгуурладаг байна. Боловсролд зориулсан тусламж 2006 онд \$9.0 тэрбум долларт хүрсэн ба энэ нь 2002 оны байдалтай (\$5.5) харьцуулахад нэмэгдсэн байна. Үүнийг дагаад мөн бага боловсролд үзүүлсэн тусламжийн хэмжээ 2002 онд зарцуулсан \$2.1 тэрбум

доллартай харьцуулахад 2006 онд \$3.5 болж өссөн байна. Хэдийгээр ийнхүү өссөн ч 2004 оноос хойш тусламж буурч, идэвхгүй байдалд орсон нь цаашид тусламжийн өсөлтийг удаашруулж, зогсонги байдалд ч хүргэж болох юм.

Тусламжийг хамгийн их хэрэгцээтэй байгаа хүмүүст олгох: Тэгш, шудрага байдалд ахиц, дэвшил гарч байна уу?

БНБ-ын зорилгод хүрэхэд тусламж хамгийн их хэрэгтэй байгаа тэр орнуудад тусламж хүрч чадаж байна уу? 2006 онд орлогын түвшин доогуурт тооцогддог 68 орны боловсролын салбарт \$6.4 тэрбум долларын тусламж үзүүлсэн ба нийт тусламжийн хэмжээний 75% нь бага боловсролд зориулагдсан нь 2000 оноос хойшхи хамгийн өндөр үзүүлэлт юм (2004 оныг оруулахгүйгээр) Эдгээр эерэг хандлагуудаас гадна, боловсролд зориулсан тусламжийн 2/5 ба суурь боловсролд зориулсан тусламжийн 1/4-ээс илүү хувь нь дунд орлоготой хөгжиж буй орнуудад хуваарилагдсан байна. Хамгийн ядуу 50 улсын хувьд нийт тусламжийн суурь боловсролд зориулагдсан хэмжээ бараг хэвээрээ байсан ба 2000-2002, 2003-2005 онуудын хооронд 45%-иас 46% болсон байна.

Ялангуяа, ядуу буурай хэмээн тодорхойлогддог улс орнуудад боловсролын тусламж хамгийн их шаардлагатай байдаг. Гэвч 2006 оны байдлаар эдгээр 35 орны боловсролын салбарт \$1.6 тэрбум долларын тусламжийг олгосон ба үүний \$0.9 тэрбум доллар нь суурь боловсролд зориулагдаж байжээ. Тэдгээр орнуудад олгосон тусламжийн хэмжээг нийт хүн амтай нь харьцуулж үзвэл бусад бүх доогуур орлоготой орнуудад олгодог тусламжаас бараг илүүгүй байна.

Тусламжийг илүү үр ашигтай, үр дүнтэй зарцуулдаг улс орнуудад илүү тусламж үзүүлдэг үү? Тусламж хамгийн их шаардлагатай байгаа болон түүнийг хамгийн үр ашигтай зарцуулж байгаа улс орнуудад тусламж олгоход илүү чиглэгддэг гэсэн зарим нэг баримт байдаг хэдий ч энэ

Хамгийн сүүлийн үеийн баримтаас харахад боловсролд үзүүлэх тусламж, ялангуяа суурь боловсролд үзүүлэх тусламж удаашралтай байгааг харуулж байна.

нь амьдрал дээр төдийлөн хэрэгжихгүй байна. Үнэн хэрэгтээ, тусламж хамгийн их хэрэгцээтэй байгаа болон амжилт гаргаж байгаа улс орнуудад тусламжийг нэмэгдүүлэх бүхий л бололцоо байгаа.

Хандивлагчдын тусламжийн үр шим, харилцан адилгүй үр дүн


Харамсалтай нь хандивлагчид тэр болгон, өөрсдийн хөтөлбөрүүдийн хүрээнд ч тэр, Үр дүнд түргэн хүрэх санаачлагын Каталик санд дэмжлэг үзүүлэхдээ ч тэр, БНБ-д хүрэх зорилтыг тэргүүлэх чиглэл болгон тавьж чадахгүй байна. Суурь боловсролд үзүүлэх тусламжийн хэмжээ 2005-2006 оны хооронд өссөн хэдий ч энэ нь олон улсын хамтын нийгэмлэгийн өргөн хүрээтэй хүчин чармайлт гэхээсээ илүү цөөн хэдэн хандивлагчдын үйл ажиллагааны үр дүн юм.

2006 онд боловсролд зориулсан нийт тусламжийг цөөн тооны хандивлагч нар бүрдүүлсэн: Франц (\$1.9 тэрбум доллар), Герман (\$1.4 тэрбум доллар), Нидерланд (\$1.4 тэрбум доллар), Английн Нэгдсэн Вант улс (\$1.2 тэрбум доллар), Дэлхийн банкны Олон улсын хөгжлийн нийгэмлэг (IDA, \$1.0 тэрбум доллар). Харин суурь боловсролд зориулсан нийт тусламжийн тэн хагасыг Нидерланд, Английн Нэгдсэн Вант улс, Дэлхийн банкны Олон улсын хөгжлийн нийгэмлэг (IDA) зэрэг гуравхан хандивлагч бүрдүүлсэн. Нидерланд нь суурь боловсролд хамгийн их тусламж үзүүлсэн хандивлагч болж байна. Энэ нь \$1.1 тэрбум доллар ба дэлхийн хэмжээний нийт тусламжийн бараг ¼ -хувийг эзэлж байна. Эдгээр 3 хандивлагч нь доогуур орлоготой улс орнуудын суурь боловсролд зориулах тусламжийн 60%-ийг бүрдүүлсэн байна. Харин Франц боловсролд олгосон нийт тусламжийнхаа дөнгөж 17%, Герман зөвхөн 11%-ийг суурь боловсролд хандивласан байна. Тэд тусламжийнхаа ихэнх хувийг их, дээд боловсролд зориулсан байна. Эдгээр орон болоод Япон улс тусламж хамгийн их шаардлагатай байдаг доогуур орлоготой орнуудын суурь боловсролд төдийлөн анхаарахгүй байна (График 11 нь 2005-2006 оны жилийн дундаж үзүүлэлтийг харуулж байна).

Хэдийгээр 2006 онд хоёр талын хандивлагч нарын дийлэнх нь боловсролд зориулах нийт тусламжийнхаа хэмжээг өсгөсөн боловч 21 хандивлагчдын зөвхөн 7 нь суурь боловсролд үзүүлэх тусламжаа тодорхой хэмжээнд нэмэгдүүлсэн байна. Цөөн тооны хандивлагч тусламжаа нилээд хэмжээгээр нэмэгдүүлсэн ч, энэ нь 2005 онд боловсролын салбар дахь уналт, доройтлыг зогсооход төдийлөн хүрэлцээтэй биш байсан. Суурь боловсролд үзүүлэх тусламжийн хэмжээ хэдхэн тооны хандивлагчдаас бүрдэж байгаа нь Дакарт амласан үүрэг, амлалтаа биелүүлэхэд бүх хандивлагчид хэр зэрэг бэлэн байна вэ гэсэн асуулт тавихад хүргэж байна.

Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (OECD)-ын Хөгжлийн Тусламжийн Хороо (DAC)-нд нэгдэн ороогүй хоёр талын хандивлагчид хөгжиж буй орнуудын боловсролын салбарт мөн дэмжлэг, туслалцаа үзүүлж байна. Бага, дунд боловсролын чанарыг сайжруулах үүднээс Хьюлетт, Гейтс зэрэг хувийн сангууд мөн \$ 60 сая хүртэлх ам.

График 11. Доогуур орлоготой улс орнуудын суурь боловсролд гол хандивлагчдын үзүүлсэн тусламжийн хэмжээ, 2005-2006 онуудын дунджаар



Эх сурвалж: 2009 оны БНБ-ын Хяналт үнэлгээний Дэлхийн Тайлангийн График 4.13-аас авсан тоо баримт.

Суурь боловсролд үзүүлэх тусламжийн хэмжээ хэдхэн тооны хандивлагчдаас бүрдэж байгаа нь Дакарт амласан үүрэг, амлалтаа биелүүлэхэд бүх хандивлагчид хэр зэрэг бэлэн байна вэ гэсэн асуулт тавихад хүргэж байна.

долларын тусламжийг суурь боловсролд хандивласан байна. Дубайн Халамжийн Сан нь ЮНИСЕФ, Хүүхдийг Ивээх Сан гэх мэт байгууллагуудтай хамтран хүүхдүүдэд боловсрол олгоход зориулан тусламжийн хэмжээг \$1 тэрбум ам.долларт хүргэсэн байна.

Үр Дүнд Түргэн Хүрэх Санаачлага (ҮДТХС): зорьсондоо хүрэхгүй байна

ҮДТХС-ын Каталик сан нь доогуур орлоготой зарим орнуудын санхүүгийн чухал эх үүсвэр болоод байгаа хэдий ч санхүүгийн боломжоо бүрэн дайчилж чадахгүй байгаагаас санхүүгийн ноцтой хомсдолд ороод байна. 2004-2011 оны хооронд 17 хандивлагч \$1.3 тэрбум долларыг хандивлахаар амлалт өгсөн хэдий ч ихэнх хувийг нь Нидерланд, Английн Нэгдсэн Вант улс, Европын Холбоо, Испани орнууд бүрдүүлж байна. Амласан нийт тусламжаас зөвхөн \$329 сая долларын гэрээ хийгдээд байгаа ба 2008 оны хоёрдугаар сарын сүүлийн байдлаар улс орнууд дөнгөж \$270 сая долларын тусламжийг хүлээж авсан байдалтай байна⁷. Тусламжийн дийлэнх хувь нь зөвхөн 5 оронд хуваарилагдсан ба бусад 13 орны хувьд \$10 саяас илүүгүй хэмжээний тусламж авчээ.

Өнөөгийн явц, хандлага хэвээр үргэлжилбэл урьдчилж төлөвлөсөн хэрэгцээ, шаардлагыг хангаж чадахааргүй байна. ҮДТХС-д нэгдсэн 35 орноос 8 орныг авч үзэхэд төлөвлөгөөгөөр батлагдсан тусламжийн \$1 тэрбум долларын дутагдалд ороод байна. 2010 он гэхэд ҮДТХС-д нэгдсэн бусад 13 орны хувьд энэ хэмжээ \$2.2 тэрбум болтлоо өсөх хандлагатай байна. Урьдчилсан таамаглалаар санхүүгийн хомсдолын 40-50%-ийг нь Каталик Сан нөхөн барагдуулна гэж үзвэл цаана нь 1 тэрбум орчим доллар шаардлагатай байгаа юм. Хэрвээ энэ урьдчилсан таамаглал зөв болж таарвал тусламж авч байгаа зарим орнуудад тусламжийн урсгал зогсож, мөн бусад орон ямар ч тусламж авч чадахгүйд хүрч болох юм.

Удирдлага ба тусламжийн үр шим

Тусламж хэрхэн хүрч байгаа нь хэр их тусламж үзүүлж байгаагаас илүү чухал асуудал юм. Урьдчилж хараагүй тусламж, хандивлагчдын тооны замбараагүй өсөлт, болон муу зохицуулалт зэрэг нь тусламж авагч орнууд болон хандивлагчдыг залхааж байна. Эдгээр нь бэрхшээлийн нэг хэсэг болж байгааг ухамсарласнаар хандивлагчид болон хүлээн авч буй орнууд хамтран 2005 оны Тусламжийн үр шимийн талаарх Парисын Тунхаглалд тусламжийг зохицуулах шинэ бодлого, зарчмуудыг батласан билээ. Тусламжийг зохицуулахдаа түүнийг тусламж авч буй орны эрх мэдэлд өгөх, нэг бодлогод зангидах, нийцүүлэн зохицуулах зэрэг арга хандлагыг үндсэн зарчмаа болгосон энэхүү үзэл баримтлалын дагуу Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын Хөгжлийн Тусламжийн Хороо (DAC)-ны гишүүд үндэсний байгууллага, санхүүгийн тогтолцоог нь ашиглан тусламжийг урьдчилан харж, тооцоолох болон хандивлагчдаас зохицуулахад гарч байгаа урсгал үргүй зардлыг бууруулахад анхаарлаа хандуулахаар тохиролцсон юм.

Үйл ажиллагааны бүхий л чиглэлүүдийн явц, үр дүн харилцан адилгүй байна. OECD-гийн саяхны хийсэн судалгаанаар тусламж олгох харилцааны асуудал нь шийдвэрлэх ноцтой хэвээр байгаа нь тодорхой харагдаж байна.

Тусламжийн удирдлагыг сайжруулах 4 түлхүүр

Энэхүү тайланд тусламжийн удирдлагын шинэчлэлийн 4 хүрээг болон боловсролын тусламжид үзүүлж байгаа тэдгээрийн нөлөөний талаар авч үзнэ.

Бие даасан салангид төслүүдээс салбар, тогтолцоог бүхэлд нь хамарсан хөтөлбөрүүдэд шилжих нь. Хандивлагч нар салбарыг бүхэлд нь хамарсан хөтөлбөрүүдэд дэмжлэг, туслалцаа үзүүлж, хамтран ажиллаж байгаа газарт тухайн улс орны үндэсний өмчлөх эрх мэдлийг бэхжүүлж, үр дүнг нь яг шаардлагатай

7. Гана, Йемен, Кени, Мадагаскар болон Никарагуа.

газруудад хүргэдэг ач холбогдолтой гэж үзэж байна.

Парисын Тунхаглалын зорилго нь 2010 он гэхэд нийт санхүүгийн тусламжийн 2/3-ыг хамтарсан тусламж хэлбэрээр бүрдүүлж, салбарыг бүхэлд нь хамарсан аргаар хэрэгжүүлэх явдал юм. Боловсролын салбар дахь хөтөлбөрт-суурилсан тусламж нь 1999- 2000 онуудад 33% байснаа 2005-2006 онуудад 54% хүртэл өссөн. Энэ өөрчлөлт доогуур орлоготой, тусламжаас хараат улс орнуудад илүү мэдрэгдэж байна. Бусад бүлгийн улс орнуудад төдийлөн өөрчлөлт гарсангүй: дунд орлоготой улс орнууд хандивлагч нартай тусдаа гэрээ хийхийг эрмэлзэж байхад ядуу буурай, эмзэг улс орны засгийн газруудад ихэнхдээ ийм өөрчлөлт хийх төрийн чадавхи дутагдаж байна.

Буркина Фасо, Этиоп, Энэтхэг, Балба, Уганда, Танзаны Нэгдсэн БНУ, Замби зэрэг хэд хэдэн орон сургуульд хамрагдалтыг ихээр нэмэгдүүлсэн зэрэг боловсрол дахь Салбар дамнасан арга хандлага (SWAp)-ын хүрээнд ололт амжилт их олон гарсан. Тэгсэн ч гэсэн гол гол бэрхшээлүүд хэвээр байгаа бөгөөд ийм арга хандлагыг тууштай хэрэгжүүлж чадахгүй байна. SWAp-ийг амжилттай хэрэгжүүлэх нь улс төрийн хүчтэй бодлого, удирдлага болон засгийн газрын хүчин чадавхитай байгууллагуудаас хамаарч байна.

Үндэсний эрх мэдэл, үүрэг хариуцлага. Үндэсний эрх мэдэл, үүрэг, хариуцлага бэхжих нь үндэсний засгийн газрууд болон хандивлагчдын хоорондын хоёр талын хамтын ажиллагаан дээр суурилдаг. Онолын хувьд, засгийн газрууд үндэсний хөгжлийн стратеги боловсруулж, хэрэгжүүлэх явцыг удирдан зохицуулж байхад, хандивлагч нар тухайн орны удирдлагыг хүндэтгэн үзэж, чадавхийг нь бэхжүүлж байдаг. Гэвч бодит байдал дээр бол Энэтхэг, Мозамбекийн туршлагаас үзэхэд засгийн газрын удирдлагуудын нөхцөл байдал янз бүр байна. Энэтхэг улс нь гадны тусламжаас бага хамааралтай, засгийн газрын өндөр чадавхитай, хөгжлийн чадавхи бүхий үндэсний хүчирхэг

байгууллагуудтай бөгөөд бүх нийтийн бага боловсролыг хангах тухайд тэргүүлэх чиглэлээ нарийн тодорхойлох, үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар хатуу хянан ажиллаж байна. Харин Мозамбек иргэний дайны хор уршгийн улмаас удирдлага, захиргаа нь сул, түүнийг удирдан явуулах хүчин чадавхи дутагдалтай байна. Ийнхүү Мозамбекийн засгийн газар боловсролын салбарт Салбар дамнасан хандлагыг боловсруулахад 3 жил гаруй зарцуулсан бөгөөд засгийн газар болон хандивлагч нар зөвшилцөлд хүрэх арга зам олох шалгалт болсон юм. Ийнхүү хоёр тал сэтгэл дундуур, бухимдалтай байсан хэдий ч SWAp-ын ачаар боловсролын салбарын үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд Мозамбекийн засгийн газрын хариуцлага, чадавхийг нэмэгдүүлж чадсан билээ.

Тусламжийг үндэсний бодлогын тэргүүлэх чиглэлд нийцүүлэх ба засгийн газрын тогтолцоог ашиглах. Тусламжийн шинэ бодлого, хөтөлбөрт тухайн улс орны тэргүүлэх чиглэл болон тогтолцоонд нийцүүлэн тохируулж тусламж олгохыг хандивлагч нарт уриалжээ. Хэдийгээр энэ нь тийм хялбар биш ч, боловсролын салбарын төлөвлөгөө болон үндэсний менежментийн тогтолцоонд нийцүүлэн тусламж олгох нь эерэг үр дүнд хүргэнэ. Үүнд салбарын үйл ажиллагааны уялдаа холбоог бэхжүүлж, хандивлагчдын үйл ажиллагаа, тэрчлэн үндсэн болон урсгал зардлын тусламжийн улам их болж байгаа санхүүгийн уян хатан байдлын хяналтыг дээшлүүлэх зэргийг дурьдаж болно. Камбожид 2001 онд Боловсролын Стратегийн Төлөвлөгөөг хэрэгжүүлж эхэлсэн нь засгийн газар болон хандивлагчдын илүү ойр нягт хамтын ажиллагааны эхлэл болсон юм. Энэ төлөвлөгөө нь салбарын үйл ажиллагааны уялдаа холбоог бэхжүүлэхэд удирдамж болж, хандивлагчдын үйл ажиллагааны талаарх боловсролын сайд нарын мэдлэгийг дээшлүүл, хандах хандлага, нөлөөг нь мөн сайжруулсан.

Буркина Фасод засгийн газрын удирдлагын бүтцээр дамжуулан шаардлагатай тусламжийг олгож байгаа нь Суурь

Боловсролын салбарын төлөвлөгөө болон үндэсний менежментийн тогтолцоонд нийцүүлэн тусламж олгох нь эерэг үр дүнд хүргэнэ.

Боловсролын Яамнаас илүү үр дүнтэй төсөв, санхүүгийн тайлан хүлээн авах, төсвийг илүү оновчтой төлөвлөх, тусламжийг илүү сайн урьдчилан тооцоолоход нөлөөлсний хамт нөөц сан бүрдүүлэх нийтлэг журмыг зөвшөөрсөн хандивлагчдын тоог нэмэгдүүлэхэд сайнаар нөлөөлсөн. Үндэсний чадавхийг юуны өмнө бэхжүүлэхийн тулд Канад, Нидерланд, Английн Нэгдсэн Вант улс зэрэг зарим хандивлагч орон үндэсний чадавхи хангалтгүй байгааг хүлээн зөвшөөрч байгаа хэдий ч үндэсний тогтолцоогоор дамжуулан тусламжийг хүргэх нь зүйтэй гэж үзэж байна. Австрали, Португал, АНУ зэрэг бусад улс орнууд үндэсний тогтолцооны үйл ажиллагаа сайжиртал хүлээхийг эрхэмлэж байна.

Тусламжийг үр ашигтай зарцуулахын тулд улс орнууд хэр хэмжээний тусламж, хэдийд хүлээн авах вэ гэдгийг мэдэж байх шаардлагатай. Тусламжийг урьдчилан төлөвлөх үйл явц төвөг бэрхшээлтэй. Салбар дамнасан төсвийг дэмжсэн тусламж олгох нь дунд болон урт хугацааны дэмжлэгийг урьдчилан харж олгох хандлагыг хэрэгжүүлэхэд бэрхшээл учруулж байгаа бөгөөд богино хугацаанд урьдчилан тооцоолж, тусламж олгох арга хэндлага одоогоор давамгайлж байна. Энэ нь нэг талаас хөгжиж буй орнуудын удирдлагын сул, дорой байдал, нөгөө талаас хандивлагчдын тааруу үйл ажиллагаатай холбоотой. Европын Комиссын МХЗ-ын гэрээ хэлэлцээр, АНУ-ын МСС зэрэг өнөөгийн санаачлага, үйл ажиллагаа нь олон жилийн үүрэг, амлалтыг хэрэгжүүлэх замаар эдгээр асуудлуудыг шийдвэрлэхэд чиглэгдэж байна.

Хандивлагчид хоорондын зохицуулалтыг сайжруулах нь. Парисийн Тунхаглалд үр ашиггүй байдал болон үйл ажиллагааны завсрын зардлыг бууруулахад чиглэсэн хандивлагчид хоорондын зохицуулалтыг сайжруулах үндсэн үйл ажиллагаануудыг хүлээн зөвшөөрсөн.

- **Хамтарсан албан томилолтуудыг нэмэгдүүлэх.** Улс орнуудад хандивлагчид бүлгээрээ буюу хамтарсан

албан томилолтоор ажиллах тохиолдолд үйл ажиллагааны урсгал зардлыг бууруулж, тухайн засгийн газрийн ажилчид илүү үр бүтээлтэй ажиллах боломж хангадаг. 2007 онд бүх хандивлагчдын албан томилолтын зөвхөн 20%-ийг хамтарсан байдлаар хийсэн нь төлөвлөж байсан 40%-ийн хаана ч хүрэхгүй байна. Тэгсэн хэдий ч бусад салбарыг бодвол боловсролын салбарт ахиц гарч байгаа нь мэдрэгдэж байна. Жишээ нь, Гондурас гэхэд 2007 онд боловсролын бүх хандивлагчдын хийсэн албан томилолтын 73% нь хамтарсан томилолтууд байлаа.

- **Хандивлагчдын бүлэг байгуулах.** Олон оронд боловсролын салбарт тэргүүлэх үүрэг бүхий хандивлагчдаас хандивлагчдын бүлгийг бүрдүүлж байгуулдаг. ҮДТХС-ын Каталик сангаас тусламж авдаг орнуудын нэгээс бусад нь бүгд ийм бүлэг байгуулсан. Тийм ч гэлээ хандивлагчид нэг нэгнээсээ ялгаатай, бүгд нэг хурдаар ажилладаггүй. Жишээ нь: Нидерланд, Нэгдсэн Вант Улс болон зарим Скандинавын орнууд нь өөрийн ажил, үүргийг бусадтай нийцүүлэн хамтран ажиллахыг зорьж байхад АНУ болон Япон зэрэг улс орнууд зэрэгцээ бүтцээр ажиллахыг илүү эрхэмлэж байна.
- **Тусламжийг зөв зохистой хүргэх.** Олон тооны хандивлагч нар бага хэмжээний тусламж үзүүлэх нь үйл ажиллагааны урсгал зардал өндөр болж, үр бүтээмж муутай болдог. Гэтэл цөөн улс орнуудад их хэмжээний тусламжийг төвлөрүүлэх гэсэн хандивлагчдын хүчин зүтгэл одоогоор бэрхшээлтэй хязгаарлагдмал байна. 2005-2006 онуудад суурь боловсролд зориулж 18 орон тус бүр доод тал нь 12 хандивлагчидтай хамтран ажиллах шаардлагатай байсан. 2002- 2006 оны хооронд ихэнх хандивлагч нар суурь боловсролд зориулах тусламжийнхаа хэмжээг нэмэгдүүлэхийн хэрээр санхүүжигч орнуудын тоог мөн нэмэгдүүлсэн байна. Австри, Грек,

Ирланд, Япон болон Испани зэрэг зарим хандивлагчид тусламжийн хэмжээний өсөлтийн түвшингээс санхүүжигч орнуудын тоог илүү хурдан нэмэгдүүлсэн нь мэдээж, нэг улсад ногдох тусламжийн хэмжээг бууруулсан байна. Нидерланд, Английн Нэгдсэн Вант улс зэрэг орнууд харин бүр эсрэгээрээ санхүүжигч орнуудынхаа тоог бууруулах замаар суурь боловсролд үзүүлэх тусламжийнхаа хэмжээг хоёр дахин нэмэгдүүлсэн байна.

Тусламжаар дамжуулан удирдлагыг сайжруулах нь

Хандивлагч орнуудын өнөөгийн чиг хандлагуудад суурилан тухайн орны боловсролын салбар дахь зөв сайн удирдлагыг төлөвшүүлэх чиглэл, зорилгыг тодорхойлохыг оролдож байгаа нь хандивлагч нарыг өөрсдийг нь эрсдэлд оруулж байна.

Хандивлагчид удирдлагыг сайжруулахад чиглэсэн хөрөнгө оруулалтыг түлхүү оруулдаг. Тусламжийн хөтөлбөрийн хүрээнд удирдлагын асуудлын ач холбогдол нэмэгдэж байгаа нь түүнд зарцуулсан санхүүгийн хэмжээнээс харагдаж байна. 2006 онд хандивлагч нар боловсролын салбарын нийт тусламжийн 9%-ийг «удирдлага ба иргэний нийгэм»-д хувиарласан нь салбарын үйл ажиллагааны бусад чиглэлүүдэд зориулсан хэмжээнээс хамгийн өндөр нь байна. 2006 ба 2007 онуудад зарим гол хандивлагчид удирдлагын талаар шинэ стратеги баталсан. Ялангуяа, Дэлхийн банк болон Европын Комисс өөрсдийн тусламжийн хөтөлбөрүүдээр дамжуулан удирдлагыг сайжруулахад идэвхитэй ажиллаж байна. Тэд төрийн санхүүгийн менежмент, төвлөрлийг сааруулах, ил тод байдал, хариуцлага тооцоо болон төрийн ажил эрхлэлт зэрэг үйл ажиллагаануудад анхаарч дэмжлэг үзүүлж байна. Түүнчлэн хандивлагч нар улс орны удирдлагын зохицуулалтын дүрэм, журмын статусын байдлыг үнэлэн дүгнэх оролдого хийж байна. Үүний жишээ нь зарим оронд Английн Нэгдсэн Вант улсын олон улсын хөгжлийн газраас боловсруулан гаргасан Улс орны удирдлагын дүн шинжилгээний арга зүйг ашиглаж байна.

Хандивлагч орнууд удирдлагын асуудалд илүү анхаарах болсон нь тусламж авагч орнуудын боловсролын салбарын бодлого,

хөтөлбөрт нөлөөлөх үү? Дэлхийн банкны өнөөгийн боловсролын төсөл болон суурь боловсролын хөтөлбөрүүдээс үзэхэд удирдлагын үйл ажиллагааг эрчимжүүлэх сонирхол өсөж байгаа нь харагдаж байна. Цөөн хэдийг дурьдвал, удирдлага нь сургуулийн үйл ажиллагаанд нийгмийн идэвхитэй оролцоог хангах (Гондурас), багшийн хангамж, хувиарлалт, хяналт шинжилгээ (Индонези), сургуульд суурилсан менежмент (Филлипин) зэрэг асуудлуудад холбоотой байна. Салбар дамнасан хандлага, арга барил (SWAp) Бангладеш, Кени, Пакистан зэрэг орнуудад удирдлагад чиглэсэн идэвхитэй санаачлага, үйл ажиллагааг дэмжин хэрэгжүүлж байна. Тэдний зарим нь багш нар, нийгмийн өргөн оролцоо ба хувийн хэвшлийнхний оролцоог дэмжихэд онцгой анхаарч байна.

Ядуу буурай улс орнуудад юу хамгийн чухал, юу хамаатай вэ гэдгийг тооцоолж харгалзан үзэхгүйгээр зөвхөн хандивлагч орнуудын өнөөгийн чиг хандлагуудад суурилан тухайн орны боловсролын салбар дахь зөв сайн удирдлагыг төлөвшүүлэх чиглэл, зорилгыг тодорхойлохыг оролдож байгаа нь хандивлагч нарыг өөрсдийг нь эрсдэлд оруулж байна. Зөв сайн удирдлага боловсролын салбарт тэргүүлэх чиглэл нь байх ёстой хэдий ч тухайн оронд тийм удирдлага яаж, юунаас тогтож, ямар байхыг хандивлагчид дангаараа мэдэж зохицуулах боломжгүй юм.

Ерөнхийд нь дүгнэвэл, боловсролд болон суурь боловсролд үзүүлэх тусламжийн түвшин зогсонги байдалд орсон ийм нөхцөлд БНБ-ын зорилгуудыг биелүүлэхэд санхүүгийн дутагдал байсаар байх ба зорилгодоо хүрэх нь эргэлзээтэй байна. Магадгүй хандивлагч нар болон улс орнууд удирдлагын тусламжийг сайжруулах арга замыг олсон байж болох ч дэвшил нь удаан байна. Нийт тусламжийг нэмэгдүүлэх болон түүнийг илүү үр бүтээлтэй зарцуулахад чиглэсэн дэлхийн улс орнуудын хүчин зүтгэл, чармайлтыг бэхжүүлэхгүйгээр БНБ-ын зорилгуудыг хэрэгжүүлэх явцыг түргэсгэх боломжгүй юм.

БҮЛЭГ 5.

Бодлогын шинжтэй дүгнэлтүүд болон зөвлөмжүүд

Дакарын үйл ажиллагааны хүрээнд дэвшүүлсэн зорилтуудыг хэрэгжүүлэхэд удирдлагын бүх түвшинд улс төрийн хүчтэй манлайлал болон өөрчлөлт, шинэчлэлтийг шаардаж байна. Сургуулийн

өмнөх боловсролын нөхцөл боломжийг дээшлүүлэх, олон арван сая хүүхдүүдийг сургуульд хамран сургах, сургалтын стандартыг сайжруулах, мөн залуучууд, насанд хүрэгчдийн сурах боломжийг нэмэгдүүлэх зэрэг нь Засгийн газруудын олон зорилтуудын зөвхөн зарим хэсэг нь юм. Удирдлагын шинэчлэл нь хөгжил, дэвшилд хүргэх чухал ач холбогдолтой.

Тайланд БНБ-ын зорилтуудад хүрэхийн тулд хяналт үнэлгээ болон удирдлагын шинэчлэлийг сайжруулан хэрэгжүүлсэн тухай туршлага, үйл ажиллагааг авч үзсэн. Сүүлийн энэ бүлэгт ерөнхий дүгнэлт болон бодлогын шинжтэй зөвлөмжүүдийг оруулсан болно.

БНБ-ын зорилтуудад хүрэх явц

БНБ-ын зорилтуудыг хэрэгжүүлэх явцад хяналт үнэлгээ хийж үзэхэд үр дүн янз бүр байна. Дэлхийн ядуу буурай зарим улс орнууд сургуульд хамралтыг нэмэгдүүлэх, бүх нийтээр бага боловсролд хүрэх, хүйсийн тэгш бус байдлыг бууруулах зэрэг зорилтуудыг хэрэгжүүлэхэд гайхалтай амжилтанд хүрч чаджээ. Ийнхүү ололт, амжилт гарч байгаа хэдий ч Дакарын үйл ажиллагааны үүрэг, зорилтонд хүрэх ерөнхий явц байдал хэтэрхий удаан бөгөөд жигд бус байна.

Тэгш бус байдлын түвшин өндөр байгаагаас боловсролын явц болон хөгжлийн өргөн хүрээний зорилтуудын

Боловсролд хүрэх урт зам: Сургуульдаа очихоор цөлөөр алхаж байгаа нь, Йемен.



биелэлт удааширч байна. Хэрвээ засгийн газрууд БНБ-ын зорилтуудыг тэргүүлэх чиглэлээ болгон анхаарч байгаа бол тэд бүх нийтэд адил тэгш, хүртээмжтэй боловсролыг олгохын төлөө бүхий л хүчин чармайлтаа дайчлан ажиллах ёстой. Энэхүү Тайланд нэн тэргүүнд шийдвэрлэх шаардлагатай зорилт, чиглэлүүдийг онцгойлон авч үзсэн болно.

Бага насны хүүхдийн халамж, хүмүүжил, боловсрол

Бага насны хүүхдийн халамж, хүмүүжил, боловсролын өнөөгийн байдалд таагүй үр дүн харагдаж байгаагаас гадна улс орнуудын түвшинд төдийгүй тухайн улс орны дотор ч эрс ялгаатай байгаа нь боловсролын салбарын хөгжлийг бүхэлд нь сааруулж байна. Энэхүү Тайланд засгийн газрууд болон хандивлагчдыг дор дурьдсан арга хэмжээ авахыг шаардаж байна.

- Эрүүл мэндийн салбарын үндсэн үйл ажиллагаануудад мөнгөн тусламж үзүүлэх болон эрүүлийг хамгаалах салбаруудын хөтөлбөр, үйл ажиллагаануудад төрөөс тэгш шудрагаар санхүүжилт олгох замаар боловсролын төлөвлөлт болон хүүхдийн эрүүл мэндийн салбар хоорондын **уялдаа холбоог бэхжүүлэх**.
- Хүүхэд бүрийн төлөвлөлтийн асуудалд **бага насны хүүхдийн халамж, хүмүүжил, боловсролыг онцгойлон анхаарах**, ингэхдээ эмзэг бүлгийн хүүхдүүдэд илүү түлхүү анхаарах.
- Хүүхдийн хүнс тэжээлийн хомсдлыг бууруулах, эрүүл мэндийн тогтолцоог боловсронгуй болгох зэрэг асуудлуудыг шийдвэрлэж, улмаар эмзэг, ядуу гэр бүлд чиглэсэн нийгэм халамжийн шинэлэг хөтөлбөрүүдийг авч хэрэгжүүлэх замаар **ядуурлын эсрэг тууштай тэмцэхийг** уриалсан юм.

Бүх нийтийн бага боловсрол

Улс төрийн манлайлал нь бүх нийтээр бага боловсролд хүрэх явцыг идэвхжүүлэгч хүч юм. Энэхүү Тайланд нэлээд амжилттай тууштай ажиллаж байгаа улс орнуудын үйл ажиллагаанаас 3 чиглэлээр өргөн хүрээний туршлага, сургамжуудыг нэгтгэн толилуулж байна.

- Хүүхэд бүр бага сургуульд хамрагдан суралцаж, түүнийг төгсөж байх явдлыг хангах талаар ахиц дэвшил гаргахын тулд бодитой төлөвлөлт, дунд болон урт хугацааны санхүүгийн хүрэлцэхүйц хуваарилалт хийх замаар **үр дүнтэй, урт хугацааны зорилтуудыг дэвшүүлэн тавьж** ажиллах,
- Боловсролын адил тэгш байдлыг дэмжиж чадах бодитой бодлого, стратегид тулгуурлан ялгаатай байдлыг бууруулахад чиглэсэн тодорхой зорилтуудыг дэвшүүлэн хэрэгжүүлэх замаар охидууд, эмзэг бүлгийнхэн болон хангамж үйлчилгээний хүрэлцээ муу хүрдэг нутгуудад **тэгш байдлыг дэмжих**. Бодитой бодлого, стратегит сургалтыг төлбөрөөс чөлөөлөх болон нэн шаардлагатай байгаа салбар, чиглэлүүдэд улсын төсвийг нэмэгдүүлэх зэргийг оруулж байна.
- Суралцагчдын тасралтгүй анги дэвшин суралцах явдалд анхаарч, сурлагын амжилтыг дээшлүүлэх, сурах бичгийн хангамж, чанарыг сайжруулах, багш нарыг сургаж, бэлтгэх, тэдэнд дэмжлэг туслалцаа үзүүлэх, сургалт явуулахад тохирсон сурагчдын тоо бүхий ангиудыг бүрдүүлэх зэргээр **боловсролын чанарыг дээшлүүлэхийн зэрэгцээ түүнд хүрэх боломжийг нэмэгдүүлж байх нь зүйтэй гэдгийг тэмдэглэж болох** байна.

Боловсролын чанар

Сургалтын доголдол, дутагдлыг засч залруулах, нийгмийн байдал болон оршин

суугаа газраас үл хамааран бүх хүүхэд өөрийн чадавхи, боломжоо бүх талаар дайчлан ашиглахад шаардлагатай мэдлэг, чадварыг эзэмшиж, сургуулиа төгсдөг байх явдлыг баталгаажуулахын тулд үндэсний эрх бүхий байгууллагууд, хамт олны төлөөллүүд болон сургуулийн удирдлагууд хамтран ажиллах шаардлагатай. Тайланд энэ талаар үйл ажиллагааны 5 гол хүрээ чиглэлийг гарган тавьж байна.

- Шаардлагатай дэд бүтэц, сайтар бэлтгэгдсэн багш, тохирсон сургалтын хөтөлбөр, тов тодорхой сурлагын үнэлгээ зэрэг бүх сурагчдад үр ашигтай байхуйц сургалтын орчинг бүрдүүлж, боловсролын чанарыг дээшлүүлэх талаар **төрийн бодлогын үүрэг хариуцлагыг хүчтэй болгох**. Багш болон сургалтанд голлон анхаарах нь энэ бодлогын гол цөм нь байх ёстой.
- Бага сургуульд бүх хүүхэд доод тал нь 4-5 жил суралцаж, өөрсдийн чадамж, боломжоо цааш хөгжүүлэхэд зайлшгүй шаардагдах **бичиг үсгийн болон тоо бодох суурь мэдлэг олж авч байх явдлыг хангах**.
- Сургалтын нөхцөл (дэд бүтэц, сурах бичиг, анги дүүргэлт), явц (хэл, хичээлийн цаг), үр дүн болон бүс нутаг, бүлэг хамт олон, сургуулиудын өөр хоорондын ялгаа зэргийг оруулаад **боловсролын чанарыг шалгах, хянаж үнэлэх, дүгнэх чадавхийг нэмэгдүүлэн хөгжүүлэх**.
- **Хүүхдүүд хангалттай цагаар хичээллэж байх**, төлөвлөсөн болон бодит хичээлийн цагийн хоорондох зөрүүг аль болох бага байлгах явдлыг хангах зорилгоор мөрдөж байгаа бодлого, дүрэм журмыг эргэн авч үзэж, нягтлах.
- Бүсийн болон олон улсын харьцуулсан **сурлагын амжилтын үнэлгээнд** хамрагдаж, гарсан үр дүнг үндэсний бодлогодоо тусгах: улс орныхоо

тодорхой хэрэгцээ, шаардлага, зорилгыг хамгийн бодитой тусгасан үндэсний үнэлгээний тогтолцоог боловсруулах.

Тэгш бус байдлыг арилгах- үндэсний удирдлагын шинэчлэлийн талаар гарсан сургамж, туршлагууд

Боловсролын салбарын зөв зохистой удирдлага нь БНБ-ын зорилтод хүрэхэд сурагчдын сурлагын амжилтыг дээшлүүлэх болон адил тэгш боломжоор хангах гол түлхүүр юм. Гэвч олон оронд удирдлагын шинэчлэлд үндсэн хоёр дутагдал байна. Үүнд: тэгш бус байдлыг арилгахад төдийлөн анхаарахгүй байна. Мөн загварчлах хандлага их гарч байгаа бөгөөд тухайлбал, төрийн салбарын асуудлуудыг шийдвэрлэхийн тулд хувийн сургуулийг байгуулж ажиллуулахдаа загварчлан урсгалаар хандах явдал гарч байна. Боловсролын салбарын удирдлагад шинэ хандлагуудыг гаргаж ирэх шаардлагатай байна. Засгийн газрын зохих үйл ажиллагаа, оролцоо шаардлагатай байгаа хүрээ чиглэлүүдийг энд толилуулж байна.

- Амьдралын түвшин, оршин суугаа газар нутаг, хүйс болон бусад хүчин зүйлээс үүдэлтэй **тэгш бус байдлыг арилгахад үйл ажиллагаагаа хандуулах**. Засгийн газрууд тэгш бус байдлыг арилгах талаар тодорхой зорилго тавьж, түүнийг хэрэгжүүлэх явцад хяналт тавьж байх ёстой.
- Бодлогын тодорхой зорилгууд болон төрийн ба төрийн бус байгууллагууд (иргэний нийгэм, хувийн хэвшил, эмзэг бүлэг)-ын үйл ажиллагааны зохицуулалтыг сайжруулах замаар боловсролын нэн тэргүүний зорилтуудыг хэрэгжүүлэх болон тэгш бус байдлыг арилгахад **улс төрийн удирдах манлайлалыг нэмэгдүүлж тууштай байлгах**.

Боловсролын салбарын зөв зохистой удирдлага нь БНБ-ын зорилтод хүрэхэд сурагчдын сурлагын амжилтыг дээшлүүлэх болон адил тэгш боломжоор хангах гол түлхүүр юм.

- БНБ-д хүрэх зорилтод саад учруулж байгаа **ядуурал болон нийгэмд амь бөхтэй байгаа тэгш бус байдлыг бууруулахад чиглэгдсэн бодлогыг тууштай баримтлах.** Засгийн газрууд тухайн улс орныхоо боловсролын төлөвлөлтийг ядуурлыг бууруулах өргөн хүрээний бодлогод уялдуулан нэгтгэх хэрэгтэй байна.
- **Боловсролын чанарын стандартыг боловсронгуй болгож,** бүс нутаг, бүлэг хамт олон, сургуулиудын хоорондын сургалтын амжилтын ялгааг арилгахын төлөө ажиллах
- **Боловсролд зориулах үндэсний зардлыг нэмэгдүүлэх,** ялангуяа боловсролд хөрөнгө оруулалт бага хийдэг хөгжиж буй орнуудад энэ нь илүү хамаатай.
- Хүн амын нэн ядуу давхрагыг хамруулах зорилго тавин тэгш шудрагаар хуваарилах явдлыг дэмжих, ингэхдээ эмзэг бүлгийн хүүхдүүдэд ноогдох зардлыг нарийн тооцон хуваарилах замаар адил **тэгш шудрага байх асуудлыг санхүүжилтийн бодлогын төвд тавих.**
- Ядуурлын түвшин, боловсролын санхүүгийн хомсдолыг бууруулахад санхүүгийн эх үүсвэрийг гаргах тийм санхүүжүүлэх зарчмыг нэвтрүүлэх замаар жинхэнэ адил тэгш шудрага байдлын төлөө **төвлөрлийг сааруулах бодлогыг чиглүүлэх.**
- **Сургууль хоорондоо өрсөлдөх сургууль сонгох болон төрийн болон хувийн хэвшлийнхний түншлэл нь өөрийн доголдол дутагдалтай гэдгийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй.** Хэрвээ төрийн боловсролын тогтолцоо доголдож байвал түүнийг нэн даруй засч залруулах арга хэмжээ авах нь зүйтэй.
- Бүс нутаг болон сургууль бүрт, ялангуяа алслагдмал, хангамж

үйлчилгээ хомсдолтой орон нутагт мэргэшсэн багш нарыг бүрэн хангалттай ажиллуулахын тулд багш нарыг зөв хуваарилах, тэдний ажиллах хүсэл сонирхолыг татах талаар тууштай хүчтэй арга хэмжээ авах.

Хандивлагчид: авсан үүрэг, амлалтын хэрэгжилт

Хөгжиж буй орнуудын засгийн газрууд БНБ-ын зорилтод хүрэх гол үүрэг хариуцлагыг хүлээж байгаа. Санхүүгийн тусламж амлалтаа нэмэгдүүлэх, тусламж үзүүлэх арга замыг төгөлдөржүүлэх, энэ тусламж нь үндэсний хэмжээний нэн тэргүүний зорилтуудыг шийдвэрлэхэд зориулагдсан байх явдлыг хангах замаар хөгжингүй орнууд тэдэнд дэмжлэг тусалцаа үзүүлдэг. Тайланд зарим үндсэн хүрээ чиглэлүүдээр зөвлөж байна.

- БНБ-ын үндсэн чиглэлүүдийг хэрэгжүүлэхэд дутагдаж байгаа санхүүгийн хомсдлыг арилгахад ойролцоогоор \$7 тэрбум долларын тусламж үзүүлж, **суурь боловсролд зориулах тусламжийг нэмэгдүүлэх,** ялангуяа энэ нь бага орлоготой улс орнуудын хувьд бүр ч шаардлагатай.
- БНБ-ын зорилтуудыг хэрэгжүүлэхэд санхүүгийн тусламжийг тогтвортой байлгах үүднээс суурь боловсролд тусламж үзүүлэх **хандивлагч орнуудын тоог нэмэгдүүлэх.**
- Доогуур орлоготой орнуудын суурь боловсролд илүү санхүүжилт олгох замаар **боловсролын тусламжийн адил тэгш шудрага байдлыг хангах.** Франц, Герман зэрэг зарим хандивлагч орнууд тусламж үзүүлж байгаа арга хэлбэрээ яаралтай нягтлан үзэх шаардлагатай байна.
- **ҮДТХС-д дэмжлэг үзүүлж,** төлөвлөгөө нь батлагдсан улс орнуудын санхүүгийн хүлээгдэж буй хомсдлыг арилгах (Төлөвлөгөө нь батлагдсан эдгээр улс

орнуудад санхүүгийн энэ хомсдол 2010 он хүртэлх хугацаанд жил бүр \$ 2.2 тэрбум долларт хүрэхээр тооцоо гарч байна).

- Үндэсний хэмжээний нэн тэргүүний зорилтуудад нийцүүлэн тусламж олгох, илүү сайн зохицуулалт хийх, санхүүгийн удирдлагын үндэсний тогтолцоог өргөн ашиглах болон тусламжийн урсгалыг урьдчилан тооцоолох замаар Парисийн Тунхаглалд заасны дагуу **тусламжийн үр өгөөжийг нэмэгдүүлж**, үйл ажиллагааны урсгал зардлыг бууруулах

Төрийн бус байгууллагууд: тэдгээрийн үүрэг, оролцоо онцгой чухал

Тайланд боловсролын салбарт Засгийн газар болон төрийн бодлогын үүрэг рольд онцгой ач холбогдол өгч байна. Ингэснээр төрийн бус байгууллагуудын үүрэг, оролцоог үгүйсгэж байгаа хэрэг бишээ. БНБ-д хүрэхэд янз бүрийн түвшний байгууллагуудын хооронд тухайлбал, сургууль эцэг эхийн хооронд, иргэний нийгмийн байгууллагууд болон засгийн газрын байгуулла-

гуудын хооронд, төрийн болон төрийн бус боловсролын салбарынхны хоорондын хамтын ажиллагааг бэхжүүлэх шаардлагатай. Иргэний нийгмийн байгууллага, холбоод нь:

- БНБ-ыг түгээн дэлгэрүүлэх үйлсэд ядуучууд, хөдөлмөр эрхлэгч хүүхдүүд, доод давхрагын болон уугуул нутгийн хүмүүс зэрэг **гадуурхагдсан бүлгийн дуу хоолойг төлөөлөн хүргэж хүчтэй ажиллах.**
- Боловсролын үйлчилгээ үзүүлэх, чадавхийг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлж, байнга **тайлагнаж байх талаар Засгийн газарт шаардаж байх.**

Тэгш бус байдлыг арилгахад зөв сайн удирдлага нь төрийн бүхий л бодлогын зүрх нь болж байх ёстой. Хүүхэд бүрийн хэрэгцээ шаардлагад нийцсэн, ялангуяа боломж нөхцөлөөр ихээхэн дутмаг хүүхдүүдэд хандсан тэгш хүртээмжтэй, уян хатан боловсролын тогтолцоог хөгжүүлэх нь зайлшгүй чухал юм. Тэгш шудрага байдлыг дэмжихэд чиглэсэн боловсролын тогтолцоог бүрдүүлж, хэрэгжүүлэх нь 2015 онд дэлхий нийтээр БНБ-ын зорилтуудад хүрэхэд шийдвэрлэх ач холбогдолтой.

Хандив-лагчид суурь боловсролд үзүүлэх тусламжийн хэмжээг, ялангуяа доогуур орлоготой улс орнуудад нэмэгдүүлэх ёстой.

Тэгш бус байдлыг арилгах нь: Яагаад удирдлагын асуудал чухал вэ?

Боловсрол бол хүний үндсэн эрх. Дэлхий нийтэд хөрөнгө чинээ, хүйс, оршин суугаа газар нутаг, хэл яриа болон бусад ялгаатай хүчин зүйлүүдээс шалтгаалан боловсролын салбарт тэгш бус байдал өргөн хүрээнд байсаар байна. Ийм тэгш бус байдал нь 2000 онд 160 гаруй засгийн газар хүлээн зөвшөөрсөн БНБ-ын үндсэн 6 зорилтуудыг хэрэгжүүлэх хүчин чармайлтад саад тотгор учруулсаар байна. Тэгш шудрага байдлыг БНБ-ын хөтөлбөрийн цөм болгон хэрэгжүүлж чадахгүй байгаа нь сая сая хүүхэд, залуучууд, насанд хүрэгчдэд өөрсдийн чадавхийг бодитоор нээн ашиглах, ядуурахгүй байх ба нийгмийн үйл хэрэгт бүрэн оролцож байхад нь амин чухал сурч боловсрох боломжийг нь олгохгүй байна гэсэн хэрэг юм.

Энэхүү хэвлэл нь БНБ-ын Хяналт үнэлгээний Дэлхийн Тайлангийн долоо дахь хэвлэлийн Хураангуй бөгөөд БНБ-ын зорилтуудад хүрэх дэлхий нийтийн явц болон амжилтыг баримтжуулан танилцуулж байна. Ард үлдсэн амжилт бүтээл, бэрхшээлүүд дээр тулгуурлан Энэ Тайланд боловсролын удирдлагын шинэчлэлийн өнөөгийн хандлагуудыг судлан үзэж, тэдгээр нь боловсролын чанар, хүртээмж, оролцоо, хариуцлагыг дээшлүүлэхэд хувь нэмэр оруулж байгаа эсэхэд дүгнэлт хийн таниулахыг зорьсон юм. Түүнчлэн боловсролд үзүүлж буй тусламжийн удирдлагын асуудлыг анхаарч авч үзсэн болно. Баян чинээлэг орнууд аль ч улс орны боловсролын үндэсний стратеги зорилтууд санхүүжилтээс шалтгаалан хэрэгжихгүй байх явдлыг гаргахгүй байхыг баталгаажуулна гэж амлалт авсан. Гэвч энэ үүрэг амлалт хараахан хэрэгжихгүй байна.

Тайлангийн бүтэн хувилбар мөн боловсролын талаарх иж бүрэн статистик мэдээ, тоон үзүүлэлт, шалгуурууд болон өөр бусад хэл дээр байгаа тайлангийн хувилбар хэвлэлүүдийг www.efareport.unesco.org хаягаар авах боломжтой.



ЮНЕСКО-гийн
хэвлэл

